



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

БАГА БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН

ХӨТӨЛБӨР

Улаанбаатар

2019



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

БАГА БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН **ХӨТӨЛБӨР**

2019 он

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

АГУУЛГА

Бага ангийн сургалтын төлөвлөгөө	5
Бага боловсролын сургалтын хөтөлбөр	8
Монгол хэл.....	15
Математик	25
Хүн ба орчин.....	37
Хүн ба байгаль	45
Хүн ба нийгэм.....	53
Урлаг	59
Биеийн тамир	71
Англи хэл	81
Эрүүл мэнд.....	87



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/491

Улаанбаатар хот

「Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай」

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.8-3.2.17 дахь заалтууд, "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" багш нарын улсын хоёрдугаар зөвлөгөөнд оролцогчдын санал, зөвлөмж, "Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр" үндэсний хэлэлцүүлэгт оролцогчдын санал, дүгнэлт, Монголын багш нарын VII их хурлын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургалтын төлөвлөгөөг нэгдүгээр, дунд ангийн сургалтын төлөвлөгөөг хоёрдугаар, ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг гуравдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар шинэчлэн баталсан сургалтын төлөвлөгөөг ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангид 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсүгэй.

3. Шинэчлэн баталсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга /Т.Ням-Очир/, сургалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхийг Боловсролын хүрээлэнгийн захирал /П.Лхагвасүрэн/, сургалтын төлөвлөгөөг чанартай хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2018 оны А/543 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ

БАГА АНГИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д.д	Анги	I	II	III	IV	V	Нийт цаг
	Хичээл						
1	Бэлтгэл хөтөлбөр	60					60
2	Монгол хэл	192	224	224	224	224	1088
3	Иргэний ёс зүйн боловсрол	64	64	64	64	64	320
4	Математик	112	160	160	160	160	752
5	Хүн ба орчин	64	64	64			192
6	Хүн ба байгаль				64	64	128
7	Хүн ба нийгэм				32	64	96
8	Дүрслэх урлаг, технологи	58	64	64	64	64	314
9	Хөгжим	58	64	64	64	32	282
10	Биеийн тамир	58	64	64	64	64	314
11	Эрүүл мэнд				32	32	64
12	Англи хэл					96	96
Дүн		666	704	704	768	864	3706
Багш зохицуулах цаг		64	34	34	34	33	199
Жилийн нийт цаг							3905
Долоо хоногийн нийт ачаалал		20.8	22.0	22.0	24.0	27.0	
Өдрийн ачаалал		4.2	4.4	4.4	4.8	5.4	

Тайлбар:

1. Хичээлийн жилд 32 долоо хоног хичээллэнэ. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа I-II ангид 35 минут, III-V ангид 40 минут байна.
2. Нэгдүгээр ангийн “Бэлтгэл” хөтөлбөр нь сурагчдыг сургуулийн амьдрал, сурах үйл ажиллагаанд бэлтгэхэд чиглэсэн нэгдмэл агуулгатай үйл ажиллагаа бөгөөд хичээлийн жилийн эхэнд хэрэгжүүлнэ.
3. “Багш зохицуулах цаг”-аар суралцагчдын хоцрогдол арилгахаас гадна, суралцагч, эцэг эхэд “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлээр зөвлөгөө өгнө.
4. “Багш зохицуулах цаг”-ийг хичээлийн цагт тооцно.

-----oOo-----



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/492

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 28.1.2, 28.1.8. Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.8-3.2.17 дахь заалтууд Боловсролын хүрээлэнгийн 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 124 дүгээр албан бичиг, "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" багш нарын улсын хоёрдугаар зөвлөгөөнд оролцогчдын санал, зөвлөмж, "Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр" үндэсний хэлэлцүүлэгт оролцогчдын санал, дүгнэлт, Монголын багш нарын VII их хурлын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага боловсролын монгол хэл, математик, хүн ба орчин, хүн ба нийгэм, хүн ба байгаль, дүрслэх урлаг, технологи, хөгжим, биеийн тамир, англи хэлний сургалтын сайжруулсан хөтөлбөрийг нэгдүгээр, суурь боловсролын монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик, биологи, хими, газар зүй, түүх, нийгэм судлал, хөгжим, дүрслэх урлаг, дизайн технологи, биеийн тамир, англи хэл, орос хэлний сургалтын сайжруулсан хөтөлбөрийг хоёрдугаар, бүрэн дунд боловсролын заавал судлах, сонгон судлах монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик, биологи, хими, газар зүй, нийгэм судлал, англи хэл, орос хэлний болон заавал судлах монголын түүх, биеийн тамир, дизайн зураг зүй, технологи, сонгон судлах түүх, дизайн технологийн сайжруулсан хөтөлбөрийг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр үл харгалзан ерөнхий боловсролын нийт сургуульд 2019-2020 оны хичээлийн жилээс тус тус сургалтад хэрэгжүүлсүгэй.


3. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, хөтөлбөр хэрэгжүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхийг Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төлөвлөгөө, цөм хөтөлбөр, багийн бүрэлдэхүүн батлах тухай” 2014 оны А/240 дүгээр тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургалтын цөм хөтөлбөр батлах тухай” 2015 оны А/302 дугаар тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр батлах тухай” 2016 оны А/277 дугаар тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2015 оны А/551 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ



БАГА БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Боловсролын тухай хуульд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино”¹ гэж, Бага, дунд боловсролын тухай хуульд “Бага, дунд боловсролын зорилго нь суралцагчдад ерөнхий боловсрол эзэмшүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх, хүмүүнлэг ёсонд суралцах, авьяас чадвараа хөгжүүлэх, амьдрал, хөдөлмөрт болон тасралтгүй суралцахад өөрийгөө бэлтгэхэд нь туслахад оршино”² гэж, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод “Бага боловсролыг эх хэлний чадамжийг эзэмших боломжийг бүрдүүлэн бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвших үе хэмээн хөгжүүлнэ”³ гэж тус тус заасан.

Бага дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд нийгмийн амьдралын таатай орчин, хэм хэмжээг бий болгох, түүнд дасан зохицож амьдрах чадвартай, иргэншсэн монгол хүнийг төлөвшүүлэх, хүүхдийн сурч боловсрох хүсэл сонирхол, хийж бүтээх тэмүүллийг боловсролын түвшин бүрт дэмжиж ажиллахыг боловсролын зорилго болгон дэвшүүлсэн.

Ийнхүү Монгол Улсын боловсролын хууль тогтоомж, төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, хүүхэд бүрийн хөгжил, төлөвшлийг дэмжих үзэл баримтлал, хандлагад үндэслэн боловсруулсан бага боловсролын сургалтын хөтөлбөрийг 2014 оноос үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн үндэсний хэмжээний судалгаа, сурагчдын сурлагын амжилтын үнэлгээний үр дүн, боловсролын өнөөгийн хөгжлийн чиг хандлага болон дараах хэрэгцээ шаардлагад нийцүүлэн 2019 онд бага боловсролын сургалтын хөтөлбөрийг сайжруулж, сургууль, багш нарт хүргэж байна. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийн дараагийн үе шатны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;
- Сургууль, багш нарын хамтын ажиллагааг дэмжих, гүнзгийрүүлэх;
- Суралцах үйл ажиллагааг сурагчийн үнэт зүйл, хандлага, төлөвшилд чиглүүлэх;
- Сургалтын хөтөлбөрийн агуулгын давхардал, хүндрэлийг арилгаж хэрэгжих нөхцөл боломжийг нэмэгдүүлэх;
- Сурагчдын сурах болон багшийн багшлах ажлын ачааллыг зохистой болгох;
- Сургуулийн хичээлд суурилсан үйл ажиллагааны менежмент, төлөвлөлтийг дэмжиж, сургуулийн хөтөлбөр, багшийн хичээл төлөвлөлтийг хөгжүүлэх зэрэг болно.

ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛСАН ЗАРЧИМ

- 2.1. Хүүхэд бүрийн авьяас, сонирхол, хувийн онцлог шинжийг нээх, суралцахуйг нь дэмжих, хөгжүүлэх үндэс болох;
- 2.2. Агуулга нь шурган бүтцээр гүнзгийрэх, өргөсөх, залгамж холбоотой, тасралтгүй, хүүхдийн хөгжил, төлөвшлийн ахиц дэвшлийг хангахуйц байх;

1 Монгол улсын боловсролын тухай хууль

2 Бага дунд боловсролын тухай хууль

3 Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого/2014-2024/. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолын хавсралт

- 2.3. Сургалтын арга зүй нь тухайн насны сурагчдын нас, сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийн онцлогт нийцсэн, сурах арга барил, мэдлэг, чадвар эзэмших, хандлага төлөвшихөд чиглэсэн байх;
- 2.4. Мэдлэгийг хэрэглээ болгох, сургалтыг уян хатан төлөвлөх, зохион байгуулах сургалтын орчныг бүрдүүлсэн байх;
- 2.5. Үнэлгээ нь хүүхэд нэг бүрийн хөгжил, ахицыг дэмжихэд чиглэсэн байх;
- 2.6. Эцэг эх олон нийтийн оролцоог хангасан, бие даасан, нээлттэй сургуулийн менежмент, бодлогыг дэмжсэн байх;

ГУРАВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

3.1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

3.1.1. Зорилго

Сурагч нь эх хэл, үндэсний соёл, өв уламжлалаа дээдэлдэг; өөртөө итгэлтэй, бусдыг ойлгож, хүндэтгэдэг; сурах арга барил, авьяас чадвараа нээн хөгжүүлдэг; эрүүл аж төрөх ёсыг эрхэмлэдэг иргэн болж төлөвшихөд оршино.

3.1.2. Зорилт

- 3.1.2.1. Эх хэл, үндэсний соёл, ёс суртахуун, заншил, уламжлалыг мэдэж хүндэтгэх, эх орноороо бахархах, хүрээлэн буй орчноо таних, хайрлан хамгаалах, хүн төрөлхтний хэл, соёлоос суралцах;
- 3.1.2.2. Авьяас, сонирхол, ур чадвараа нээн илрүүлэх, хөгжүүлэх, оюуны үйл, үйлдлийг гүйцэтгэх арга барил эзэмшиж, сурах хүсэл эрмэлзэлтэй болох;
- 3.1.2.3. Өдөр тутмын ахуй, амьдралдаа харилцааны болон ёс суртахууны хэм хэмжээг баримтлах, эрүүл аж төрөх зөв дадал, хэвшлийг эрхэмлэх;

3.1.3. Сурагчийн эзэмших чадвар

- 3.1.3.1. Сургалтын хөтөлбөр нь сурагчийн танин мэдэхүй; хэл-нийгэм, харилцаа; бие бялдар, зан үйлийн хөгжлийг дэмжинэ. Үүнд:

- Танин мэдэхүй
 - Сэтгэн бодох
 - Мэдээлэл, технологитой ажиллах
 - Асуудал шийдвэрлэх
- Хэл-нийгэм, харилцаа
 - Бие даан суралцах
 - Харилцах
 - Хамтран суралцах
- Бие бялдар, зан үйл
 - Эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болох
 - Үндэсний соёл, ёс суртахуун, уламжлалыг хүндэтгэх
 - Байгаль орчинтой зөв харилцах

- 3.1.3.2. Бага боловсролын түвшинд сургалт ба хичээлээс гадуурх үйл ажиллагааг зохион байгуулсны үр дүнд III ба V анги төгссөн сурагч дараах чадварыг эзэмшсэн байна.

Чадвар		I-III анги	IV-V анги
Сэтгэн бодох ¹	Сэтгэхүйн үйл, үйлдэл гүйцэтгэх	- Хоёр зүйлийг харьцуулж, ялгаатай ба төсөөтэй талыг олдог байх - Хоёр зүйлийн ялгаатай шинжид суурилан ангилах үйлдлийг гүйцэтгэж чаддаг байх - Аливаа зүйлийг үндсэн хэсэгт хувааж, нэгтгэж чаддаг байх	- Бүлэг зүйлийг харьцуулж, ялгаатай ба төсөөтэй талыг олж чаддаг байх - Бүлэг зүйлийн ялгаатай шинжид үндэслэн ангилах, төсөөтэй шинжид үндэслэн нэгтгэн дүгнэж чаддаг байх - Аливаа зүйлийг үндсэн хэсэгт хувааж, нэгтгэж буйгаа тайлбарладаг байх
	Учир зүйтэй /логик/ сэтгэх	- Юмс, үйл явдал, өөрчлөлтийн шалтгаан, холбоо хамаарлыг тодорхойлох хүсэл, оролдлоготой болох	- Юмс, үйл явдал, өөрчлөлтийн учир шалтгаан, холбоо хамаарал, үр дагаврыг илрүүлж, тайлбарлаж чаддаг байх
	Бүтээлчээр сэтгэх	- Ямар нэгэн үйл ажиллагаа гүйцэтгэх шинэ, бүтээлч санаа дэвшүүлдэг байх	- Шинэ, бүтээлч санаа дэвшүүлж, түүнийгээ баталж чаддаг байх
Мэдээлэл, технологитой ажиллах	- Мэдээлэл цуглуулах аргаа сонгох - Мэдээлэл цуглуулах - Мэдээлэл боловсруулах - Мэдээллийг хэрэглэх	- Гэр бүл, найз нөхөд, ахмад хүмүүсээс асуух замаар мэдээлэл цуглуулж сурах - Цуглуулсан мэдээллээ харьцуулж, чухал ба чухал бишийг ялгаж, ангилж чаддаг байх - Мэдээллийг бичвэр, хүснэгт, зураг зэрэг хэлбэрээр бусдад танилцуулдаг байх - Мэдээллийг ашиглан тайлбарладаг байх	- Өөрийн боломжид суурилан эх сурвалжаас мэдээлэл цуглуулж сурах - Мэдээллээс өөрт хэрэгцээтэйгээ олж чаддаг болох - Мэдээллийг оновчтой хэлбэрээр бусдад танилцуулдаг байх - Шаардлагатай үед мэдээллийг эш татах, жишээ гаргах зэргээр ашигладаг болох
	- Анги, танхим, сургууль, ойр орчимд байгаа дохио, таних тэмдэг, тэмдэглэгээг ялгах, хэрэглэх - Аливаа үйлийг гүйцэтгэх технологи /техник/-ийн талаарх удирдамж, зааврыг уншиж ойлгох, мөрдөх	- Орчин тойронд байнга тохиолддог дохио, таних тэмдэг, тэмдэглэгээг мэддэг байх - Багшийн өгсөн зааврыг уншиж ойлгодог, хэрхэн хэрэгжүүлэх талаар бусдад тайлбарладаг байх	- Дохио, таних тэмдэг, тэмдэглэгээг мөрдөх, хэм хэмжээг сахидаг байх - Удирдамж, зааврыг уншиж ойлгохоос гадна зарим оновчтой хувилбарыг дэвшүүлдэг, түүнийг тогтмол мөрддөг байх

¹. Сэтгэн бодох чадварт тулгуурлан хичээл /судлагдахуун/ бүрийн тусгай чадвар хөгжинө.

Асуудал шийдвэрлэх	- Асуудлыг олж харах - Асуудлыг шийдвэрлэх арга, хувилбарыг санал болгох - Хувилбаруудаас сонгох - Хувилбарыг сонгосон үндэслэлээ тайлбарлах	- Өөрийн, гэр бүлийн, анги хамт олны хүрээнд тулгарч буй бэрхшээл, асуудлыг олж хардаг байх - Өөрийн туршлагад үндэслэн асуудал шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг нэрлэж чаддаг байх - Хувилбаруудаас сонголт хийдэг байх - Хувилбарыг сонгосон үндэслэлээ тайлбарладаг байх	- Гэр бүл, анги хамт олон, сургуулийн түвшинд шийдвэрлэх асуудлыг дэвшүүлж, үндэслэлтэй тайлбарладаг байх - Баримт нотолгоо болон бусад мэдээлэлд үндэслэн асуудлыг шийдвэрлэх хувилбарыг тодорхойлдог байх - Хувилбаруудаас сонголт хийж, хооронд нь харьцуулдаг байх - Хувилбарыг сонгож, үндэслэлээ баримт нотолгоо, мэдээллээр баяжуулан тайлбарлах
Бие даан суралцах	- Юу сурах талаар хүсэж, сонирхож буйгаа илэрхийлэх - Өөрийн сурах үйлээ төлөвлөх, гүйцэтгэх - Өөрийн хийсэн зүйлээ хянах, сайжруулах - Аливаа зүйлийг эхнээс нь дуустал хийж гүйцэтгэх - Бусдад өөрийн санаа бодлоо илэрхийлэх	- Юу хүсэж, сонирхож байгаагаа ойр дотны хүндээ хэлж, ярьж чаддаг байх - Сурахын тулд юу хийхээ баримжаалдаг байх - Юуг чадахгүй байгаагаа мэддэг байх - Бодсон зүйлээ хийж гүйцэтгэн, юу нь болсон, юу нь болоогүйг бусдад ярьж чаддаг байх - Үйлийг бусдын дэмжлэгтэй хийж дуусгадаг байх - Бүтэн, гүйцэд өгүүлбэрээр товч, ойлгомжтой өөрийн санаа бодлыг илэрхийлдэг болох	- Ямар мэдлэг, чадвар эзэмших шаардлагатай байгаагаа тодорхойлж чаддаг байх - Өөрийн мэдэхгүй, чадахгүй зүйлийг хэрхэн эзэмшихээ өөрийн бодит нөхцөлд тулгуурлан тодорхойлдог байх - Өөрийн сурах ажлын үр дүнг тооцдог, алдааны шалтгааныг илрүүлдэг байх - Үйлийг бие даан гүйцэтгэдэг, шаардлагатай үед тэвчээртэй хандаж, асуудлыг шийдвэрлэх арга замыг олж хардаг байх - Өөрийн санаа бодлыг илэрхийлэхдээ мэдээллийн олон хэлбэрийг ашигладаг байх
Харилцах	- Бусдыг сонсох	- Бусдыг анхааралтай сонсохын чухлыг ойлгодог байх	- Бусдыг сонсож ойлгодог болох
	- Бусдад хүндэтгэлтэй хандах	- Бусдыг хүндэтгэж байгаагаа үгээр, үйлээр, биеийн хэлээр илэрхийлж, зүй зохистой харилцдаг байх	- Харилцааны, хүндэтгэлийн үгийг тохиромжтой үед хэрэглэж, харилцааны эерэг байдлыг бий болгодог байх
	- Бусадтай харилцахдаа үг хэллэгийг оновчтой ашиглах	- Бусадтай харилцахдаа хэрэглэх үг хэллэгийг мэддэг байх - Хичээл тус бүрийн агуулгатай холбоотой үг хэллэгийг мэддэг болох	- Бусадтай харилцахдаа ашиглах үг хэллэгийг зөв хэрэглэдэг байх - Тайлбар хийх, санаа бодлоо илэрхийлэхдээ тохиромжтой үг хэллэг, зарим нэр томъёог ашигладаг байх

Хамтран суралцах	- Багаар хамтран ажиллах - Үеийнхнээс дэмжлэг авах, бусдыг дэмжих - Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, удирдах	- Хосоор хамтран ажиллаж, бие биедээ харилцан тусалдаг байх - Мэдэхгүй, чадахгүй зүйлд бусдаас дэмжлэг хүсэж чаддаг байх - Сэтгэл хөдлөлөө үг, үйлдэл, биеийн хэлээр зөв илэрхийлдэг байх	- Бичил бүлэг /3-4 хүн/-ээр ажиллаж, даалгавар гүйцэтгэхэд өөрийн хувь нэмрээ оруулдаг байх - Өөрийн чадах зүйлээр бусдад дэмжлэг үзүүлдэг байх - Сэтгэлийн хөдөлгөөнөө бусдад зөв илэрхийлдэг, ойр орчмын хүмүүстээ сөрөг нөлөө үзүүлэхгүйг эрмэлздэг байх
Эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болох	- Амьдралын хэв маяг, эрүүл мэнд хоорондын холбоо хамаарлыг тунгаан бодох - Эрүүл ахуйн дэглэм, хэм хэмжээг баримтлах	- Өдөр тутмын амьдралдаа эрүүл ахуйн дэглэм баримтлахын учрыг олох - Гэр бүл, сургууль, орчин тойронд эрүүл ахуйн дэглэмийг мөрддөг байх	- Эрүүл, зөв дадал, хэвшилтэй байх нь эрүүл мэндээ хамгаалахад чухал болохыг эргэцүүлэх - Өдөр тутмын амьдралд эрүүл ахуйн дэглэм мөрдөж, хэвшил болгохыг эрмэлздэг байх
Үндэсний соёл, ёс суртахуун, уламжлалыг хүндэтгэх	- Үндэсний соёлоо мэдэрч таних, бахархах - Монгол ёс суртахуун, уламжлалаасаа сурах, өвлөх, хөгжүүлэх	- Үндэсний соёл, ёс заншлаасаа ухаарч ойлгон, өдөр тутмын зан үйлдээ хэвшил болгох - Монгол ёс суртахууны хэм хэмжээнээс ойлгож, биеэ зөв авч явахад баримталдаг байх - Ү н д э с н и й х э э уламжлалаасаа сурч, өвлөх, хөгжүүлэх эрмэлзэлтэй болох	- Үндэсний соёл, ёс заншлын үнэт зүйлсийг ойлгож, өдөр тутмын зан үйлдээ хэвшүүлсэн байх - Монгол ёс суртахууны хэм хэмжээг танин мэдэж, биеэ зөв авч явахад баримталж хэвшсэн байх - Үндэснийхээ уламжлалын үнэт зүйлсээс суралцаж, өвлөх, хөгжүүлэх хандлагатай болох
Байгаль орчинтой зөв харилцах	- Байгаль орчноо таньж мэдрэх, түүнд нөлөөлж буй зүйлсийг нэрлэх - Байгаль орчноо хамгаалах санааг дэмжих	- Амьдарч буй орчныхоо амьд ба амьгүй биес, түүнд нөлөөлж буй зүйлсийг нэрлэж, үнэлэх - Амьдарч буй орчноо цэвэр цэмцгэр байлгах, хамгаалах санаа гаргах	- Орон нутгийнхаа байгаль орчинд нөлөө үзүүлж байгаа зүйлсийг нэрлэж, үнэлж дүгнэх - Орон нутгийнхаа байгаль орчныг хамгаалахад оролцох хүсэл эрмэлзэлтэй болох

3.2. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

- 3.2.1. Математик, хүн ба орчин, хүн ба байгаль, англи хэлний боловсролын агуулга нь шинжлэх ухаан, технологи, гадаад хэлийг судлах хүсэл сонирхолтой болоход;
- 3.2.2. Монгол хэл, хүн ба нийгмийн боловсролын агуулга нь нийгмийн харилцааны бүхий л орчинд эх хэлээрээ чөлөөтэй харилцах, эх хэлээ дээдлэх, амьдран буй нийгмээ танин мэдэх, эх орныхоо түүх, соёлоор бахархах, өвлөн уламжилж хөгжүүлэх мэдлэг, ойлголт, хандлага, төлөвшилтэй болоход;
- 3.2.3. Урлаг (хөгжим, дүрслэх урлаг, технологи), биеийн тамирын боловсролын агуулга нь бие бялдраа хөгжүүлэх, гоо сайхныг мэдрэх, шинийг санаачилж бүтээх, соёл өв уламжлалаа дээдлэх, ёс суртахуунтай байх мэдлэг ойлголт, хандлага төлөвшилтэй болоход тус тус чиглэсэн байх;

3.3. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

- 3.3.1. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сурагч дараах суралцахуйн стратегийг баримтална. Үүнд:
- Сурагч хэрэгцээ, сонирхол, туршлага, чадвартаа суурилан бие даан суралцах арга барилаа хөгжүүлэх;
 - Асуулт, дасгал, даалгавар зэрэг үйл ажиллагаагаар өөрийгөө сорьж, хөгжүүлэх, мэдлэг бүтээх боломжийг хангах;
 - Ярилцлага, хэлэлцүүлэг, мэтгэлцээнд оролцох, дүрд тоглох зэрэг хамтран суралцах болон оролцооны арга барилд суралцах;
- 3.3.2. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш дараах багшлахуйн стратегийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- Сурагч сонирхол, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, асууж, ярих боломжийг бүрдүүлэх зэргээр хөгжлийг нь дэмжих;
 - Сурагчийн ялгаатай байдал (хүйс, сурах арга барил, соёл гэх мэт)-ыг харгалзах;
 - Ганцаарчилсан, хосоор, багаар, анги нийтээр оролцох хичээл зохион байгуулалтын хэлбэрийг хослуулах;
 - Сурагчийн өмнөх төсөөлөл, мэдлэг чадварыг судалсан үр дүнд суурилан хичээлийн арга зүйг сонгож боловсруулах, сурагч гаргасан алдаанаасаа суралцахад нь анхаарах;
 - Тоглоом, хэлэлцүүлэг, мэтгэлцээн, дүрд тоглох, туршилт, тэмцээн, төсөлт ажил зэрэг сурагч төвтэй, идэвхтэй сурах аргыг хичээлд өргөн хэрэглэх;

3.4. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

- 3.4.1. Сургалтын орчин гэдэгт танхимын болон танхимаас гадуурх байгаль, нийгэм, соёлын орчинг ойлгоно.
- 3.4.2. Сурагчийн сурах үйлийн болон сэтгэл зүйн орчин, тэдний өөрөө суралцаж хөгжих нөхцөл боломж бүрдүүлэхийг чухалчилна.
- 3.4.3. Сургалтад хэвлэмэл, бодит болон дүрс, дуу бичлэг, цахим хэрэглэгдэхүүнийг ашиглана.
- 3.4.4. Орон нутаг, сургуулийн онцлог, боломжийг харгалзсан, аюулгүй, хямд, ашиглахад хялбар, олдоцтой гарын доорх материалыг ашиглан сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэж болно.

3.5. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ

- 3.5.1. Сурагчийг оношлох, явцын ба үр дүнгийн үнэлгээгээр үнэлнэ.
- 3.5.2. Оношлох үнэлгээ нь сурах үйл ажиллагаанд тулгарч байгаа бэрхшээл, түүний шалтгааныг тодорхойлох зорилгоор хичээлийн жил, хагас жил, улирал, бүлэг сэдвийн эхэнд сурагчийн мэдлэг, чадвар, хандлагын түвшинг тандаж илрүүлэхэд чиглэнэ.
- 3.5.3. Явцын үнэлгээ нь сурагчийн ахиц, хөгжлийн талаар мэдээлэл цуглуулах, суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл сургалтын явцад тогтмол хийгдэж, багш, сурагч, эцэг эхэд мэдээлэл өгөх, эргэх холбоо бий болгоход чиглэнэ.
- 3.5.4. Үр дүнгийн үнэлгээ нь сурагчийн тухайн хичээлийн жил, хагас жил, бүлэг сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварын түвшинг тогтоох, хандлага төлөвшилд үнэлэлт, дүгнэлт өгөхөд чиглэнэ. Бага боловсролын III, IV ангийн анги дэвших болон V ангийн төгсөх шалгалтаар сургалтын хөтөлбөрийн үнэлгээний зорилт, шалгуур, жинг үндэслэн үр дүнгийн үнэлгээ хийнэ.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ

- 4.1.1. Сургалтын хөтөлбөрийг сурагчийн чадвар, сурах арга барил эзэмшилт, хувь хүний төлөвшил, тэдний танин мэдэхүйн хөгжлийг гол үзүүлэлт болгон I-III, IV-V анги гэсэн хоёр шатлалтайгаар хэрэгжүүлнэ.
- 4.1.2. Сургалтын хөтөлбөр нь сургалтын болон хичээлээс гадуурх сургалтын ажлаар хэрэгжинэ. Эдгээр нь сургалтын хөтөлбөрт тодорхойлсон мэдлэг, ойлголтоо бататгах, авьяас чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ.
- 4.1.3. Ерөнхий боловсролын сургууль нь батлагдсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хичээлд суурилсан, хүүхэд төвтэй сургалт, үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлнэ.
- 4.1.4. Сургалтын хөтөлбөрийг орон нутаг, сургуулийн онцлог, бие даасан байдлыг хангахуйц, сургуульд суурилсан хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.

4.2. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЛЭЭ БА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сургалтын хөтөлбөр нь багш, сурагчийн үйл ажиллагаанаас гадна сургуулийн бодлого, менежмент, эцэг эх, асран хамгаалагчид болон олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжих тул дараах зориулалтаар хэрэглэнэ.Үүнд:

- 4.2.1. Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургуулийн менежментийг чиглүүлэх, сургалтын орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сургуулийн өөрийн үнэлгээ хийхэд;
- 4.2.2. Бага ангийн багш сургалтаа зохион байгуулах, удирдах, үнэлэх, үр дүнг тооцоход;
- 4.2.3. Сурагч сурах арга барил, чадвар эзэмших, сурлагын чанараа дээшлүүлэхэд;
- 4.2.4. Эцэг, эх, олон нийт сурагчийн сурлагын ахиц амжилт, хөгжил, төлөвшлийг дэмжих, үнэлэх, сургууль, багштай холбоо тогтоох, хамтран ажиллахад;
- 4.2.5. Боловсролын мэргэжлийн байгууллагын ажилтан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэхэд;
- 4.2.6. Олон нийт болон нийгмийн бүлгүүдэд боловсрол эзэмших үйл ажиллагааны явц, үр дүнг хянах, тооцох, дэмжин хамтран ажиллахад тус тус хэрэглэнэ.

4.3. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ гэдэгт сурагчийн сурлагын амжилтын болон боловсролын чанарын үнэлгээ, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгааг багтаан ойлгоно.

- 4.3.1. Орон нутаг, сургууль сурагчдын сурлагын амжилтыг жил бүр үнэлж, үр дүнг, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхэд хэрэглэнэ.
- 4.3.2. Бага боловсролын чанарын үнэлгээ нь сурагчийн мэдлэг, чадварын түвшинг тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ.
- 4.3.3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгааг 5 жил тутамд хийж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх үндэслэлийг тодорхойлно.
- 4.3.4. Дээрх үнэлгээ, судалгаанууд нь үнэлгээний зорилго, үнэлж буй субъект болон арга, хэлбэрээр ялгаатай байна.

МОНГОЛ ХЭЛ

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэн, бүтээлчээр уншиж бичин, хэл соёлоороо бахархдаг болно.

1.2. Зорилт

- 1.2.1. Монгол хэлний зүй, үгийн сангийн анхан шатны мэдлэг ойлголт эзэмших;
- 1.2.2. Төрөл бүрийн эхийг уншиж, сонсож ойлгох, санаа бодлоо амаар болон бичгээр илэрхийлэх арга барил эзэмших;
- 1.2.3. Эх хэлээрээ чадварлаг, соёлтой харилцах, үгийн сангаа нэмэгдүүлэх хүсэл эрмэлзэлтэй болох.

Хэлний хэрэглээнд тулгуурлан унших, бичих, ярих, сонсох чадварыг эзэмшин, хэл сурах арга барилд суралцана.

Чадвар	I-III анги	IV-V анги
Унших	- Үгийн утгыг тайлбарлахдаа сурах бичгийн тайлбар, тайлбар толь бичиг хэрэглэх чадвар - Төрөл бүрийн эх уншаад, ерөнхийд нь ойлгосноо харуулах, чухал хэсгийг ялгаж, ойлгосноо илэрхийлэх чадвар - Уншсан эхийн баатрын зан чанар, үйл хөдлөлийн учир шалтгааныг жишээ татан тайлбарлах чадвар - Цээжилсэн хэл зүгшрүүлэх үг, бэлгэ дэмбэрлийн үг, зугаа үгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших, шүлгийн утгыг мэдэрч, уран унших чадвар - Зохиолын баатруудын хэлэх үгийг төсөөлөх, үйл явдлыг таамаглах чадвар - Талархал, мэндчилгээ, товч анкет, танилцуулга, заавар, талархсан захидал, төлөвлөгөө, номын тэмдэглэл, хаяг, шошго зэргийг уншиж, эхийн онцлогоос хамааран, агуулга, бүтцийг тайлбарлах чадвар	- Эхийн агуулгыг ойлгохдоо үгийн утгыг тайлбарлах чадвар - Төрөл бүрийн эх уншаад, гол санааг ойлгосноо харуулж, утгыг харьцуулах чадвар - Уншсан эхийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгаан, утгын холбоо хамаарлыг тайлбарлах чадвар - Уншсан эхийн баатрын зан чанар, үзэл бодолд гарсан өөрчлөлтийг харьцуулах, дүгнэх чадвар - Уншсан эх дэх адилтгасан, хүншүүлсэн, хэтрүүлсэн дүрслэлийг тайлбарлах чадвар - Зохиолчийн санааг мэдэрч, ярианы хурд, дууны өнгөө тохируулан уран уншиж, шүлгийн утгыг ойлгосноо харуулах чадвар - Уншсан эхээс үзэл бодол, баримт, бодит байдал, уран сэтгэмжийг ялгах чадвар - Зохиолын баатрын гадаад байдал, орчныг төсөөлөх, үйл явдлыг таамаглах чадвар - Урилга, уриалга, номын танилцуулга, үзэл бодлоо илэрхийлсэн захидал зэргийг уншиж, эхийн онцлогоос хамааран, агуулга, бүтцийг тайлбарлах чадвар

Бичих	- Авиа, үсгийг зөв холбон, үгийг үеэр зөв таслан, өгүүлбэрийг том үсгээр эхлэн, өгүүлбэр, эхийг бүтцийн дагуу хичээнгүй бичих чадвар - Зөв бичгийн дүрмийн алдаагүй зөв бичих чадвар - Танилцуулга, талархал, мэндчилгээ, болсон явдал, үлгэр, номын танилцуулга, талархсан захидал, төлөвлөгөө зэргийг зохион бичих чадвар - Ертөнцийн гурав, богино шүлгийн хэлбэрийг дуурайж бичих чадвар	- Авиа, үсгийг зөв холбон, үгийг үеэр зөв таслан, өгүүлбэрийг том үсгээр эхлэн, эхийг догол мөрөөр зааглан, утгын уялдаа холбоотой, дэгийн дагуу хичээнгүй бичих чадвар - Зөв бичгийн дүрмийн алдаагүй зөв бичих чадвар - Урилга, уриалга, сонины мэдээ, өдрийн тэмдэглэл, үзэл бодлоо илэрхийлсэн захидал, оньсого, үлгэр, өгүүллэг, баатруудын харилцан яриа зохион бичих чадвар - Уншсан зохиолын хүрээнд мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлж бичих, үйл явдлыг товчилж бичих чадвар
Сонсох	- Анхааралтай сонсох чадвар - Идэвхтэй сонсох чадвар	- Хүлээцтэй сонсох чадвар - Зөв сонссон гэдгээ илэрхийлэх чадвар
Ярих	- Ярилцах, хэлэлцэх үедээ санаа бодлоо тод, чанга, өөртөө итгэлтэй, ойлгомжтой, тодорхой ярих чадвар - Үлгэр, хүүхэлдэйн киноны баатрын үг хэл, үйл хөдлөлийг дуурайж дүрд тоглох чадвар	- Ярилцах, хэлэлцэх, илтгэх үедээ баримт хэрэглэн цэгцтэй, товч тодорхой, оновчтой илэрхийлэх чадвар - Бусдын санаа бодлыг дүгнэн ярих чадвар - Үгийн сонголт, дууны өнгөө тохируулан баатрын хэл яриа, үйл хөдлөл, үзэл бодлыг илэрхийлж жүжиглэн, зохиолын утгыг ойлгосноо харуулах
Хэл зүй, үгийн сан	- Эх өгүүлбэрээс хэн?, юу?, яав?, яаж?, яагаад?, ямар учраас? гэсэн асуултад хариулагдах үсгийг олох, хэрэглэх - Уншсан эхээс анхааруулах өгүүлбэрийг ялган таних, бичихдээ анхаарлын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх - Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох - Хэлц үгийн тайлбарыг уншиж ойлгох, өгүүлбэр зохиохдоо хэрэглэх	- Хашилт, хаалт, цэг тэмдгийг зөв хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох - Баталсан, дэмжсэн өнгө аясыг илтгэсэн үг, өгүүлбэрийг оновчтой хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох - Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох - Хэлц үгийг эх зохиохдоо хэрэглэх

ХОЁР. АГУУЛГА

I АНГИ

ҮСЭГ, БИЧИГТ ЭХЛЭН СУРАЛЦАХ ҮЕ

(Цагаан толгойн бэлтгэл ба цагаан толгойн үе)

0.1. СОНСОХ-ЯРИХ

0.1a. Бусдын уншсан үлгэр, өгүүллэгийг сонсож, асуултад хариулах

0.1б. Сурах бичиг дэх зургийн дагуу үлгэр өгүүллэгийг ярих

0.2. УНШИХ

0.2a. Үгийн бүтцээс богино, урт, хос эгшиг үсгийг ялган таних, нэрлэх, зөв унших

(а, аа, ай, э, ээ, эй, и, ий, ы, о, оо, ой, ө, өө, у, уу, уй, ү, үү, үй)

0.2б. Дармал ба бичмэл “м, с, х, р, в, л, н, ш” үсгийг таних, нэрлэх, задгай ба битүү үеийг нүдлэх, үг, холбоо үгийг үелж зөв унших

- 0.2в. Дармал ба бичмэл б, г, д, т, ц, ч, з, ж үсгийг таних, нэрлэх, задгай ба битүү үеийг нүдлэх, 1-2 үетэй үгийг шууд, урт үг, холбоо үгийг үелж зөв унших
- 0.2г. Зөөлний тэмдгийг ялган таних, нэрлэх, зөөлөрсөн гийгүүлэгч бүхий үсгийг зөв унших
- 0.2д. “я, е, ё, ю” болон “к, п, ф, щ” үсгийг ялган таних, нэрлэх, эдгээр үсэг бүхий үг, холбоо үг, хялбар эхийг унших, 2-3 үетэй үгийг шууд унших
- 0.2е. Хатуугийн тэмдгийг ялган таних, нэрлэх, унших
- 0.3. БИЧИХ
- 0.3а. Үсэг бүтээдэг зурлагуудыг дэвтрийн шугамаар баримжаалан дэгийн дагуу бичих
- 0.3б. Богино, урт, хос эгшиг үсгийг дэгийн дагуу бичих
(а, аа, ай, э, ээ, эй, и, ий, ы, о, оо, ой, ө, өө, у, уу, уй, ү, үү, үй)
- 0.3в. Том, жижиг “м, с, х, р, в, л, н, ш” үсгийг дэгийн дагуу бичих, зөв холбон бичих
- 0.3г. Том, жижиг “б, г, д, т, ц, ч, з, ж” үсэг болон зөөлний тэмдгийг дэгийн дагуу бичих, зөв холбон бичих
- 0.3д. Том, жижиг “я, е, ё, ю” болон “к, п, ф, щ” үсэг, хатуугийн тэмдгийг дэгийн дагуу бичих, үг, холбоо үг, өгүүлбэрийг бичих
- 0.3е. Хуулж бичихдээ урт үгийг үеэр, богино үгийг бүтнээр нүдэлж бичих
- 0.4. ХЭЛ ЗҮЙ, ҮГСИЙН САН
- 0.4а. Өгсөн үгээс эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгийг таньж нэрлэх
- 0.4б. Хуулж болон цээжээр бичихдээ хүний нэр ба өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих
- 0.4в. Өгүүлбэрийг хаана? хэзээ? гэсэн асуултаар дэлгэрүүлэх

ЦАГААН ТОЛГОЙН ДАРААХ ҮЕ

- 1.1. УНШИХ
- 1.1а. Өгүүлбэр, эхээс танил биш үгийг олж, утгыг нь таамаглах
- 1.1б. Сурах бичгийн эх, зурагт эх, богино хэмжээтэй хялбар эхийг уншиж агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах
- 1.1в. Уншсан эхийн үйл явдлыг асуултын дагуу тоочин ярих (эхлээд? дараа нь, эцэст нь?)
- 1.1г. Уншсан эхийн баатрын хийсэн зүйлийг тоочих
- 1.1д. Цээжилсэн хэл зүгшрүүлэх үг, бэлгэ дэмбэрлийн үг, шүлгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших
- 1.1е. Зохиолын баатруудын гадаад байдлыг төсөөлж ярих
- 1.2. БИЧИХ
- 1.2а. Хуулж болон цээжээр бичихдээ үг, үсэг, өгүүлбэрийг дэгийн дагуу бичих
- 1.2б. Хүний нэр ба өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, өгүүлбэрт цэг, таслал, асуултын тэмдгийг зөв хэрэглэх
- 1.2в. Зураг, бүдүүвчид тохирсон 3-4 үгтэй өгүүлбэр зохиож бичих
- 1.2г. Багшийн хэлсэн 2-4 үгээс бүтсэн өгүүлбэрийг сонсож, цээжээр бичих
- 1.2д. Өгсөн загвар, асуулт, зургийн дагуу 3-4 өгүүлбэр бүхий зохиож бичих
- 1.2е. Өөрийгөө 4-5 өгүүлбэрээр танилцуулж бичих
- 1.3. СОНСОХ-ЯРИХ
- 1.3а. Өгсөн зургийг ажиглаж үйл явдлыг тод, чанга, ойлгомжтой ярих
- 1.3б. Бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож, ойлгосноо харуулах

- 1.3в. Үлгэр, хүүхэлдэйн киноны баатрын үг хэл, үйл хөдлөлийг дуурайж тоглох
- 1.4. ХЭЛ ЗҮЙ, ҮГСИЙН САН
- 1.4а. Эгшиг ба гийгүүлэгч, тэмдэг үсгийг ялган таних
- 1.4б. Эх, өгүүлбэр дэх үсгийг хэн? юу? яав? гэсэн асуултаар ялгах
- 1.4в. Өгүүлбэрийг 1-2 асуултаар дэлгэрүүлэх
- 1.4г. Өгүүлбэрт цэг, таслал, асуултын тэмдгийг зөв хэрэглэх

II АНГИ

- 2.1. УНШИХ
- 2.1а. Танил биш үгийг сурах бичгийн тайлбараас цагаан толгойн үсгийн дарааллаар олж сонгох, утгыг мэдэх
- 2.1б. Уншсан шүлэг, өгүүллэг, үлгэр, зүйр цэцэн үг, хэл зүгшрүүлэх үг зэрэг эхийг уншиж, агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах
- 2.1в. Уншсан үлгэр, өгүүллэгийг үйл явдлын дарааллын дагуу тоочих
- 2.1г. Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг жишээгээр тайлбарлах
- 2.1д. Талархал, мэндчилгээ, товч анкет, танилцуулга, заавар зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах
- 2.1е. Цээжилсэн шүлэг, зугаа үг, хэл зүгшрүүлэх үгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших
- 2.1ж. Өгсөн зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг ургуулан төсөөлөх
- 2.1з. Өгсөн зургаас үндэслэн үйл явдлыг таамаглах
- 2.2. БИЧИХ
- 2.2а. [н,г] үсгээр утга ялгаж үсгийг зөв унших, нүдлэх, зөв бичих
- 2.2б. Эр, эм үгэнд “ы, ий” залгаврыг зөв залган бичих
- 2.2в. Үгийг үеэр таслан мөр шилжүүлж зөв бичих
- 2.2г. Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсэг гэж ангилж, бүлэглэх
- 2.2д. Багшийн хэлсэн 5-6 өгүүлбэрийг сонсож, цээжээр бичих
- 2.2е. Өгсөн бүтцийн дагуу мэндчилгээ бичих
- 2.2ж. Өгсөн бүтцийн дагуу болсон явдлаа ойлгомжтой бичих
- 2.2з. Өгсөн бүтэц зааврын дагуу баярлаж талархсанаа илэрхийлсэн талархал бичих
- 2.2и. Сэдэвт болон цуврал зургийн дагуу утгын холбоотой 4-5 өгүүлбэр бүхий эх зохиох
- 2.2к. Ертөнцийн гурвын хэлбэрийг дуурайн зохион бичих
- 2.2л. Зааврын дагуу гэр бүлээ танилцуулж бичих
- 2.3. СОНСОХ-ЯРИХ
- 2.3а. Болсон явдал, сонссон зүйлийг ойлгомжтой мэдээлж ярих
- 2.3б. Бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож, ойлгосноо харуулах
- 2.3в. Санаа бодлоо өөртөө итгэлтэйгээр ойлгомжтой, тод дуугаар илэрхийлэх
- 2.3г. Зохиолын баатрын үг яриаг цээжилж тогтоон, харилцан яриагаар дүрд тоглох
- 2.4. ХЭЛ ЗҮЙ, ҮГСИЙН САН
- 2.4а. Эх, өгүүлбэрээс хэн? юу? ямар? хэд хэчнээн? яах? яав? яасан? гэсэн асуултад хариулагдах үсгийг олох, эх, өгүүлбэр зохиохдоо зөв хэрэглэх
- 2.4б. Асуусан, хүүрнэсэн өнгө аястай өгүүлбэр зохиохдоо асуултын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх
- 2.4в. Эсрэг утгатай үгийг таних, өгүүлбэр зохиохдоо хэрэглэх
- 2.4г. Хэлц үгийн тайлбарыг уншиж ойлгох, цээжилж тогтоох

III АНГИ

3.1. УНШИХ

- 3.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж, агуулгыг ойлгох
- 3.1б. Уншсан эх, үлгэр, өгүүллэг, шүлгээс чухал хэсгийг ялгаж, ойлгосноо харуулах
- 3.1в. Уншсан үлгэр, өгүүллэг дэх баатрын үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлах
- 3.1г. Эхээс баатрын болон зохиогчийн үгийг ялгах
- 3.1д. Уншсан зохиолын баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлах
- 3.1е. Талархсан захидал, зорилгодоо хүрэх төлөвлөгөө, номын тэмдэглэл, хаяг, шошго зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах
- 3.1ж. Цээжилсэн шүлгийн утгыг мэдэрч, мэдрэмжээ илэрхийлэн уран унших
- 3.1з. Үлгэр, өгүүллэгийн үйл явдлыг уншихдаа гол баатрын хэлэх үгийг ургуулан бодож, төсөөлөх
- 3.1и. Уншсан үлгэр, өгүүллэгийн гол хэсгийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг таамаглах

3.2. БИЧИХ

- 3.2а. Утга ялгасан үгийг /н,г,х/ зөв дуудах, нүдлэх, өгүүлбэрт утга ялган зөв хэрэглэх
- 3.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэдэх, бичихдээ хэрэглэх
- 3.2в. Дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр зөв бичих
- 3.2г. Газар ус, улс орон зэрэг оноосон нэрийг ялгах, зөв бичих
- 3.2д. Баярласан сэтгэлээ илэрхийлж, бүтцийн дагуу талархсан утгатай захидал бичих
- 3.2е. Хүсэл мөрөөдөл, зорилготойгоо нийцүүлж төлөвлөгөө зохион бичих
- 3.2ж. Өгсөн зааврын дагуу тоочин жагсааж бичих
- 3.2з. Өгсөн сэдэв, бүтцийн дагуу үлгэр зохиож бичих
- 3.2и. Шүлэг, ертөнцийн гурвын хэлбэрийг дуурайн зохиож бичих
- 3.2к. Өгсөн бүтцийн дагуу уншсан номоо тэмдэглэн бичих
- 3.2л. Уншсан зохиолын талаар сэтгэгдлээ илэрхийлэн бичих

3.3. СОНСОХ-ЯРИХ

- 3.3а. Болсон явдал, сонссон зүйлийн учир шалтгааныг бусдын өмнө тодорхой ярих
- 3.3б. Хэлэлцүүлгийн үед бусдын ярианаас лавшруулан, тодруулан асуух замаар идэвхтэй сонссоноо харуулах
- 3.3в. Хэлэлцэх, ярилцах үед хүсэл, санаа бодлоо бусдын өмнө чөлөөтэй илэрхийлэх
- 3.3г. Зохиолын баатрын дуу хоолой, биеийн хөдөлгөөн, харцыг дуурайн дүрд тоглох

3.4. ХЭЛ ЗҮЙ, ҮГСИЙН САН

- 3.4а. Эх, өгүүлбэрээс хэн? юу? яав? яаж? яагаад? ямар учраас? гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, хэрэглэх
- 3.4б. Уншсан эхээс анхааруулах өгүүлбэрийг ялган таних, бичихдээ анхаарлын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх
- 3.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох
- 3.4г. Хэлц үгийн тайлбарыг уншиж ойлгох, өгүүлбэр зохиохдоо хэрэглэх

IV АНГИ

4.1. УНШИХ

- 4.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс олж, агуулгыг ойлгох
- 4.1б. Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах
- 4.1в. Уншсан эх, үлгэр, өгүүллэгийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгааныг тайлбарлах
- 4.1г. Шүлэг дэх хоёр зүйлийн ижил төстэй шинжийг харьцуулан адилтган дүрсэлснийг тайлбарлах
- 4.1д. Эхэд ашигласан баримт ба өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсгийг ялгах
- 4.1е. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанар, үзэл бодолд гарсан өөрчлөлтийг харьцуулах
- 4.1ж. Урилга, уриалга, номын танилцуулга, сонины мэдээ, захидал зэргийн зорилго, бүтцийг тайлбарлах
- 4.1з. Хурд, дууны өнгөө тохируулан урнаар уншиж, шүлгийн утгыг ойлгосноо харуулах
- 4.1и. Уншсан зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх
- 4.1к. Эхийн үйл явдлын төгсгөлийг үндэслэлтэйгээр таамаглах

4.2. БИЧИХ

- 4.2а. Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгаж, өгүүлбэрт зөв хэрэглэх (буурь-буйр, хууль-хуйл, тууль-туйл)
- 4.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих
- 4.2в. ж, ч, ш-ийн дараа “и” бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих
- 4.2г. Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэх, зөв бичих
- 4.2д. Үйл явдлыг өрнүүлэн, утгын уялдаа холбоотой богино өгүүллэг зохиох
- 4.2е. Өгсөн бүтцийн дагуу утгын уялдаа холбоотой бахархсан утгатай захидал бичих
- 4.2ж. Бусдыг сайн сайхан зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга бичих
- 4.2з. Өгсөн асуултын хүрээнд үйл явдлын товч мэдээ бичих
- 4.2и. Хүндэтгэлийн үг хэрэглэн, бүтцийн дагуу урилга бичих
- 4.2к. Бүтцийн дагуу үлгэр зохиохдоо баатрын гадаад дүр байдлыг дүрслэн бичих
- 4.2л. Шүлгийн хэлбэрийг дуурайж зохион бичих
- 4.2м. Уншсан номыг танилцуулж бичихдээ сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх

4.3. СОНСОХ-ЯРИХ

- 4.3а. Сэдвийн хүрээнд яриагаа төлөвлөж, бэлтгэн, ойлгомжтой, цэгцтэй илэрхийлэн ярих
- 4.3б. Хэлэлцүүлэгт шинэ санаа нэмж оролцох, бусдын яриаг дуустал хүлээцтэй сонсох
- 4.3в. Хэлэлцүүлгийн явцад бусдын санаа бодлыг анхааралтай сонсож, дүгнэх
- 4.3г. Зохиолын баатруудын харилцан ярианы утгыг ойлгосноо жүжиглэн үзүүлэх

4.4. ХЭЛ ЗҮЙ, ҮГСИЙН САН

- 4.4а. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох
- 4.4б. Уриалсан, зөвлөсөн өнгө аясыг илтгэх үг хэллэгийг оновчтой хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох
- 4.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох
- 4.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх

V АНГИ

5.1. УНШИХ

- 5.1а. Эхэд ашигласан зарим үг, хэллэгийг сонгож, эхэд хэрэглэсэн учрыг тайлбарлан дүгнэх
- 5.1б. Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг харьцуулах замаар эхийн агуулгыг ойлгосноо харуулах
- 5.1в. Уншсан жүжгийн зохиолын гол санааг тайлбарлах
- 5.1г. Уншсан эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн утгын холбоо хамаарлыг тайлбарлах
- 5.1д. Эхээс хүншүүлсэн, хэтрүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах
- 5.1е. Үлгэрт амьдралын бодит байдлыг тусгасан эс тусгасан шинжээр нь бодит байдал ба уран сэтгэмжийг ялгах
- 5.1ж. Уншсан эхийн баатруудын харилцан ярианаас тэдний зан чанарыг дүгнэх
- 5.1з. Захидлаас нэг сэдвийн талаар ялгаатай үзэл бодлыг харьцуулж дүгнэх
- 5.1и. Зохиолчийн санааг мэдэрч, уран унших
- 5.1к. Үйл явдал хаана, хэзээ өрнөж байгааг ургуулан бодож төсөөлөх
- 5.1л. Онъсогойн далд утгыг үндэслэлтэй таамаглах

5.2. БИЧИХ

- 5.2а. Залгавар залгахад эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг мэдэж, бүлэглэх, тайлбарлах
- 5.2б. Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрмийг мэдэж, зөв бичих
- 5.2в. Эхийн үйл явдлын орчныг өөрчлөн, богино өгүүллэг зохион бичих
- 5.2г. Зохиолын санааг нэгтгэн дүгнэн товчилж бичих
- 5.2д. Бусдын үзэл бодлыг дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн утгатай захидал бичих
- 5.2е. Өдрийн тэмдэглэлээ бичихдээ сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх
- 5.2ж. Чухал, шинэ үйл явдлыг баримтаар нотлон, бүтцийн дагуу мэдээ бичих
- 5.2з. Бусдын анхаарлыг таттал ятгаж бичих
- 5.2и. Жүжигт баатруудын харилцан яриаг нэмэн бичих
- 5.2к. Адил төстэй шинжийг харьцуулан, утгыг далдлан онъсого зохион бичих
- 5.2л. Баримт, зураг, график хэрэглэн баталгаа нотолгоо гарган санаагаа илэрхийлж бичих
- 5.2м. Өгсөн бүтцийн дагуу үлгэр зохиох

5.3. СОНСОХ-ЯРИХ

- 5.3а. Тодорхой сэдвийн хүрээнд хэд хэдэн зүйлийг харьцуулж, дүгнэх
- 5.3б. Хэлэлцэх, илтгэх үедээ сонссон зүйлийн голыг олж, зөв сонссон гэдгээ илэрхийлэх
- 5.3в. Хэлэлцэх, илтгэх үедээ үзэл бодлоо баримт хэрэглэн товч тодорхой оновчтой илэрхийлэх
- 5.3г. Зохиолын баатрын хэл яриа, үйл хөдлөлийг дуурайн үзэл бодлыг нь илэрхийлэн жүжиглэх

5.4. ХЭЛ ЗҮЙ, ҮГСИЙН САН

- 5.4а. Хашилт, хаалт, цэг тэмдгийг зөв хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох
- 5.4б. Эх, өгүүлбэрт баталсан, дэмжсэн өнгө аясыг илтгэсэн үг, өгүүлбэрийг оновчтой хэрэглэх
- 5.4в. Эх, өгүүлбэр зохиохдоо ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэх
- 5.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

- Монгол хэлний хичээл нь аман зохиол, уран зохиолын болон уран зохиолын бус эхийн агуулгыг уншиж ойлгох, тусган хүлээн авах, боловсруулах, бүтээлчээр зохион найруулж бичих замаар эх хэлээ хэрэглэх, бүтээлчээр сэтгэх арга барил хөгжүүлэх технологид суурилна.
- Хүүхэд бүрийн танин мэдэхүйн хөгжлийн онцлогт тулгуурлан удирдан чиглүүлэх багшийн үйл нь сурагчдын бие даан суралцах арга барилыг хөгжүүлэх зарчим дээр суурилсан арга зүйг баримтална. Үүнд:
 - Суралцахуйг дэмжсэн үйл ажиллагааг өөрийн үнэлгээтэй хослуулах арга зүй
 - Хүүхэд бүр санаа бодлоо солилцох, бусдыг ойлгон сонсох, бусдыг мэдрэх, идэвхтэй, нээлттэй харилцах боломж олгох оролцооны арга зүйг тус тус баримтална.

3.2. Сургалтын орчин

- Монгол хэлний хичээлээр эзэмшсэн мэдлэг чадвараа хэрэглэх, хамтран ажиллах, асуудал шийдвэрлэхүйц бүтээлч үйлийн орчныг бүрдүүлнэ. Үүнд: Асуудал дэвшүүлж шийдвэрлэсэн харилцан яриаг өрнүүлэх орчин, биет зүйл, жүжиг, кино, музей, уран зургийн галерей, үзэсгэлэн, хөшөө дурсгал, газар орныг үзэж сонирхох замаар ажиглах, эргэцүүлэх, тунгаан бодох, ярих, хамтран ярилцах, харилцаа холбоо тогтоох, хэлэлцэх, илтгэх зэрэг оюуны үйлийг хөгжүүлэх орчинг бүрдүүлнэ.
- Идэвхтэй сургалтын аргыг хэрэглэн, сурагчдын хамтран суралцахуй болон асуудлыг олж, шийдвэрлэх бүтээлч хандлагыг идэвхжүүлэх, хийж бүтээх гэсэн оролдлого, санаачилгыг дэмжин туслах сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлнэ.

3.3. Сургалтын хэрэглэгдэхүүн

- Сургуулийн бага насны хүүхдийн нас, сэтгэц, танин мэдэхүйн онцлогт тохирсон аман зохиол, уран зохиолын болон уран зохиолын бус эхүүд
- Сурагчдын хэл ярианы чадварыг хөгжүүлэхэд тэдний хүүхдийн нас, сэтгэц, танин мэдэхүйн онцлогт тохирсон аудио, видео бичлэгүүд
- Төрөл бүрийн зорилготой танилцуулга, захидал, заавар, мэндчилгээ, талархал, өдрийн тэмдэглэл, урилга, уриалга, сонины мэдээ зэрэг уран зохиолын бус эхүүд
- Сурагчийн тайлбар толь, монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, өвөрмөц ба хэвшмэл хэлц үгийн толь гэх мэт толь бичгүүд

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

Үнэлгээнд дараах үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтална.

4.1. Үнэлгээний зорилт

- А. Мэдлэг, ойлголт
- Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар
- В*. Хандлага

* Сурагчийн хандлагыг ажиглалт, ярилцлага, рубрик зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт		Үнэлгээний шалгуур
А. Мэдлэг, ойлголт		А1. Үг, өгүүлбэр, эхийн утга, бүтэц, зүй тогтол, үгийн сан, хэлний хэрэглээ А2. Зөв бичгийн дүрмийн мэдлэг
Б.Мэдлэгээ хэрэглэх чадвар	Унших	Б1. Төрөл бүрийн эхийг уншиж агуулгыг ойлгох Б2. Эхээс чухал хэсгийг ялгаж өөрийнхөөрөө тайлбарлах, зохиолчийн хэлэх гэсэн санааг тунгаан бодож, гол санааг тайлбарлах Б3. Баатрын зан чанарыг үнэлж, өөрийн зан чанартай харьцуулан эргэцүүлэн бодох Б4. Үг, өгүүлбэр, эхийн утгыг ойлгосны үндсэн дээр уран унших Б5. Уншсанаа бусадтай хуваалцан, санаа бодлоо солилцох Б6. Зохиолын баатрыг төсөөлөхдөө өөрийн хандлага, үзэл бодлоо илэрхийлэх, үйл явдлыг таамаглах
	Бичих	Б7. Үсгийг зөв холбон, үгийг үеэр зөв таслан, өгүүлбэр болон оноосон нэрийг том үсгээр эхлэн, эхийг догол мөрөөр зааглан, хичээнгүй бичих Б8. Зохиосон эхдээ өөрийн санаа бодлоо ойлгомжтой, утгын уялдаа холбоотой, зөв бичгийн дүрмийн болон найруулгын алдаагүй илэрхийлэх Б9. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгээр зааглан, утгын уялдаа холбоотой, үгийг оновчтой сонгон зохиох
	Сонсох-ярих	Б10. Авиа, үг, өгүүлбэрийг зөв дуудан хэлж, тод, чанга, өөртөө итгэлтэй, тодорхой ярих Б11. Хэлэлцэх, илтгэх, санал солилцох үедээ үзэл бодлоо бусдад ойлгомжтой илэрхийлэх Б12. Гэр бүл, сургуулийн орчинд харилцахдаа бусдын яриаг анхааралтай сонсох Б13. Ярилцахдаа бусдын яриаг дуустал хүлээцтэй сонсож, ойлгоогүй зүйлээ лавшруулан тодруулж асуух Б14. Бусдын яриаг ойлгон, зөв сонссон гэдгээ илэрхийлэх
В. Хандлага		В1. Ном сонгон унших сонирхолтой болж, номын тэмдэглэлээ бүтээлчээр танилцуулж, харилцах байдал В2. Хичээлийн үйл ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлж, чармайн мэрийх байдал В3. Харилцахдаа өөрийн хувь нэмрээ оруулан идэвхтэй байж, бусдыг ойлгон, хүндэтгэх байдал

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
Мэдлэг, ойлголт	40%
Мэдлэг, ойлголтоо хэрэглэх чадвар	60%

МАТЕМАТИК

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь математикийн суурь мэдлэг, хэл сэтгэлгээнд суралцаж, асуудлыг тооцоолон шийдвэрлэх чадвартай, математикт суралцах хүсэл эрмэлзэлтэй, байгаль орчинд ээлтэй хэрэглээг эрхэмлэх хандлагатай болсон байна.

1.2. Зорилт

- 1.2.1. Сурагч математикийн нэр томьёо, дүрэм, чанар, хамаарал, зүй тогтлын талаар суурь мэдлэг, ойлголттой болох;
- 1.2.2. Математик хэлд суралцан асуудлыг загварчлах, түүнийг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөг гүйцэтгэх, шийдийг шалгах, юмсыг шинж чанараар нь ангилах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, үнэлэх, өөртөө итгэлтэйгээр санаа бодлоо илэрхийлэх, бие даан болон бусадтай хамтран ажиллах чадвар эзэмших;
- 1.2.3. Математикт идэвх оролцоотой суралцах, зорилго, шалгуурт хүрсэн эсэхээ үнэлэх, гүйцэтгэж буй үйлдэлдээ нягт нямбай хандах, хүрээлэн буй орчин, нийгэм соёлын ялгаатай байдлыг ойлгон хүндэтгэх, өдөр тутмын хэрэглээнд хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй хандах.

Математикийн хичээлээр сурагчид асуудал шийдвэрлэх арга барилд суралцана.

Асуудал шийдвэрлэх арга барил	
Асуудалтай танилцах, ойлгох	- Асуудлыг ойлгон, түүнийг шийдэх боломжтой эсэхийг тодорхойлох - Асуудлыг тохирох товч бичиглэл, зураглал, хүснэгт, хялбар графикаар оновчтой илэрхийлэх - Асуудалд холбогдох элементүүдийг ялган таних, тэдгээрийн холбоо хамаарал, ерөнхий хууль зүй тогтлыг олж харах
Асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулах	- Асуудлыг шийдвэрлэх хэд хэдэн арга замыг эрэлхийлж, оновчтойг сонгох - Асуудлыг шийдэх төлөвлөгөө боловсруулах (шийдэлд хүрэх зорилтууд, шийдэх асуултуудын дараалал байдлаар илэрхийлэх) - Мэдээлэлтэй ажиллах үйлийн үе шат, алхмыг тодорхойлох
Төлөвлөгөөг гүйцэтгэх	- Үйлдлийг дарааллаар нь гүйцэтгэх буюу асуултад дэс дараатай хандах - Холбоо хамаарлыг илэрхийлэх хууль, дүрмийн мөн чанарыг ойлгон хэрэглэх - Хийж буй үйлдэл, тооцооллоо алдаагүй, зөв бичиж тэмдэглэх - Боломжуудыг тооцох, тухайн тохиолдлыг шалгах - Диаграмм, график, бүдүүвчийг ойлгомжтой, өгсөн нарийвчлалаар дүрслэх, тайлбарлах - Нэг эсвэл хэд хэдэн зөв шийдлийг олох
Шийдийг шалгах, үнэлэх, тайлбарлах	- Асуудлын шийдэл хэр оновчтой, бүрэн зөв эсэхийг нягтлан шинжлэх, шалгах - Үйлдэл бүрийн учир шалтгааныг тайлбарлах, дүгнэлт гаргах - Дүгнэлтийг бусадтай хэлэлцэн үнэлж сайжруулах, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулан зохицуулах - Шийдэгдсэн асуудалд үндэслэн асуудлыг өргөтгөх, нарийвчлах эсвэл өөр асуудлыг дэвшүүлэх (төсөөтэй ба урвуу бодлого зохиох)

ХОЁР. АГУУЛГА

I АНГИ

- 1.1. ТОО ТООЛОЛ
- 1.1а. Зуу хүртэлх тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, юмсыг дугаарлах
- 1.1б. Юмсын тоо, хэмжээг аравтаар баримжаалан хэлж, түүнийгээ тоолж шалгах
- 1.1в. Хорь дотор аравт хэтрүүлэн нэмэх, аравт задлан хасах; 10, 20-ийн бүтцийг цээжээр хэлэх
- 1.1г. Зуу дотор аравт хэтрүүлэхгүй нэмэх, аравт задлахгүй хасах
- 1.1д. Хорь хүртэлх юмсыг хоёр хэсэгт нэг нэгээр нь хуваарилан хуваах байдлаар тэгш, сондгой тоог таних, арав хүртэлх ижил нэмэгдэхүүний нийлбэрийн утгыг цээжээр хэлэх
- 1.1е. Тоон илэрхийлэл бичиж утгыг олох; нэмэх үйлдлийн байр солих, 0-ийн чанар хэрэглэх; үйлдлийн мэдэгдэхгүй байгаа (дүрсээр тэмдэглэсэн) гишүүний утгыг олох, математик бичвэрийг үнэн болгох тоо, тэмдэг бичих
- 1.1ж. Тоог 1, 2, 5, 10-аар нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, дараалуулан байрлуулсан тоо, дүрс, юмсын зүй тогтлыг олох
- 1.1з. Энгийн бодлогыг загварчлах, бодох, хариуг шалгах, өгсөн загвар, зураг дүрслэлд тохирох энгийн бодлого зохиох
- 1.2. ХЭМЖИГДЭХҮҮН
- 1.2а. Хугацааг хэмжих нэгжүүдийг (цаг, хоног, долоо хоног, сар, улирал) таних, цуврал зургийг үйл явдлын дарааллаар эрэмбэлэх
- 1.2б. Мөнгөн дэвсгэртийг таних, задлах, бүхэлдэх
- 1.2в. Урт, хүнд, эзлэхүүнийг (шингэний хэмжээ, савны багтаамж) харьцуулан эсвэл стандарт бус хэмжих нэгж хэрэглэн жиших, урт, богино, хүнд, хөнгөн, их, бага, ижил, тэнцүү зэрэг үг хэрэглэн тайлбарлах, уртын хэмжээг сантиметрээр илэрхийлэн бичих
- 1.3. ГЕОМЕТР
- 1.3а. Цэг, хэрчим, тахир шугам, гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрсийг таньж нэрлэх, эдгээр дүрсийг хоёр тэнцүү хэсэг болгон нугалах аргаар тэгш хэмтэй эсэхийг таних, биет болон хэв хэрэглэн дүрс зурах, бүтээл хийх
- 1.3б. Орон зай, чиглэл, хөдөлгөөнтэй холбоотой үг хэллэг хэрэглэн гэр, сургуулийн орчин дахь юмс, аюулгүй тоглох зорчих замын байршлыг хэлэх
- 1.4. ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ
- 1.4а. Юмсыг (өнгө, хэлбэр, хэмжээ) нэг, хоёр шинжээр Карроллын диаграмм хэрэглэн ангилах
- 1.4б. Асуулт асууж, хариултыг хүснэгтэд бүртгэх, зурган диаграммыг (пиктограмм) унших, илэрхийлэх

II АНГИ

- 2.1. ТОО ТООЛОЛ
- 2.1а. Мянга хүртэлх тооны орны утгыг нэрлэх, тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх
- 2.1б. Аравт, зуутыг тэмдэглэсэн хуваарьтай тоон шулуун дээр мянга хүртэлх тоог цэгээр тэмдэглэн аравт, зуутаар тоймлох

- 2.1в. Тууз, дүрсийг 2, 4 тэнцүү хэсэгт хувааж, хагас, хагасын хагасыг тэмдэглэсэн тэмдэглэгээний $\frac{1}{2}$, $\frac{1}{4}$ утгыг тайлбарлах
- 2.1г. Мянга дотор тоог орны нэмэгдэхүүний нийлбэрт задлаж болон задлахгүйгээр нэмэх, хасах
- 2.1д. Ижил нэмэгдэхүүний нийлбэрийг үржвэр хэлбэрээр бичих, юмсыг хуваарилах, багцлах, үлдэгдэлтэй хуваах, хүрд хэрэглэн үржүүлэх, хуваах
- 2.1е. Нийлбэрийн утга нь 100 байх аравтууд, 1000 байх зуутуудыг бичих, тоог аравтаар тоймлон нэмэх, тавь хүртэлх тоог 2 дахин ихэсгэх, багасгах үйлдлийг цээжээр гүйцэтгэх
- 2.1ж. Үйлдлийн дараалал тогтоон тоон илэрхийллийн утгыг олох; хоёр тоон илэрхийллийн утгыг олж буюу олохгүйгээр жиших; байр солих, бүлэглэх, нийлбэр, ялгаврыг тоогоор үржүүлэх чанарыг хэрэглэн тооцоолол хийж шалгах
- 2.1з. Үйлдлийн нэг гишүүнийг бусад гишүүнээр илэрхийлэн утгыг олох, математик бичвэрийг үнэн болгох тоо, тэмдэг бичих, тайлбарлах
- 2.1и. Тоог нэгжээр, 10, 100-аар нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, дараалуулан байрлуулсан тоо, дүрс, юмсын зүй тогтлыг олох, үргэлжлүүлэх
- 2.1к. Бодлогыг загварчлах, төлөвлөгөө бичиж бодох, бодсон хариуг шалгах, өөр аргаар бодох, өгсөн загвар, бичвэрт тохирох энгийн бодлого зохиох, төсөөтэй ба урвуу бодлого зохиох
- 2.2. ХЭМЖИГДЭХҮҮН
- 2.2а. Хугацааг тохирох нэгжээр (минут, цаг, хоног, долоо хоног, сар, жил) илэрхийлэх, жиших, аналог цагийг 30 минут, 5 минутын нарийвчлалтай унших, үйл явдлын эрэмбэ дараалал, үргэлжлэх хугацааг тооцоолох
- 2.2б. Мөнгөн дэвсгэртийг задлах, бүхэлдэх, хариултыг тооцоолох
- 2.2в. Урт, хүнд, эзлэхүүнийг (шингэний хэмжээ, савны багтаамж) хэмжих, хэмжээг унших, бичих, жиших, хэмжих хэрэгслийн хуваарийн утгыг тайлбарлах, хэмжээг тохирох нэгжээр (мм, см, дм, м, кг, л) илэрхийлэх, баримжаалан хэлэх, уртын хэмжээг уламжлалт нэгжээр (сөөм, төө, тохой, алд, дэлэм, алхам) баримжаалах, дүрсийн талын уртыг хэмжих, томьёо хэрэглэхгүй хүрээний уртыг олох
- 2.3. ГЕОМЕТР
- 2.3а. Цацраг, өнцөг, тэгш өнцөг, олон өнцөгтийг (дөрвөн өнцөгт, таван өнцөгт, зургаан өнцөгт) нэрлэх, хоёр тэнцүү хэсэг болгон нугалах аргаар тэгш хэмтэй дүрсийг таних, дүрс, биет хэрэглэн бүтээл хийх
- 2.3б. Гэр, сургуулийн орчин, зураг дээрх юмсын байршлыг хэлэх; баганыг үсгээр, мөрийг тоогоор тэмдэглэсэн хүснэгт дэх дүрсийн байршлыг бичих, заасан байршилд зурах
- 2.4. ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ
- 2.4а. Юмсыг нэг, хоёр шинжээр Карролын диаграмм хэрэглэн ангилах, тайлбарлах
- 2.4б. Өгөгдөл, мэдээллийг цуглуулах, хүснэгтэд бүртгэх, зурган диаграммаар илэрхийлэх, тайлбарлах
- 2.4в. Хоёр буюу нэг олонлогоос хос үүсгэх

III АНГИ

- 3.1. ТОО ТООЛОЛ
- 3.1а. Арван мянга хүртэлх натурал тооны орны утгыг нэрлэх, тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх
- 3.1б. Аравт, зуут, мянгатыг тэмдэглэсэн хуваарьтай тоон шулуун дээр арван мянга хүртэлх натурал тоог цэгээр тэмдэглэн аравт, зуут, мянгатаар тоймлох

- 3.1в. Сөрөг тоог унших, бичих, термометр, тоон шулуун хэрэглэн жиших, эрэмбэлэх, тоон шулуун дээр 0 хэтрүүлж 1-ээр нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох
- 3.1г. 2, 3, 4, 5, 6, 8, 10 хуваарьтай энгийн бутархайг унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, ижил хуваарьтай энгийн бутархайг жиших, эрэмбэлэх
- 3.1д. Арван мянга дотор тоог орны нэмэгдэхүүний нийлбэрт задлах, нэмэх, хасах, аравт, зуутагд ойр байх хоёр тоог цээжээр нэмэх, хасах, ойролцоогоор тооцоолох
- 3.1е. Арван мянга дотор тоог 10, 100, нэгжээр үржүүлэх, 10, 100, нэгжид хуваах, үлдэгдэлтэй хуваах, нэг тоо нөгөө тооноосоо хэд дахин бага (их) үед эдгээр хоёр тооны нийлбэрээр (зөрөөгөөр) тоо тус бүрийг олох, аравт, зуутыг 2 дахин ихэсгэх, багасгах үйлдлийг цээжээр гүйцэтгэх
- 3.1ж. Тоон илэрхийлэл, тоон тэнцэтгэл, тоон тэнцэтгэл биш бичих, зохиох, нэмэх, үржүүлэх үйлдлийн чанар хэрэглэн тооцоолол хийж шалгах
- 3.1з. Үйлдлийн нэг гишүүнийг бусад гишүүнээр илэрхийлэн утгыг олох; математик бичвэрийг үнэн утгатай болгох, үйлдлийн гишүүдийн хамаарлыг тайлбарлах
- 3.1и. Тоо, хэмжээний 2, 3, 4, 5, 6, 8, 10-ны хэсгийг олох, нийлбэр нь 1-ээс хэтрэхгүй үед ижил хуваарьтай энгийн бутархайнуудыг нэмэх, хасах
- 3.1к. Тоог тогтмол тоогоор нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, дараалуулан байрлуулсан тоо, дүрс, юмсын зүй тогтлыг олж үргэлжлүүлэх, орхисон гишүүнийг олох
- 3.1л. Бодлогыг загварчлах, бодох хялбар аргыг сонгон төлөвлөгөө бичих, тохирох үйлдлийг гүйцэтгэх, хариуг таамаглан урвуу үйлдэл болон бусад аргаар шалгах, өгсөн зураглал бичвэрт тохирох 2-3 алхамтай өгүүлбэртэй бодлого зохиох, өөрийн хэрэглээнд хэмнэлттэй тооцоо хийх асуудлыг шийдвэрлэх
- 3.2. ХЭМЖИГДЭХҮҮН
- 3.2а. Хугацааг тохирох нэгжээр (секунд, минут, цаг, хоног, сар, жил, жаран, зуун) илэрхийлэх, жиших, үргэлжлэх хугацааг тооцоолох
- 3.2б. Тохирох хэрэгсэл, хэмжих нэгжийг (мм, см, дм, м, км, г, кг, ц, т, мл, л) сонгон урт, хүнд, эзлэхүүнийг (шингэний хэмжээ, савны багтаамж) хэмжих, хэмжээг жиших, баримжаалах, хэмжих хэрэгслийн хуваарийн утгыг тайлбарлах, нэг нэгжийг нөгөө нэгжээр илэрхийлэх, дүрсийн хүрээний уртыг олох
- 3.2в. Нэгж квадратыг тоолж талбайн хэмжээг олох, талбайн хэмжээг сантиметр квадратаар илэрхийлэх; кубын дэлгээсийн талбайн хэмжээг олох
- 3.3. ГЕОМЕТР
- 3.3а. Харилцан эгц (перпендикуляр), зэрэгцээ (параллел) шулуун, тэгш, хурц, мохоо өнцөг, олон өнцөгт, тойрог, дугуй дүрсийг нэрлэх, зурах, бүтээл хийх, дүрсийн тэгш хэмийн тэнхлэгийг зурах
- 3.3б. Куб, түүний дэлгээсийг таних, өгсөн дэлгээсээр нь бүтээх
- 3.3в. Гэр, сургууль орчны зам, тоглох газрын байршлыг хэлэх; зураг, хүснэгт дэх дүрс, юмсын байршлыг бичих, заасан байршилд хүрэх зам, чиглэлийг тодорхойлох, шилжүүлэх
- 3.4. ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ
- 3.4а. Юмсыг нэг, хоёр шинжээр Карролл, Эйлер-Веннийн диаграмм хэрэглэн ангилах
- 3.4б. Ажиглалт, хялбар туршилтаар өгөгдөл, мэдээллийг цуглуулах, хүснэгтэд бүртгэх, зурган, баганан диаграммаар илэрхийлэн асуултад хариулах
- 3.4в. Модны загвар хэрэглэн боломжийг тооцоолох

IV АНГИ

4.1. ТОО ТООЛОЛ

- 4.1a. Сая хүртэлх натурал тооны орны утгыг нэрлэх, тоог унших, бичих, жиших, эрэмбэлэх, тоймлох
- 4.1б. Сөрөг тоог тоон шулуун дээр цэгээр тэмдэглэн жиших, эрэмбэлэх, 1, 2-оор нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох
- 4.1в. Холимог бутархайг унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, холимог бутархайг засагдах бутархай, засагдах бутархайг холимог бутархай хэлбэрээр бичих, натурал тооны үлдэгдэлтэй хуваах үйлдэлтэй холбон тайлбарлах
- 4.1г. Хуваарь нь 10, 100 байх энгийн бутархайг аравтын бутархайгаар илэрхийлэх, натурал тоог 10, 100-д хуваах үйлдэлтэй холбон аравтын бутархайн орны утгыг нэрлэх, бутархай хэсэг нь хоёр орноос хэтрэхгүй байх аравтын бутархайг унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, бүхлээр тоймлох
- 4.1д. Сая дотор тоо, хэмжээг нэмэх, хасах, зуут, мянгатад ойр тоог цээжээр нэмэх, хасах
- 4.1е. Хоёроос дөрвөн оронтой тоог нэг, хоёр оронтой тоогоор үржүүлэх, хуваах; хоёр оронтой тоог хэд хэдэн тооны үржвэр хэлбэртэй бичих, тооны 2, 5, 10, 25, 50, 100-д хуваагдах шинжийг хэрэглэн цээжээр тооцоолох
- 4.1ж. Үйлдлийн гишүүдийн хамаарал болон үйлдлийн чанарыг хэрэглэн тооцоолол хийж, тоон илэрхийлэл зохиох; тэгшитгэл, тэнцэтгэл бишийг бодох, шалгах
- 4.1з. Ижил хуваарьтай энгийн бутархай, холимог бутархайг нэмэх, хасах, хэсгийн бодлогыг бодох
- 4.1и. Хэрчим, дүрс, юмсын бодит хэмжээг хэд дахин багасгаж (ихэсгэж) зурах, тоо хэмжээг өгсөн харьцаагаар хуваах, тэнцүү харьцааг бичих, пропорцын мэдэгдэхгүй байгаа гишүүнийг олох
- 4.1к. Аравтын бутархайг нэмэх, хасах, нийлбэр нь 1 эсвэл 10 байх хоёр аравтын бутархайг цээжээр хэлэх
- 4.1л. Тоог тогтмол тоогоор нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, дараалуулан байрлуулсан тооны зүй тогтлыг олж үргэлжлүүлэх, зохиох
- 4.1м. Пропорционал хамаарлын бодлогыг хүснэгтээр илэрхийлэх, графикийг тайлбарлах, төлөвлөгөө бичиж бодох, шалгах, өгсөн зураглал, бичвэртэй холбоотой асуулт асуух, бодлого зохиох, логик бодлого бодох, байгаль орчинд ээлтэй, ахуйн хэрэглээнд хэмнэлттэй тооцоо хийх зэрэг асуудлыг шийдвэрлэх

4.2. ХЭМЖИГДЭХҮҮН

- 4.2a. Цагийн хуваарь хэрэглэн үргэлжлэх хугацааг тооцоолох
 - 4.2б. Урт, хүнд, эзлэхүүнийг (шингэний хэмжээ, савны багтаамж) хэмжих, жиших, нэг нэгжийг нөгөө нэгжээр илэрхийлэх, хэмжээг энгийн бутархайгаар илэрхийлэх, талуудыг аравтын бутархайгаар илэрхийлсэн дүрсийн хүрээний уртыг олох
 - 4.2в. Тэгш өнцөгт параллелепипедийн эзлэхүүнийг нэгж куб (шоог) тоолон хэмжих, см.куб нэгжээр илэрхийлэх
 - 4.2г. Талбайн хэмжээг олж, тохирох нэгжээр (см.кв, дм.кв, м.кв, км.кв) илэрхийлэх, палетка хэрэглэн дүрсийн талбайн хэмжээг олох
 - 4.2д. Тэгш өнцөгт параллелепипедийн гадаргуугийн талбайн хэмжээг олох
- ##### 4.3. ГЕОМЕТР
- 4.3a. Өнцгийг тэмдэглэн транспортироор хэмжих, хэмжээг унших, бичих; зөв олон өнцөгтийг таних
 - 4.3б. Тэгш өнцөгт параллелепипед, цилиндрийг таних, өгсөн дэлгээсээр нь бүтээх

- 4.3в. Орчны план зураг, зорчих замын зургийг уншиж тайлбарлах, координатын хавтгайн I мөч дэх цэгийн координатыг унших, бичих, өгсөн координатаар цэг тэмдэглэх
- 4.3г. Аль нэг тал нь тэгш хэмийн тэнхлэгтэй параллел байх дүрсийг тэнхлэгийн тэгш хэмээр хувиргах
- 4.3д. Хэрчим, тэгш өнцөгт гурвалжныг параллелээр зөөх
- 4.3е. Хэрчим, тэгш өнцөгт гурвалжныг нэг оройн хувьд цагийн зүүний дагуу 90° эргүүлэх, зурах
- 4.4. ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ
- 4.4а. Юмсыг нэг, хоёр шинжээр Карролл, Эйлер-Веннийн диаграмм хэрэглэн ангилах, тайлбарлах
- 4.4б. Өгөгдөл, мэдээлэл цуглуулан хүснэгтэд бүртгэх, диаграммаар илэрхийлэх, багана диаграммын хуваарь нь ялгаатай байх үеийн дүрслэлийг харьцуулан асуултад хариулах, графикийг тайлбарлах
- 4.4в. Ажиглалт, туршилтаар боломжтой, боломжгүй үзэгдлийг тогтоох
- 4.4г. Боломжийн тоог тооцоолох

V АНГИ

- 5.1. ТОО ТООЛОЛ
- 5.1а. Олон оронтой тоог унших, бичих, жиших, эрэмбэлэх, тоймлох, ром тоог унших, бичих
- 5.1б. Сөрөг тоог нэгжээр нэмэгдүүлэн, хорогдуулан тоолж, тоон шулуун хэрэглэн зөрөөг олох
- 5.1в. Нэг нь нөгөөгийн хуваагдагч байх ижил бус хуваарьтай энгийн бутархайг тоон шулуун дээр цэгээр тэмдэглэн жиших, эрэмбэлэх
- 5.1г. Бутархай хэсэг нь гурван орноос хэтрэхгүй байх аравтын бутархайн орны утгыг нэрлэх, унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, бүхлээр болон аравны, зууны хэсгээр тоймлох
- 5.1д. Олон оронтой тоо, хэмжээг нэмэх, хасах, зуут, мянгатад ойр тоонуудыг цээжээр нэмэх, хасах
- 5.1е. Олон оронтой тоог үржүүлэх, хуваах; тооны 2, 4, 5, 10, 25, 50, 100-д хуваагдах шинж хэрэглэн цээжээр тооцоолох, хоёр тооны ерөнхий хуваагч, ерөнхий хуваагдагчийг олох
- 5.1ж. Үйлдлийн гишүүдийн хамаарал болон үйлдлийн чанарыг хэрэглэн тооцоолол хийж, тэгшитгэл, тэнцэтгэл бишийг бодож шалгах, зохиох, тайлбарлах
- 5.1з. Нэг нь нөгөөгийн хуваагдагч байх ижил бус хуваарьтай энгийн бутархайг нэмэх, хасах
- 5.1и. Харьцаа, пропорц, масштабыг тооцоололд хэрэглэх
- 5.1к. Процентыг тэмдэглэх, тоо, хэмжээний 2, 4, 5, 10, 20, 100-ны хэсгийг процентоор илэрхийлэх; тоо, хэмжээний 50%, 25%, 20%, 10%, 5%, 1% процентод ногдох тоо, хэмжээг олох, 50%, 25%, 20%, 10%, 5%, 1% процентод ногдох тоо, хэмжээгээр уг тоо, хэмжээг олох, нэг тоо хэмжээ нөгөө тоо хэмжээний хэдэн процент болохыг олох
- 5.1л. Аравтын бутархайг нэмэх, хасах; натурал тоог аравтын бутархайгаар нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох; аравтын бутархайг 10, 100, 1000, нэгжээр үржүүлэх, тоог 10, 100, 1000, нэгжид хуваах (ногдворын утгын бутархай хэсэг 3 орноос хэтрэхгүй байх)
- 5.1м. Дараалуулан байрлуулсан тооны зүй тогтлыг олж үргэлжлүүлэх, зохиох
- 5.1н. Процент, масштаб бүхий бодлогыг загварчлах, бодох, зохиох, хариуг таамаглах, шалгах, тоон таавар, логик бодлого бодох, байгаль орчин, эрүүл мэндэд ээлтэй, ахуй хэрэглээнд хэмнэлттэй тооцоо хийх зэрэг асуудлыг шийдвэрлэх

5.2. ХЭМЖИГДЭХҮҮН

- 5.2a. Цаг тооны бичиг хэрэглэн үргэлжлэх хугацааг тооцоолох
- 5.2б. Урт, хүнд, эзлэхүүнийг (шингэний хэмжээ, савны багтаамж) энгийн болон аравтын бутархайгаар илэрхийлэх, жиших, бүхлээр тоймлох, нэг нэгжийг нөгөө нэгжээр илэрхийлэх, дүрсийн периметрийг олох
- 5.2в. Куб, тэгш өнцөгт параллелепипедийн эзлэхүүнийг олж тохирох нэгжээр (см.куб, дм.куб, м.куб) илэрхийлэх
- 5.2г. Талбайн хэмжээг олж, тохирох нэгжээр (см.кв, дм.кв, м.кв, км.кв, а, га) илэрхийлэх

5.3. ГЕОМЕТР

- 5.3a. Гурвалжныг ангилах, гурвалжны дотоод өнцгийн нийлбэр 180° , дөрвөн өнцөгтийн дотоод өнцгийн нийлбэр 360° болохыг тогтоох
- 5.3б. Призм, пирамидыг таних, дэлгээсээр нь бүтээх
- 5.3в. План зураг, аяллын замын зургийг тайлбарлах, зурах, координатын хавтгайн I мөч дэх цэгийн координатыг унших, бичих, цэгийн координат өгсөн үед дүрс байгуулах
- 5.3г. Дүрсийг тэнхлэгийн хувьд тэгш хэмтэй хувиргах, бүтээл хийх
- 5.3д. Дүрсийг параллелээр зөөх
- 5.3е. Тэгш өнцөгт гурвалжныг нэг оройн хувьд 90° эргүүлэх, зурах

5.4. ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ

- 5.4a. Судалсан агуулгын хүрээнд дүрс, тоо, юмсыг нэг, хоёр шинжээр ангилан Карролл, Эйлер-Веннийн диаграмм хэрэглэн дүрслэх
- 5.4б. Өгөгдөл, мэдээллийг цуглуулах, бүртгэх, диаграммаар илэрхийлэх, баганан диаграммын хуваарь нь ялгаатай байх үеийн дүрслэлийг тайлбарлан дүгнэлт гаргах; дугуй диаграммыг унших, график байгуулах
- 5.4в. Өгөгдлийн далайц, арифметик дунджийг олох
- 5.4г. Ажиглалт, туршилтаар боломжтой, боломжгүй үзэгдлийг тогтоох, таамаглал дэвшүүлэн шалгах
- 5.4д. Боломжийн тоог тооцоолох, дүгнэлт гаргах

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Бага боловсролын математикийн сургалтын хөтөлбөр нь сурагч математикт сонирхолтой, асуудлыг тооцоолон шийдвэрлэх чадвартай, зурах үйл ажиллагааны явцад өөртөө зорилго дэвшүүлэн, түүндээ хүрэх эрмэлзэлтэй, суралцах арга барилыг эзэмшихэд чиглэнэ.

3.1. Багшлах арга зүй

Сурагчийн нас, хөгжлийн онцлог, суралцах хэв маяг, ялгаатай байдлыг харгалзан сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хөгжүүлэхдээ дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Сургалтын зорилго, зорилтыг сурагчийн хэрэгцээ, мэдлэг, чадварт баримжаалан тодорхойлох
- Судлагдахууны агуулгад тогтолцооны шинжилгээний үүднээс хандах, дидактик нэгжийг томсгох, нягтруулах, интеграцчилах
- Математикийн тэмдэг, тэдгээрийг бичих, ухагдахуун, тодорхойлолт, дүрэм, томъёог эх хэлээрээ яруу тод илэрхийлэх, хэрэглэх
- Мэдлэгийн төрлүүд (баримтын, үйлийн болон метакогнитив)-ийг сургалтад бүтээлчээр хэрэглэх

- Гэр, сургууль, орон нутаг, бүс нутаг, үндэсний болон дэлхийн хэмжээний асуудлыг сонгох, сурагч сурах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож мэдлэг бүтээх, асуудал шийдвэрлэх, өөрийгөө танин мэдэх, үнэлэх, зэрэг зан үйлд суралцаж, хөгжиж өөрчлөгдөхөд нь хөтлөн чиглүүлэх, сургалтын материаллаг, сэтгэл зүйн болон аюулгүй, эрүүл таатай орчин бүрдүүлэх
- Танин мэдэхүйн ерөнхийлөх, тусгайлах, харьцуулах, загварчлах, задлан шинжлэх, эвлүүлэх зэрэг ерөнхий болон тооцоолох, батлах зэрэг аргуудыг хэрэглэн учир шалтгааныг тайлбарлах
- Дэлхийн иргэний боловсрол, тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа, мэдээлэл харилцааны дэвшилтэт технологийг хэрэглэх
- Сурагчийн мэдлэг, чадварыг тэдгээрийн гүйцэтгэж буй танин мэдэхүйн үйл, үйлдэл, үйл ажиллагааны чанар, шалгуураар үнэлэх, хөгжүүлэх, суралцахуйг дэмжиж чиглүүлэхэд өөрийн болон явцын үнэлгээний арга, хэлбэрүүдийг хэрэглэн дүн шинжилгээ хийж, сургалтын үйл ажиллагааг сайжруулах

3.2. Суралцах арга барил

Математикт суралцахуй нь эзэмшихүйн зүй тогтлын дагуу сурагч танин мэдэх бүтээлч үйл ажиллагаагаараа мэдлэг бүтээн хэрэглэх зарчимд тулгуурласан байна.

Сурагч математикийн үйл ажиллагааг гүйцэтгэх явцад:

- Сэдэв, асуудлын хүрээнд бодит юмс, зураглал, бичвэр зэргийг ажиглах, турших, судлах, таамаглал дэвшүүлэх, загварчлах, хийж бүтээх, эргэцүүлэн бодох, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, үнэлэх, асуудал шийдвэрлэх, хэлэлцэх явцад мэдлэг бүтээх
- Эмх цэгцтэй, бүтээлчээр сэтгэх, эзэмшсэн мэдлэг, чадвар, математик хэл, сэтгэлгээнд тулгуурлан санаа бодлоо өөртөө итгэлтэйгээр илэрхийлэх, учир шалтгааныг тайлбарлах, бие даан болон бусадтай хамтран ажиллах чадвараа хөгжүүлэх
- Асуудалтай танилцан зорилгоо тодорхойлох, түүнийг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, гүйцэтгэл болон шийдлийг хянах, үнэлэх, задлан шинжлэх, эргэцүүлэн дүгнэх зэргээр асуудлыг шийдвэрлэх арга барил эзэмших, туршлага хуримтлуулах, өөрийн удирдлага, хянан зохицуулалттай суралцах
- Математикт идэвх оролцоотой суралцах, зорилгодоо хүрсэн эсэхээ үнэлэх, асуудалд нягт нямбай, хариуцлагатай хандах
- Хүрээлэн буй орчин, нийгэм соёлын ялгаатай байдлыг ойлгон, бусдын гаргасан тооцоо шийдвэрт хүндэтгэлтэй хандах
- Өдөр тутмын хэрэглээнд хэмнэлттэй, эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй хандах

3.3. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

Сурагчийг хөгжүүлэх зорилгоор багш сургалтын үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хөгжүүлэхдээ сурах бичиг, зөвлөмжөөс гадна дэмжлэг болох бусад хэрэглэгдэхүүнийг (гарын авлага, тараах материал, багаж хэрэгсэл гэх мэт) сурагчийн мэдлэг, чадвар, сурах хэв маяг, танин мэдэхүйн түвшний ялгаатай байдал, орон нутаг, сургуулийн онцлог, хэрэглэгдэхүүний олдоц, бэлтгэх, боловсруулах боломж зэргийг харгалзан сонгоно.

Үзүүлэн, тараах материалыг сонгох буюу бэлтгэхдээ I-V ангид хэрэглэх боломжтой, байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд хэмнэлттэй, эрүүл ахуйн болон хэрэглэгдэхүүнд тавих шаардлагыг хангасан, сурагчдыг идэвхжүүлэх, тэдний мэдлэг бүтээх, бие даан болон хамтран суралцахад дэмжлэг болох, анги нийтийн өмнө хэрэглэхэд тохирсон том болон сурагч бүр хэрэглэхэд тохирсон жижиг хэмжээтэй, хүрэлцэхүйц тоотой байхад анхаарна.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох зарим хэрэглэгдэхүүний жагсаалтыг агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг бүрээр дор үзүүлэв. Үүнд:

“Тоо, тоолол” агуулгын хүрээнд

- Бодит юмс, тэдгээрийн загвар болох тоолох хэрэгсэл (товч, угсардаг шоо гэх мэт), бодит юмсын зураг
- Тооны орон, ангийн хүснэгт, тууз, тооны орны утгын хүснэгт, тооны орны утгын карт, смпин
- Тоо, цифр, үйлдлийн тэмдэг, математик бичвэр (тоон илэрхийлэл, тэнцэтгэл, тэнцэтгэл биш) бичсэн картууд
- Сэдэв, агуулгатай холбоотой үзүүлэн (үржүүлэхийн хүрд гэх мэт)
- Хуваарьтай тоон хэрчим буюу шулууны загвар (саваа, шугам гэх мэт)
- Хүснэгт: а) тоо бичсэн б) тоо бичээгүй (зуугийн хүснэгт гэх мэт)

“Хэмжигдэхүүн” агуулгын хүрээнд

- Урт, хүнд, эзлэхүүнийг нь хэмжих бодит юмс, шошго
- Хэмжигдэхүүний хэмжих нэгжүүдийн хамаарлын үзүүлэн
- Хэмжих багаж хэрэгсэл
- Уртыг хэмжих стандарт бус нэгжийг төлөөлөх юмс, тууз, олс, шугам, метр
- Хүндийг хэмжих жинлүүр, хуваарьтай жин
- Эзлэхүүнийг хэмжих, харьцуулахад хэрэглэх хоосон сав, аяга, миллилитрийн болон литрийн хуваарьтай сав гэх мэт
- Талбай хэмжигч (палетка), нэгж квадрат, шоо, түүнийг хийх сав
- Хугацааг хэмжих аналог, дижитал цаг, цаг тооны бичиг

“Геометр” агуулгын хувьд

- Дүрс, зураг, “Эв долоо” танграмм гэх мэт
- Гортиг, шугам, транспортер, өнцгийн эвхмэл загвар, толь
- Биет, дэлгээс, зураг, дэлгээс хийхэд хэрэглэх хайрцаг, цаас
- Тоглоомын хөлөг (шатар, даам, үндэсний тоглоом)
- Хүснэгт, геосамбар, геохуудас, координатын хавтгайн I мөчийг дүрсэлсэн үзүүлэн
- Тодорхой масштабтай газрын болон байршлын зураг

“Өгөгдөлтэй ажиллах” агуулгын хувьд

- Анги нийтэд болон сурагчдад зориулсан Карролл, Эйлер-Веннийн диаграммын загвар (хүснэгт, цаас, цагариг, олс гэх мэт)
- Ангилал юмсын зургийг дүрсэлсэн, эсвэл шинжийг бичсэн картууд
- Бодит юмс, ахуйн амьдралын агуулгатай өгөгдөл, мэдээлэл (хүснэгт, диаграмм, график, бичвэр гэх мэт)
- Туршилтын дүн (бичвэр, хүснэгт, зураг, диаграмм)

Бусад хэрэглэгдэхүүн

- Ахуй амьдрал, тогтвортой хөгжлийн боловсролын агуулгатай мэдээлэл (бичвэр, хүснэгт, диаграмм гэх мэт)
- Сурагчдын бие даан болон хамтран суралцах үйл ажиллагааг хөтлөх үйл ажиллагаа, дадлага ажлын удирдамж буюу ажлын хуудас
- Явцын болон өөрийн үнэлгээнд хэрэглэх рубрик, сурагчдын бүтээлийн сан, гэрлэн дохио, цагаан самбар, танин мэдэхүйн түвшин болон ялгаатай байдлыг харгалзан боловсруулсан даалгаврын сан гэх мэт.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

Үнэлгээнд дараах зорилт, шалгуур, жинг баримтална.

4.1. Үнэлгээний зорилт

- А. Математикийн мэдлэг, ойлголт
- Б. Математикийн мэдлэг, ойлголтоо хэрэглэх чадвар
- В*. Хандлага

* Сурагчийн хандлагыг ажиглалт, ярилцлага, рубрик зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Мэдлэг, ойлголт	А1. Математикийн үг хэллэг, нэр томьёо, ойлголт (тоо, хэмжээ, дүрс, биет, байршил, масштаб, диаграмм, график гэх мэт) А2. Дүрэм, зүй тогтол, холбоо хамаарал
Б. Мэдлэг хэрэглэх	Б1. Математикийн мэдлэг, ойлголтоо танил болон танил бус нөхцөлд хэрэглэх Б2. Асуудлыг тохирох товч бичиглэл, зураглал, хүснэгтээр илэрхийлэх Б3. Асуудлыг шийдвэрлэх оновчтой аргыг сонгох, төлөвлөх Б4. Төлөвлөгөөг хэрэгжүүлж, математик арга техникийг хэрэглэн тооцооллыг зөв гүйцэтгэх Б5. Үр дүнгээ шалгах, үндэслэлтэй тайлбарлах
В. Хандлага	В1. Сонирхол, идэвх оролцоо В2. Бүтээлчээр хандах байдал В3. Гүйцэтгэлд нягт нямбай хандах байдал В4. Байгаль экологид ээлтэй, хэмнэлттэй хэрэглээг эрхэмлэх байдал В5. Өөрийн болон бусдын шийдлийн талаар эргэцүүлэн дүгнэх байдал

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
А. Мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгавар	40%
Б. Мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх даалгавар	60%

ХҮН БА ОРЧИН

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь хүрээлэн буй орчноо танин мэдэх явцад өөрийгөө нээх, сурах арга барил эзэмших, эрүүл зөв аж төрөх дадал, зан үйлд суралцана.

1.2. Зорилт

- 1.2.1. Хүрээлэн буй орчны юмс үзэгдэл, баримтын мэдлэг, нийгэм, хүмүүс хоорондын харилцаа, аюулгүй ажиллагааны ойлголттой болох;
- 1.2.2. Орчин тойрноо сонирхон судлах замаар баримт нотолгоо цуглуулж, ажиглалт, хэмжилт, тооцоолол хийн, гарсан үр дүнг танилцуулах чадвар эзэмших;
- 1.2.3. Сургууль, нийгмийн амьдралд дасан зохицож, хэм хэмжээг эрхэмлэдэг, үндэсний соёл, өв уламжлалаа дээдэлдэг, хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалахад өөрийн хувь нэмрээ оруулах хүсэл тэмүүлэлтэй болох.

“Хүн ба орчин”-ы сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	I анги	II анги	III анги
Сонирхон судлах	- Хүрээлэн буй орчноо ажиглах /танилцах/ - Сонирхсон зүйлийн талаар асуулт асуух - Юу болохыг баримжаалах - Асуултад хариулт авч мэдээлэл цуглуулах - Хичээлийн хэрэглэлээ бэлтгэх, сонгох - Хичээлийн хэрэглэлийг зориулалтын дагуу хэрэглэх, зааварчилгааг сахих - Болсон зүйлийг таамаглалтай харьцуулах - Шинэ санааг дүрс, зургаар илэрхийлэх - Шинэ санааг тайлбарлах, харилцах	- Ажиглалт хийнгээ баримт нотолгоо цуглуулах - Асуулт асуух явцдаа шинэ санаа олох - Яагаад гэдгийг таамаглах, юу хийхээ бодох - Багшийн болон бусдын дэмжлэгтэйгээр шинэ мэдээлэл цуглуулах - Хаана, юуг, хэзээ хэрэглэх, зөв сонгохоо төлөвлөх - Энгийн багаж хэрэгсэлийг ашиглан хэмжилт хийх, аюулаас зайлсхийх - Болсон зүйл, таамаглалын хамаарлыг тодорхойлох - Үр дүнг зураг, бичвэр, хэлбэрээр илэрхийлэх, хүснэгтэн мэдээллийг унших - Таамаглал, гарсан үр дүн болон яагаад ийм зүйл болсныг тайлбарлах	- Ажиглалтын явцад цуглуулсан баримт нотолгоо ялгаатай болохыг илрүүлэх - Асуулт асууж эргэлзээтэй зүйлсийг тодруулахыг хичээх - Багшийн болон бусдын дэмжлэгтэйгээр таамаглалаа шалгах талаар төсөөлөх - Багшийн болон бусдын дэмжлэгтэйгээр харилцан хамаарал ба ялгаатай мэдээллийг цуглуулах - Ажиглалт, туршилтад хэрэглэх багаж хэрэгслийг сонгох, юуг хэмжихээ шийдвэрлэх - Энгийн багаж хэрэгсэл ашиглан хэмжих, турших, аюулгүй ажиллагааны дүрэм баримтлах - Үр дүнгээс дүгнэлт хийх - Гарсан үр дүнг зураг, бичвэр, хүснэгт, диаграммаар илэрхийлэх - Таамаглал, гарсан үр дүнг хооронд нь харьцуулж тайлбарлах, тайлагнах

Хэм хэмжээ, дэглэм сахих	- Хэм хэмжээг зохицуулсан дохио тэмдгийг ялган таних - Сургуулийн орчинд дасан зохицох, анги, хичээлийн дэг мөрдөх - Өдрийн дэглэм сахих - Аюулгүй, цэвэр орчин бүрдүүлэх санаа гаргах	- Хэм хэмжээг зохицуулсан дохио тэмдгийг ялган таних, ухаарч ойлгох - Сургуулийн орчинд баримтлах дэгийг сахих, мөрдөх, хэвшил болгох, тэвчээртэй, хүлээцтэй, хандах - Аюулгүй байдлаа хангах - Аюулгүй, цэвэр орчин бүрдүүлэхэд оролцох	- Хэм хэмжээг зохицуулсан дохио тэмдгийг ялган таних, гарах үр дагаврыг төсөөлөх - Дүрэм журмыг хэрхэн мөрдөж байгааг үнэлэх, жижиг /2-4 гишүүнтэй/ бүлгээр ажиллах - Биеийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлийг тайлбарлах - Орчин тойрны аюулгүй байдлыг үнэлэх, дүгнэх
Харилцах, үнэт зүйлийг эрхэмлэх	- Санал бодлоо илэрхийлэх, тайлбарлах - Байгаль, хүрээлэн буй орчинд эерэг хандах - Үнэт зүйлийг танин мэдэх - Хувийн - Гэр бүлийн - Найз нөхдийн	- Бусдыг сонсох, хүндлэх, бусдад туслах - Амьтан, ургамлыг хайрлах, хамгаалах - Үнэт зүйлийг ялгах - Хувийн - Гэр бүлийн - Найз нөхдийн	- Бусадтай хамтран ажиллах - Хүрээлэн буй орчноо хамгаалах, үйл ажиллагаанд оролцох - Үнэт зүйлийг бахархах - Хувийн - Гэр бүлийн - Найз нөхдийн

ХОЁР. АГУУЛГА

I АНГИ

1.1. БИ

Миний хичээлийн хэрэглэл

1.1а. Өөрийн хичээлийн хэрэглэлээ нэрлэж, үүрэг зориулалтаар нь ялган таних

Миний бие

1.1б. Мэдрэхүйн эрхтний тусламжтайгаар биетийн өнгө, хэлбэр, хэмжээ, хөдөлгөөн, амт үнэр, дуу чимээ, бат бөх чанарыг мэдэрч ялган таних

1.1в. Өдөр тутам хийдэг ажлуудаа дарааллаар нь танилцуулж, өдрийн дэглэмээ зургаар илэрхийлэх

1.2. МИНИЙ ГЭР БҮЛ

Манай гэрийнхэн

1.2а. Гэр бүлийнхнээ танилцуулах, шаардлагатай үед утсаар холбоо тогтоож чаддагаа харуулах

Миний гэр орон

1.2б. Орчин тойрны зүйлстэй харьцуулж, гэр байраа хаана оршдогийг тодорхойлох

1.2в. Гэр, байрны орчин (тухайлбал, гал тогоо) тойронд хаана, юу байдгийг ажиглаж, зураглах

1.2г. Гэрийнхээ цахилгаан хэрэгсэлтэй ажиллах аюулгүй ажиллагааг тодорхойлох

1.3. МАНАЙ СУРГУУЛЬ

Сургуулийн гадаад орчин

1.3а. Сургууль орчмын дуу чимээг сонсоод ялган таних

Сургуулийн дотоод орчин

1.3б. Ангид ургаж буй ургамлын бүтцийн хэсгүүдийг ялган таньж, нэрлэх

1.4. МИНИЙ НУТАГ

Орон нутаг ба хүмүүс

- 1.4а. Гэр, сургуулийнхаа болон аймаг, сум, хот дүүргийнхээ нэр, хаяг, байршлыг зөв хэлж чаддагаа харуулах
- 1.4б. Орон нутгийнхаа үйлчилгээний газруудыг нэрлэж, тэдгээрийн үйл ажиллагааны талаар хэлэлцэх

Орон нутаг ба байгаль

- 1.4в. Орон нутагтаа ургадаг хүнсний ногоо болон жимс, жимсгэнийг ялган таних
- 1.4г. Орон нутагтаа амьдардаг гэрийн тэжээмэл амьтдыг нэрлэж, хайрлан хамгаалах арга, ашиг шимийг жишээгээр тайлбарлах

1.5. МАНАЙ ДЭЛХИЙ

Эх орон, эх дэлхий

- 1.5а. Өдөр (гэрэлтэй, дулаан), шөнө (харанхуй, хүйтэн) -ийн ялгааг харьцуулах
- 1.5б. Байгалийн юмс үзэгдэл нар мандах, жаргахаас хамаарч өөрчлөгддөгийн учрыг жишээгээр тайлбарлах
- 1.5в. Хүний амьдрал, үйл ажиллагаа өдөр, шөнийн урт богино болон улирлаас хамаарч өөрчлөгддөгийг тодорхойлох

II АНГИ

2.1. БИ

Миний хичээлийн хэрэглэл

- 2.1а. Ангид байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг хийсэн материалаар нь төрөлжүүлэн бүлэглэх

Миний бие

- 2.1б. Биеийн бүтцийн нүдэнд харагдах хэсгүүдийг нэрлэж, үүргийг ялган таних
- 2.1в. Биеийн бүтцийн хэсгүүдийг хамгаалах аргуудыг жишээгээр тайлбарлах

2.2. МИНИЙ ГЭР БҮЛ

Манай гэрийнхэн

- 2.2а. Аав, ээжийнхээ ах дүүс (авга, нагац гэх мэт)-ийг модны мөчир хэлбэрээр зураглаж, танилцуулах
- 2.2б. Нэн шаардлагатай утасны дугаарууд (101.102.103.109)-ыг хэрэглэхийн учрыг тайлбарлах

Миний гэр орон

- 2.2в. Гэр, байрнаасаа сургууль хүрэх замыг заах, үндсэн ба завсрын зүг чигийг тодорхойлох
- 2.2г. Гэр, байрны орчин тойронд байгаа зүйлс нь амьдралд хэрхэн нөлөөлдгийг жишээгээр тайлбарлах

2.3. МАНАЙ СУРГУУЛЬ

Сургуулийн гадаад орчин

- 2.3а. Сургуулийн гадаад орчны дуу чимээний талаар жишээ гаргаж, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг хэлэлцэх

Сургуулийн дотоод орчин

- 2.3б. Ангид ургадаг ургамал олон төрөл болохыг тодорхойлж, ангилах

2.4. МИНИЙ НУТАГ

Орон нутаг ба хүмүүс

2.4а. Орон нутгийн хүмүүсийн ажил хөдөлмөрийн онцлогийг жишээгээр тайлбарлах

2.4б. Нутгийнхаа томоохон уул, ус, байгалийн болон түүхийн дурсгалт газрыг нэрлэх, танилцуулах

Орон нутаг ба байгаль

2.4в. Ургамал, амьтны амьдрах орчны ялгаатай байдлыг ажиглаж, амьдрах орчиндоо дасан зохилддог болохыг жишээгээр тайлбарлах

2.5. МАНАЙ ДЭЛХИЙ

Эх орон, эх дэлхий

2.5а. Гэрэлтэй ба сүүдэртэй газрын халуун, хүйтний ялгааг термометр ашиглан тодорхойлох

2.5б. Жилийн 4 улирал тус бүрд хамаарах саруудыг нэрлэж, улирлын ялгааг харьцуулан тодорхойлох

2.5в. Байгалийн юмс үзэгдэл улирлын ялгаанаас хамаарч өөрчлөгддөгийг жишээгээр нотлох

2.5г. Хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэлт улирлаас хамаарч өөрчлөгддөгийг тодорхойлох

2.5д. Цаг агаарын мэдээг сонсож, 7 хоногийн цаг агаарыг зураг, дүрс, тэмдэгтээр илэрхийлэх

2.5е. Цаг агаарын байдал хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлдгийг жишээгээр батлах

III АНГИ

3.1. БИ

Миний хичээлийн хэрэглэл

3.1а. Хичээлд хэрэглэж буй өгөгдсөн багаж, хэрэгслийг үүрэг зориулалтаар нь ялган таньж, аюулгүй байдлыг ханган, зөв сонгож хэрэглэх

Миний бие

3.1б. Амьд ба амьд бус биеийг ялган таньж, амьд биеийн үндсэн 5 шинжийг жишээгээр тайлбарлах

3.1в. Амьд биеийн үндсэн хэрэгцээг мэдэрч, биеийн өсөлт, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийг хэлэлцэх

3.1г. Хүн ба амьтны мэдрэхүй, гадаад орчинд үзүүлэх хариу үйлдлийг туршилт, жишээгээр нотлох

3.2. МИНИЙ ГЭР БҮЛ

Манай гэрийнхэн

3.2а. Аав, ээжийнхээ садан төрлийг жагсаан, ураг төрлийнхөө 3 үеийг зураглах

3.2б. Аав ээж болон гэрийнхнийхээ мэргэжил, ажлын газрыг ялган нэрлэх

Миний гэр орон

3.2в. Гэр, болон ангийнхаа план зургийг таних тэмдэг ашиглан зураглах

3.2г. Гэрээс сургууль хүрэх орчин тойрны зүйлсийг ажиглан, аюултай зүйлсийг тэмдэглэх

3.3. МАНАЙ СУРГУУЛЬ

Сургуулийн гадаад, дотоод орчин

3.3а. Сургуулийн гадаад орчны аюулгүй байдлыг үнэлж цэгнэх

3.3б. Ангид ургаж буй ургамлын өсөлт хөгжлийг ажиглаж, тэмдэглэл хөтлөх

3.4. МИНИЙ НУТАГ

Орон нутаг ба хүмүүс

3.4а. Орон нутгийнхаа нийтийн эзэмшлийн газар, ашиглалтын талаар мэдээлэл цуглуулж, төрөлжүүлэн бүлэглэх

3.4б. Нийтийн эзэмшлийн газруудад баримтлах дүрэм, журмыг жишээгээр тайлбарлах

Орон нутаг ба байгаль

3.4в. Орон нутагт ургадаг ургамлыг харагдах байдлаар нь ангилах, ялган таних

3.4г. Өөрийн мэддэг амьтдыг ой, тал хээрийн, усны гэж ангилан бүлэглэж, амьдрах орчны ялгаатай байдлыг жишээгээр тайлбарлах

3.5. МАНАЙ ДЭЛХИЙ

Эх орон, эх дэлхий

3.5а. Глобус, газрын зургийг харьцуулан ялган таних

3.5б. Газрын зургаас тэмдэг, тэмдэглэгээ (хилийн зурвас, нийслэл)-г ялган таньж тайлбарлах

3.5в. Глобус ба газрын зурагт далай ба хуурай газрыг өнгөөр ялган тэмдэглэдэг болохыг жишээлэн үзүүлэх

3.5г. Глобус ба газрын зураг дээр дэлхийн тивүүд болон зарим улсуудыг зааж, нэрлэх

3.5д. Дэлхийн хүмүүсийн амьдрал, арьс өнгө ялгаатай байдгийг таньж тодорхойлох

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

Хүн ба орчин хичээлийн арга зүй нь сурагчдад сонирхон судлах арга барил эзэмшихэд чиглэнэ. Сонирхон судлах арга барил нь IV-V ангийн хүн ба байгаль, суурь, бүрэн дунд боловсролын байгалийн ухааны хичээлээр эзэмших шинжлэн судлах арга барилтай адил ойлголт бөгөөд дараах үе шатаар сурагчдад сурах арга барил эзэмшүүлэхэд чиглэнэ. Үүнд:

1. Ажиглах, асуудал, таамаглал дэвшүүлэх
2. Юу хийхээ баримжаалах, багшийн болон бусдын дэмжлэгтэйгээр таамаглалаа шалгах талаар төсөөлөх, аюулгүй ажиллах санаа гаргах
3. Сорил туршилт, дасгал, даалгавар гүйцэтгэх
4. Сорил туршилтын үр дүнг бичвэр, зураг, хүснэгт, диаграммаар илэрхийлж, танилцуулах

3.2. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

- Ажиглалт, хялбар сорил туршилт хийх анги танхим, сургалтын орчин бүрдүүлж, сурагчдын эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдалд анхаарал хандуулна.
- Сорил туршилт гүйцэтгэхэд хэрэглэгдэх шаардлагатай хэрэгсэл, гарын доорх материал, багаж тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын хуудас, үйл ажиллагааны удирдамж, дасгал, даалгавар зэрэг сургалтын хэвлэмэл болон бодит үзүүлэн, цахим хэрэглэгдэхүүнийг бэлтгэж сургалтад хэрэглэнэ.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

Үнэлгээнд дараах үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтална.

4.1. Үнэлгээний зорилт

- А. Мэдлэг ойлголт
- Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар
- В*. Хандлага

* Хандлагыг багш ажиглалт, ярилцлага, рубрик зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Мэдлэг, ойлголт (Сурагчид хөтөлбөрийн хүрээний ухагдахуун ойлголтын талаар мэддэг байх)	А1. Баримт, тодорхойлолт, үг хэллэг, шинэ санаа А2. Нэр томьёо, үг хэллэг А3. Тэмдэг тэмдэглэгээ, нэгж, хэмжигдэхүүн
Б. Мэдлэг ойлголтоо хэрэглэх (Сурагч дараах зүйлсийг хэрэглэх чадвартай байх)	Б1. Тэмдэг, тэмдэглэгээ, нэгж, хэмжигдэхүүнийг хэрэглэх Б2. Шинжлэх ухааны санаануудыг тайлбарлах Б3. Өгөгдлийг ашиглах Б4. Мэдлэгээ танил болон танил бус нөхцөлд хэрэглэх Б5. Сургалтын багаж хэрэгсэл, арга техник, аюулгүй ажиллагааг баримтлах
В. Хандлага (Сурагчдад дараах хандлага төлөвшсөн байх)	В1. Сонирхол В2. Идэвх оролцоо В3. Нягт нямбай байдал В4. Санаачилгатай байдал В5. Хэм хэмжээ, дэгийг баримтлах байдал В6. Бусадтай харилцах, хамтрах

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
А. Мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгавар	40% (20%-аас ихгүй сэргээн санах түвшний даалгавар)
Б. Мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх даалгавар	60%

ХҮН БА БАЙГАЛЬ

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь байгалийн юмс, үзэгдлийг шинжлэн судалж, танин мэдэх хүсэл сонирхолтой болсноор байгалиа хайрлан хамгаалдаг болно.

1.2. Зорилт

- 1.2.1. Амьдрал, гараг, дэлхий, байгалийн юмс, үзэгдлийн мөн чанарыг ялган таних, тэдгээрийн хувирлын шалтгааныг тодорхойлох;
- 1.2.2. Байгалийн юмс, үзэгдлийг таамаглах, төлөвлөх, төлөвлөсний дагуу аюулгүй ажиллагааны дүрэм баримтлан гүйцэтгэх, үр дүнг илэрхийлэх, өөрийн үйл ажиллагааг үнэлэх;
- 1.2.3. Ургамал, амьтан, хүрээлэн буй орчныг хайрлах хүсэл эрмэлзэлтэй, байгалиа хамгаалахыг хичээж, өөртөө шүүмжлэлтэй ханддаг болох.

“Хүн ба байгаль”-ийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	IV анги	V анги
Асуудал, таамаглал дэвшүүлэх	- Юуг?, Хэзээ?, Хэрхэн?, Яаж өөрчлөгдсөн бэ? зэрэг асуулт асуух - Асуулт асуухдаа бүлгийн хүрээнд эзэмших зарим үг хэллэг, нэр томъёог ашиглах - Өөрийн туршлагад үндэслэн таамаглал дэвшүүлэх	- Яагаад ингэж өөрчлөгдсөн бэ?, Ингэвэл яах вэ? зэрэг асуулт асуух - Асуулт асуухдаа зарим мэдээлэл, баримт нотолгоог жишээ болгон ашиглах - Өдөр тутмын амьдралд тохиолдох үзэгдэлд баримжаалан таамаглал дэвшүүлэх
Сорил, туршилт, шинжлэн судлах ажлыг төлөвлөх	- Юуг?, хэрхэн?, яаж ажиглах, турших талаар харилцан ярилцах, багийн шийдвэр гаргах - Ажиглалт, туршилтын алхмуудыг багшийн болон бусдын дэмжлэгтэйгээр төлөвлөх - Ажиглалт, туршилтад хэрэглэх багаж хэрэгслийг орлуулан хэрэглэх материалыг хамтран бэлтгэх - Багаж, хэрэгслийг хэрхэн зөв хэрэглэх талаар зааврыг уншиж, ойлгосноо бусдад тайлбарлах - Ажиглалт, туршилтын явц, үр дүнг тэмдэглэх хүснэгт, ажлын хуудас зэргийг багшийн тусламжтай боловсруулах	- Юуг?, хэрхэн?, яаж ажиглах, турших талаар эргэцүүлэн бодох, бие даан шийдвэр гаргах, хэлэлцэх - Ажиглалт, туршилтын алхмуудыг бие даан төлөвлөх - Ажиглалт, туршилтын багаж хэрэгслээс зөв сонголт хийх - Багаж, хэрэгслийг зааврын дагуу аюулгүй, хэрхэн зөв хэрэглэхээ төлөвлөх - Ажиглалт, туршилтын явц, үр дүнг тэмдэглэх хүснэгт, ажлын хуудас болон шаардлагатай бусад материалыг хамтран боловсруулах

Баримт нотолгоо гаргах, илэрхийлэх	- Ажиглалт, туршилтыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх - Багаж хэрэгслийг зааврын дагуу зөв хэрэглэх - Үр дүнг тэмдэглэх, хэмжих үйлийг зааврын дагуу хамтран гүйцэтгэх - Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах	- Ажиглалт, туршилтын явцад үр дүнг тэмдэглэх, хэмжих, нягтлах үйлийг тогтмол гүйцэтгэх - Багаж хэрэгслийг зөвлөмж, удирдамж, техникийн дагуу хэрэглэх явцдаа гаргасан алдаагаа олж харах, засах - Үр дүнг тэмдэглэх, хэмжих, нягтлах үйлийн зааврыг бие даан гүйцэтгэх - Аюулгүй ажиллах дүрмийг баримталж, бусдадаа сануулах, зөвлөх
Баримт нотолгоо ба үр дүнг нягтлах, тайлбарлах	- Цуглуулсан мэдээлэл, баримт нотолгоог нэгтгэх, хангалттай эсэхийг хэлэлцэх - Ажиглалт, туршилтын явц, үр дүнг бичвэр, хүснэгт, диаграммаар илэрхийлэх - Ажиглалт, туршилтын үр дүнг тайлбарлах, юмс, үзэгдлийг тодорхойлох - Өөрсдийн хийсэн ажил, түүний үр дүнгийн талаар хэлэлцэх - Ажиглалт, туршилт хийсэн аргаа сайжруулах талаар санал гаргах	- Цуглуулсан мэдээлэл, баримт нотолгоо нь хангалттай эсэхийг үнэлэх - Ажиглалт, туршилтын явц, үр дүнг илэрхийлэх тохиромжтой аргыг сонгон хэрэглэх - Ажиглалт туршилтын үр дүнд үндэслэн таамаглалаа батлах, эсвэл няцаах, юмс, үзэгдлийг тодорхойлохдоо байгалийн ухааны зарим үг хэллэг, нэр томъёо ашиглах - Өөрсдийн хийсэн ажил, түүний үр дүнг үнэлэх - Ажиглалт, туршилтын аргаа сайжруулах талаар санал гаргах, шалтгааныг тайлбарлах

ХОЁР. АГУУЛГА

IV АНГИ

4.1. АМЬДРАЛ

Өсөлт хөдөлгөөн

- 4.1а. Хүний биеийн араг ясны толгой, их бие, мөчдийн хэсгүүдийг зургаас ялган таних, үүргийг жишээгээр тайлбарлах
- 4.1б. Булчингийн агшилт, сулралтын зарчмыг бугалганы хос булчингийн загвар дээр тайлбарлах
- 4.1в. Булчин араг ясанд бэхлэгддэг, булчин, араг яс, үе холбоос нь хөдөлгөөнд оролцдог болохыг илрүүлэх

Амьд бие ба амьдралын орчин

- 4.1г. Зарим амьтан, ургамлын онцлог шинж нь амьдрах орчиндоо зохилдсон болохыг илрүүлэх
- 4.1д. Тухайн орчин дахь амьд биес идэш тэжээлээрээ холбогддог болохыг тайлбарлах
- 4.1е. Хүрээлэн буй орчинд нөлөөлж буй хүний үйл ажиллагаанаас жишээлэн тайлбарлах

4.2. ЮМС ҮЗЭГДЭЛ

Гэрлийн шинж чанар

- 4.2а. Гэрэл үүсгэгч ашиглаж биеийн сүүдэр үүсэх нөхцөлийг тодорхойлох
- 4.2б. Гэрэл үүсгэгч, бие, дэлгэц гурвын харилцан байрлалаас сүүдрийн хэмжээ хамаардаг болохыг тайлбарлах
- 4.2в. Гэрлийн цацраг шулуун тархдаг чанарыг ашиглан дүрс байгуулах
- 4.2г. Гэрлийг ойлгодог, ойлгодоггүй материалыг ялган таних
- 4.2д. Хавтгай толиноос ойсон тусгалын хэлбэрийг толины хэлбэртэй холбож тайлбарлах

- 4.2е. Толь ашиглаж гэрлийг хуримтлуулж болохыг тодорхойлох
- 4.2ж. Ойсон гэрлийн тусламжтай биеийг хардаг болохыг зурж харуулах

Соронзон

- 4.2з. Соронзон ашиглах үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг тайлбарлах
- 4.2и. Соронзонд татагддаг, татагддаггүй материалыг таньж тодорхойлох
- 4.2к. Соронзны үйлчлэлийг татах, түлхэх хүчид үндэслэн тайлбарлах
- 4.2л. Соронзны татах, түлхэх үйлчлэлийг туйлтай холбон зурж үзүүлэх
- 4.2м. Төмөр (бичгийн хавчаар)-ийг соронзон чанартай болохыг соронзон ашиглаж тодорхойлох

Цахилгаан дамжуулагч ба тусгаарлагч

- 4.2н. Энгийн цахилгаан хэлхээний элементийн үүрэг зориулалтыг ялган таних, нэрлэх
- 4.2о. Цахилгаан хэлхээний элементийн тэмдэглэгээг ялган таних, схемийг бодит хэрэглэгдэхүүн дээр заах
- 4.2ө. Батарей, чийдэн ашиглан өгсөн материалуудын цахилгаан дамжуулах чадварыг таньж тодорхойлох
- 4.2п. Металл (цахилгааны утас, кабельд), хуванцарын (утас болон залгуур, унтраалгын гэр бүрхүүлд) хэрэглээг нэрлэх

Хатуу, шингэн, хий

- 4.2р. Түгээмэл тохиолдох хатуу, шингэн, хийг таньж тодорхойлох, нэрлэх, жишээ гаргах
- 4.2с. Хатуу, шингэн, хийн ялгаа (хэлбэр, шахагдах, урсах)-г жижиг хэсгийн байрлал, хоорондын зайтай холбон тайлбарлах
- 4.2т. Уусмал дахь бодисын жижиг хэсгийг дүрслэн тайлбарлах
- 4.2у. Хатуу бодисыг устай холиход гарах өөрчлөлтийг тодорхойлж, тэдгээрийг усанд уусдаг, уусдаггүйгээр нь ангилах

План ба газар зүйн зураг

- 4.2ү. Сургууль орчмын план зурахдаа юмсыг таних тэмдгээр дүрслэн зүг чигийг тэмдэглэх
- 4.2х. Юмсын бодит хэмжээг өөрийн зурсан план зурагтай харьцуулах
- 4.2ц. Өгсөн газарзүйн зураг дээр хол, ойр зайг хэмжиж харьцуулах
- 4.2ч. Өгсөн газарзүйн зураг дээр дүрслэгдсэн зүйлсийг таних тэмдэг ашиглан ялгах

V АНГИ

5.1. ГАРАГ ДЭЛХИЙ

Одот тэнгэр

- 5.1а. Сүүдрийн чиг ба уртын өөрчлөлтөөр нарны байрлалыг тодорхойлох
 - 5.1б. Дэлхий тэнхлэгээ тойрон эргэсний улмаас нар хөдөлж байгаа мэт харагддагийг загварчлах
 - 5.1в. Өдөр, шөнө ээлжилж буй үзэгдлийг дэлхий тэнхлэгээ эргэх хөдөлгөөнөөр тайлбарлах
 - 5.1г. Сар (хоногийн)-ны хөдөлгөөнийг тодорхой биеттэй харьцуулах
 - 5.1д. Сарны үзэгдэх хэлбэр (сарын турш- өдрөөс өдөрт) өөр өөр байдгийн шалтгааныг нар, сар, дэлхийн байрлалтай холбон тайлбарлах
 - 5.1е. Алтан гадас ба долоон бурхан оддын байрлалыг зураглаж, зүг чигээ тодорхойлох
- Голдож, зэргэдээр зүг чиг олох*
- 5.1ж. Глобус болон дэлхийн газарзүйн зураг дээр ус (далай) ба хуурай газрыг ялган нэрлэж, хэмжээг харьцуулах

- 5.1з. Глобус болон дэлхийн газарзүйн зураг дээр голдож ба зэргэдийг ялган харьцуулах
- 5.1и. Голдож, зэргэдийг ашиглан дэлхийн өмнөд ба хойд хагас, баруун ба зүүн хагасыг ялгах
- 5.1к. Голдож, зэргэдийг ашиглан цэгийн байрлалыг тодорхойлох

5.2. ЮМС ҮЗЭГДЭЛ

Бодисын төлөвийн шилжилт

- 5.2а. Ус хатуу, шингэн, хийн төлөвт шилжих үзэгдлийг нөхцөлтэй нь холбон илэрхийлэх
- 5.2б. Хайлах, хөлдөх үеийн өөрчлөлтийг бодисын жижиг хэсгээр дүрслэн үзүүлэх
- 5.2в. Уурших, шингэрэх үеийн өөрчлөлтийг бодисын жижиг хэсгээр зурж харуулах
- 5.2г. Байгаль дахь усны эргэлтийг хатуу, шингэн, хийн төлөвийн шилжилтээр тайлбарлах

Эргэх ба үл эргэх өөрчлөлт

- 5.2д. Үзэгдлийг эргэх, үл эргэх гэж ангилах, жишээ гаргах
- 5.2е. Лаа шатах нь үл эргэх үзэгдэл болохыг тодорхойлох
- 5.2ж. Төмөр, элс, модны үртсийг холимгоос нь ялгаж, эргэх үзэгдэл болохыг тодорхойлох

Цаг агаар ба уур амьсгал

- 5.2з. Хоногийн агаарын температурын өөрчлөлтийг тэмдэглэж, шалтгааныг илрүүлэх
- 5.2и. Агаарын тунадасыг энгийн аргаар хэмжиж, дүрслэх
- 5.2к. Салхины зүг чиг ба хүчийг хялбар аргаар тодорхойлон ялгааг тэмдэглэх
- 5.2л. Дэлхий дээр өөр өөр уур амьсгалтай газар орон байдгийг байрлалтай нь холбож тайлбарлах

Хөшүүрэг, хялбар механизм

- 5.2м. Өгсөн хэрэгслүүдээс хөшүүргийн зарчмаар ажилладгийг нь ялган таних, ажиллах зарчмын учрыг олох
- 5.2н. Хөшүүрэг (саваа мод) ашиглаж хүчийг ихэсгэж, багасгаж болохыг тодорхойлох
- 5.2о. Хөшүүргийн (урт мөрт бага хүч оногддог) тэнцвэрийн зарчмыг тайлбарлах, жишээ гаргах

5.3. АМЬДРАЛ

Ургамлын амьдралын эргэлт

- 5.3а. Ургамлын ургал эрхтнүүдийг ялган таних, нэрлэх
- 5.3б. Зарим тасалгааны ургамлыг ишээр үржүүлж, үр дүнг хүснэгтэд тэмдэглэх
- 5.3в. Ургамлыг үрээр үржүүлэх аргыг туршиж, үр дүнг хэлэлцэх
- 5.3г. Үрээр болон ишээр үржүүлж буй ургамлаар жишээлэн ургамлын амьдралын эргэлтийг хэсэгчлэн зураглах

Амьтдын үржил, хөгжил

- 5.3д. Шавж ба аалз ялгаатай болохыг зарим онцлог шинжид нь үндэслэн ялган таних
- 5.3е. Бүрэн ба бүрэн бус хувиралтай шавжийн амьдралын эргэлтийг бүдүүвч ашиглан харьцуулах
- 5.3ж. Өндөглөгч амьтдын үржлийн онцлог, амьдралын эргэлтийг загварчлан тайлбарлах
- 5.3з. Амьд үр төл төрүүлэгч амьтдын үржил хөгжлийн онцлогийг харьцуулан тайлбарлах
- 5.3и. Хүний төрөхийн өмнөх ба төрсний дараах өсөлт, хөгжлийг харьцуулах

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

- “Хүн ба байгаль” хичээлийн арга зүй нь сурагчдад сонирхон шинжлэн судлах арга барил эзэмшүүлэхэд чиглэнэ.

Шинжлэн судлах арга барилыг IV-V ангид дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Өдөр тутмын амьдралд тохиолдох юмс, үзэгдлийн талаар таамаглах
 2. Туршилт төлөвлөх
 3. Төлөвлөлтийн дагуу гүйцэтгэх (баримт, нотолгоо, үр дүнг цуглуулах, боловсруулах)
 4. Дүгнэлт гаргах
- Хичээл хоорондын агуулгын интеграцийг хангах, өөрөөр хэлбэл туршилтын үр дүнг бичвэр, зураг, хүснэгт, диаграммаар илэрхийлэх, бусдад тайлбарлах зэрэг нь математик, монгол хэл гэх мэт олон хичээлтэй холбоотой болохыг анхаарч хичээлийг төлөвлөнө
 - Тухайн хичээлийн жилд хэрэгжүүлэх боломжтой сорил, туршилтыг нарийвчлан төлөвлөх, шинжлэн судлах арга барилд суурилан хичээл төлөвлөхөд уян хатан хандаж нэг хичээл дээр дээрх үе шатуудыг заавал хэрэгжүүлэх шаардлагагүй. Тухайлбал, туршилт төлөвлөх үйл ажиллагааг нэг хичээл дээр хэрэгжүүлж болно.

3.2. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

- Ээлжит хичээлийг сурагчийн бүтээлч үйл ажиллагаанд чиглүүлэн төлөвлөж, самбар хөтлөлт болон дэвтрийн тэмдэглэл (сорил, туршилтын төлөвлөлтийн санаа, үйл явц, үр дүн)-ийн уялдаа холбоог хангахад анхаарна.
- Багш сорил, туршилтыг өөрөө урьдчилан гүйцэтгэж, туршилтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, алдаа гарахаас сэргийлнэ.
- Ажиглалт, туршилтын үр дүнг бусдад хэрхэн, яаж илэрхийлэх тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх, хэрэглэсэн арга нь хэр оновчтой байсан талаар үнэлж дүгнэх нь чухал учраас энэ талаар хэлэлцэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- Багаар болон ганцаарчлан ажиллах хэлбэрийг зохистой төлөвлөж, сурагчдыг багаар ажиллахад суралцах, багийн ажил нь хэр үр дүнтэй байсан, цаашид юу анхаарах талаар санал дэвшүүлж, өөрийн үнэлгээтэй ханддаг орчныг бүрдүүлнэ.
- Бусдад туршилтын үр дүнгээ танилцуулахдаа туршилтаас гарсан баримт, нотолгоог эшлэл, жишээ болгон ашиглаж сурахад чиглүүлнэ.
- Хүн ба байгаль хичээлд дараах сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглах боломжтой. Үүнд:
 - Ангийн цэцэг, амьтан (аквариум)-ы булан, сургуулийн хүлэмж, туршилтын талбай, орон нутгийн музей, байгалийн үзэсгэлэнт болон дархан цаазат газар
 - Туршилтыг гүйцэтгэхэд шаардлагатай багаж төхөөрөмж, хэрэгсэл, бодис, гарын доорх материал, аюулгүй ажиллагааны заавар
 - Газарзүйн зураг, загвар, муляж зэрэг сургалтын бодит хэрэглэгдэхүүн
 - Ажлын хуудас, үйл ажиллагааны удирдамж, дасгал даалгавар, сорил зэрэг сургалтын хэвлэмэл хэрэглэгдэхүүн
 - Аудио, видео бичлэг, сургалтын цахим хэрэглэгдэхүүн

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

Үнэлгээнд дараах үнэлгээний зорилт, шалгуур жинг баримтална.

4.1. Үнэлгээний зорилт

- А. Мэдлэг ойлголт
- Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар
- В.* Хандлага

* Хандлагыг багш ажиглалт, ярилцлага, рубрик зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Мэдлэг, ойлголт (сурагчид хөтөлбөрийн хүрээний ухагдахуун ойлголтын талаар мэддэг байх)	A1. Амьд биеийн ижил ба төсөөтэй шинж, ялгаа, холбоо хамаарал A2. Байгалийн үзэгдэл, юмсын тухай ойлголт, шинж чанар, орон зайн болон зүг чигийн баримжаа A3. Баримт, нотолгоо, тодорхойлолт, үг хэллэг, шинэ санаа A4. Нэр томьёо, үг хэллэг A5. Сорил туршилт төлөвлөхөд анхаарах зүйл, аюулгүй ажиллагаа A6. Тэмдэг тэмдэглэгээ, нэгж, хэмжигдэхүүн
Б. Мэдлэг ойлголтоо хэрэглэх (сурагч дараах зүйлсийг хэрэглэх чадвартай байх)	B1. Байгалийн юмс үзэгдлийг ажиглах, учир шалтгаан холбоо хамаарлыг тодорхойлох B2. Тэмдэг, тэмдэглэгээ ашиглаж юмсын байрлал, үзэгдлийг тайлбарлах B3. Сорил туршилт төлөвлөх, төлөвлөхдөө гаргасан алдаагаа туршилтын явцад олох, засах B4. Туршилтын хэрэглэгдэхүүнийг сонгох, зориулалтын дагуу хэрэглэх B5. Туршилтын үр дүнг зураг, бичвэр, хүснэгт, диаграммаар илэрхийлэх B6. Мэдлэгээ танил болон шинэ нөхцөлд хэрэглэх B7. Сорил туршилтын үед аюулгүй ажиллагааны дүрэм баримтлах B8. Ажиглалт, туршилтаар илрүүлсэн баримтад тулгуурлан аливаа зүйлсийн учир, шалтгаан холбоо хамаарлыг тайлбарлах
В. Хандлага (сурагчдад дараах хандлага төлөвшсөн байх)	B1. Хүсэл, сонирхол B2. Идэвх оролцоо B3. Нягт нямбай байдал B4. Хэм хэмжээ, дэгийг баримталж буй байдал B5. Бусадтай хамтран ажиллаж буй байдал

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
А. Мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгавар	40% (20%-аас ихгүй сэргээн санах түвшний даалгавар)
Б. Мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх даалгавар	60%

ХҮН БА НИЙГЭМ

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь хүн, нийгмийн үйл явц, эх орныхоо түүхэн гол үйл явдлыг танин мэдэх энгийн арга барилтай, өөрийн болон үндэснийхээ үнэт зүйл, хэм хэмжээг хүндэтгэн харилцдаг, оролцоот иргэн болж төлөвшинө.

1.2. Зорилт

- 1.2.1. Хүн, нийгэм, тэдгээрийн харилцаа, эх орны түүхэн гол үйл явдал, түүхт хүмүүсийн тухай наад захын мэдлэг, ойлголттой болох;
- 1.2.2. Хүн, нийгэм, эх орны түүхэн гол үйл явдал, түүхт хүмүүсийн үйл ажиллагааг зөв таних, төсөөлөх арга барил эзэмшиж, хувийн болон үндэсний үнэт зүйлсээс тайлбарлах, нутгийн нийгэм, хүмүүсийн амьдралд идэвхтэй оролцох чадвар эзэмших;
- 1.2.3. Гэр бүл, сургууль, нутгийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцож, зан үйлийн хэм хэмжээг баримталдаг, эх түүх, өв уламжлал, соёлоо эрхэмлэн дээдэлдэг, хүмүүс, эх орныхоо хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулах, эерэг хандлагатай болох.

“Хүн ба нийгэм”-ийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагч дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	IV анги	V анги
Нийгэм, түүхийн үйл явдлыг мэдэх, ойлгох: - Гэр бүл, сургуулийн хүрээний үйл явдлыг мэдэх, тайлбарлах - Орон нутаг, эх орны нийгэм, түүхийн үйл явдлыг ойлгох, тодорхойлох	- Судалсан хам сэдвийн хүрээнд нийгэм, түүхийн үйл явдал, үйл явцыг нэрлэх, шалтгаан, үр дагаврыг олох, эрэмбэлэх - Тэдгээрийг он цагийн дараалалд оруулах, өөрчлөлт, сургамжийг тайлбарлах	- Судалсан хам сэдвийн хүрээнд нийгэм, түүхийн үйл явдал, үйл явцуудын нийтлэг, ялгаатай шинжийг тодорхойлох, эдгээр шинжээр нь бүлэглэх - Нийгэм, түүхийн үйл явдал, үйл явцын он цаг, орон зайн хамаарал, өөрчлөлт, сургамжийг тодорхойлох, үнэлэх
Асуудал шийдвэрлэх: - Хүн ба нийгмийн холбогдолт асуудлыг олох, шийдвэрлэх - Холбогдох мэдээллийг олох, ашиглах, боловсруулах, солилцох	- Хүмүүсийн өдөр тутмын амьдралыг өөрийн түвшинд ажиглах, судлах - Хүн ба нийгмийн хувьд сонирхолтой, шийдвэрлүүштэй асуудлыг олох - Тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар санал, бодлоо илэрхийлэх - Мэдээллийг эрж хайж олох, өөрийн түвшинд ашиглах, солилцох	- Нийгмийн өдөр тутмын үйл явцыг ажиглах, судлах, энэ талаар бодол санаагаа илэрхийлэх - Хүн ба нийгмийн холбогдолтой асуудлыг шийдвэрлэх арга замыг санал болгох - Холбогдох шийдвэр гаргахдаа зөв сонголт хийх, үр дагаврыг тооцох - Мэдээллийн эх сурвалжуудаас мэдээлэл олох, өөрийн түвшинд боловсруулах, хэрэглэх, солилцох

Харилцах, хамтран ажиллах: - Өөртэйгөө харилцах - Бусадтай харилцах - Бусадтай хамтран ажиллах	- Сурагч өөрийгөө хувь хүн гэдгээ мэдрэх, ойлгох - Бусдыг сонсож сурах, үзэл бодлыг нь хүндэтгэн харилцах - Бусдад туслах, бусдаас тусламж хүсэх, дэмжин ажиллах - Хувь хүн эрх эдлэх, үүрэг, хариуцлага хүлээх талаар тайлбарлах - Дүрэм, журмын тухай мэдэх, дагаж мөрдөх	- Өөрийгөө бие даан илэрхийлэх, өөртөө итгэлтэй байх - Бусдыг ойлгох, хувийн байр суурийг нь хүндэтгэх, хүлээцтэй хандан харилцах - Бусдад туслах, бусадтай зөвшилцөн ажиллах - Өөрийн эрхээ эдлэх, үүрэг, хариуцлагаа биелүүлэх - Дүрэм, журмыг мөрдөх, сайжруулах талаар санал гаргах
Үнэт зүйлсийг эрхэмлэх: - Өөрийн болон гэр бүлийн үнэт зүйлийг эрхэмлэх - Түүх, соёл, уламжлал, зан заншлын үнэт зүйлсийг эрхэмлэх	- Өөрийн бодол, байр суурь зэрэг үнэт зүйлээ илэрхийлэх - Хувь хүн, гэр бүлийн үнэт зүйлийг мэдэх, хүндэтгэх, бахархах - Гэр бүл, найз нөхөд, ахмад хүмүүсийг хүндэтгэх - Үндэснийхээ уламжлал, ёс заншлыг хүндэтгэх - Түүх, соёлын дурсгалт зүйл, байгаль орчныг хайрлах, хамгаалахын үнэ цэнийг ухаарах, үнэлэх	- Өөрийн үнэлэлт, хандлага зэрэг үнэт зүйлээ бие даан илэрхийлэх - Гэр бүл, хамт олон, байгууллагын үнэт зүйлийг мэдэх, хүндэтгэх, хамгаалах - Сургууль, байгууллага, орон нутгийн хүмүүсийг хүндэтгэх - Үндэснийхээ уламжлал, ёс заншлыг хүндэтгэх, эрх зүйн хэм хэмжээг мөрдөх - Түүх, соёлын дурсгалт зүйл, байгаль орчныг хамгаалах талаар өөрийн түвшинд санаачилга гаргах

ХОЁР. АГУУЛГА

IV АНГИ

- 4.1. БИ, ГЭР БҮЛ, СУРГУУЛИЙН АМЬДРАЛ
 - 4.1а. Гэр бүлийн орчинд өөрийн бодол санаа, хүсэлтээ илэрхийлэн харилцах
 - 4.1б. Сургууль, анги дахь өөрийн оролцоог тодорхойлох
- 4.2. НУТГИЙН ХҮМҮҮС, НИЙГЭМ, АЖ АХУЙ, СОЁЛЫН АМЬДРАЛ
 - 4.2а. Нутгийн хүмүүсийн ахуй, амьдралын онцлог, соёлын талаар тайлбарлах
 - 4.2б. Нутгийн аж ахуй, үйлдвэрлэлийн газруудын үйл ажиллагааны ялгааг мэдэж, бүдүүвчээр харуулах
 - 4.2в. Нутгийн соёлын болон үйлчилгээний газруудын үүрэг, үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, нэгтгэн танилцуулах
 - 4.2г. Сурагч нутгийнхаа нийгмийн амьдралд өөрийн хувь нэмэр оруулах
- 4.3. ХҮМҮҮСИЙН ХАРИЛЦАА, ХАМТЫН АМЬДРАЛ ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА
 - 4.3а. Хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
 - 4.3б. Хүмүүсийн харилцаа, хамтын амьдралыг ойлгох, тайлбарлах
 - 4.3в. Сурагч өөртөө үүрэг, хариуцлага хүлээхийг ойлгох, биелүүлэх
 - 4.3г. Өөрийн нийгэм, соёлын орчны талаар ойлгох, үнэлэлт өгөх
 - 4.3д. Өөрийн аюулгүй байдлыг хангах талаар мэдэх, шийдвэр гаргах

V АНГИ

- 5.1. БИ, ГЭР БҮЛ, СУРГУУЛИЙН АМЬДРАЛ
 - 5.1а. Үе тэнгийнхэн, сургуулийн ажилтнуудад өөрийгөө зөв илэрхийлж, харилцах
 - 5.1б. Сургууль, хамт олны үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах арга замыг сонгох, хэрэгжүүлэх
- 5.2. НУТГИЙН ХҮМҮҮС, НИЙГЭМ, АЖ АХУЙ, СОЁЛЫН АМЬДРАЛ
 - 5.2а. Хүмүүсийн ялгаатай байдлыг (нас, хүйс, нийгэм, соёлын гэх мэт) мэдэж, харилцах
 - 5.2б. Нутгийн нийгэм, аж ахуй, соёлын амьдрал, хөгжилд гарамгай хувь нэмэр оруулсан хүмүүсийг мэдэх, үйл ажиллагааг нь тайлбарлах
 - 5.2в. Нутгийн байгууллагуудын (үйлдвэрлэл, үйлчилгээ, удирдах зэрэг) үйл ажиллагааг ажиглах, танилцуулах
 - 5.2г. Хөрш нутаг, өөрийн улсын хөрш улсуудыг газрын зурагт зөв заах
- 5.3. ХҮМҮҮСИЙН ХАРИЛЦАА, ХАМТЫН АМЬДРАЛ, ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА
 - 5.3а. Хүүхэд эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх, эрх зөрчигдсөн тохиолдолд холбогдох байгууллага, хүмүүст хэрхэн хандахыг мэдэж, харилцах
 - 5.3б. Холбогдох мэдээллийг өөрийн түвшинд боловсруулах, хэрэглэх
- 5.4. МИНИЙ ЭХ ОРОН-МОНГОЛ БАХАРХАЛ
 - 5.4.1. Эх орон, эх түүхийн бахархал
 - 5.4.1а. Эх орныхоо байгаль, газарзүйн онцлог, үзэсгэлэнт газруудыг мэдэх
 - 5.4.1б. Монгол орон хүн үүссэн өлгий нутгийн нэг болохыг мэдэх, жишээгээр нотлох
 - 5.4.1в. Монгол хүний ахуй, амьдрал, эрхлэх аж ахуйн онцлогийг тодорхойлох
 - 5.4.1г. Монголчуудын дээд өвөг Хүннүгийн хаан Модунь шаньюгийн тухай сэтгэгдлээ илэрхийлэх
 - 5.4.1д. Их Монгол улсын нийгэм, аж ахуй, соёлын онцлогийг өөрийн үгээр тайлбарлах
 - 5.4.1е. Суут Чингис хааны үйл ажиллагаа, гавьяаг жишээгээр тайлбарлах, тодорхойлох
 - 5.4.1ж. Чингисийг залгамжлагч их хаадын үйл ажиллагаанаас дүрслэн харуулах
 - 5.4.1з. Манжийн ноёрхлын эсрэг тусгаар тогтнолын төлөө тэмцэгч голлох хүмүүсийн талаар танилцуулга хийх
 - 5.4.2. Үндэсний тусгаар тогтнол, орчин үеийн бахархал
 - 5.4.2а. Улс үндэснийхээ тусгаар тогтнол, сэргэн мандлын тухай тайлбарлах
 - 5.4.2б. Тухайн үеийн Монгол улсын нийгэм, аж ахуй, соёлын шинэ зүйлсийг тодорхойлох
 - 5.4.2в. Эх орны түүхэн дэх хүнд бэрх үе, тусгаар тогтнолын бэхжилтийн талаар хэлэлцэх
 - 5.4.2г. Монгол улсын нэр хүнд дэлхий дахинд өссөн тухай өөрийн үгээр илэрхийлэх
 - 5.4.2д. Тухайн үеийн эх орны аж ахуй, нийгэм, соёлын бүтээн байгуулалтыг жишээгээр тайлбарлах
 - 5.4.2е. Монгол төрийнхөө бэлгэдлийн талаар мэдэх, танилцуулах
 - 5.4.2ж. Ардчилсан Монголын нийгэм, аж ахуй, соёлын ололт, амжилтыг тайлбарлах

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

- “Хүн ба нийгэм”-ийн сургалтаар эзэмших чадварыг сурагч бүр бие даан болон хамтран ажилласны үр дүнд эзэмшинэ. Багш хичээлийг оновчтой арга зүйгээр удирдан зохион байгуулж, сурагчийн үйл ажиллагааг чиглүүлэн, хөгжүүлнэ.
- Үүний тулд сурагчийн хүрээлэн буй нийгэм, түүхийн бодит үйл явц, баримтад тулгуурласан тохиолдол шинжлэх, мөн ажиглах, судлах, харьцуулах, асуудал шийдвэрлэх, үнэлэлт өгөх зэрэг идэвхтэй аргыг хэрэглэнэ. Сурагч бүр багаар ажиллах, асуулт асуух, ярилцах, хэлэлцэх, дасгал, даалгавар гүйцэтгэх, дүрд тоглох зэрэг сонирхолтой, идэвхтэй, хөгжөөнтэй үйл ажиллагаанд оролцоно.
- Мөн зочинтой хичээл, танилцах аялал, уулзалт зэрэг үйл ажиллагаа нь хичээлийн нэг чухал арга, хэлбэр байна.

3.2. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

- Сургууль, орон нутаг, эх орны газрын зураг, түүхийн зураг, атлас, музейн үзмэр, танилцуулга, бусад зураг, баримт, тохиолдол
- Сургууль, орон нутаг, эх орны нийгэм, түүхийн үйл явдалд холбогдох мэдээллийн эх сурвалж (телевиз, радио, тогтмол хэвлэл) болон ном зохиол
- Сургууль, орон нутаг, эх орны нийгэм, түүх, түүхэн хүмүүсийн намтар, үйл ажиллагаанд холбогдох кино, дүрс бичлэг, цахим хэрэглэгдэхүүн зэрэг болно

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

Үнэлгээнд дараах үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтална.

4.1. Үнэлгээний зорилт

- А. Мэдлэг, ойлголт
- Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар
- В*. Хандлага

* Сурагчийн хандлагыг ажиглалт, ярилцлага, рубрик зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А.Мэдлэг, ойлголт (сурагч хам сэдвийн хүрээн дэх мэдлэг, ойлголтыг эзэмшсэн байх)	А1. Судалсан хам сэдвийн хүрээнд хүн ба нийгмийн харилцааны тухай үг хэллэг, мэдлэг, ойлголт А2. Эх орныхоо түүх, соёлын гол үйл явдал, түүхэн хүмүүсээс нэрлэж, тэдгээрийн үйл ажиллагааг тайлбарлах байдал А3. Нийгэм, түүхийн үйл явдлын он цаг, түүний дараалал болон орон зайн хамаарал

Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар (сурагч мэдлэг, ойлголтоо хэрэглэх чадвартай байх)	Б1. Гэр бүл, сургууль, орон нутгийнхаа нийгэм, аж ахуй, соёл, хүмүүсийн амьдралын талаар тайлбарлах Б2. Эх орныхоо түүх, соёлын гол үйл явдал, түүхэн хүмүүсийн үйл ажиллагаанд холбогдох жишээ, баримтыг хэрэглэх Б3. Асуултыг төлөвлөж, бусдаас асуулт асуух Б4. Асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийг олж, боловсруулж, хэрэглэх
В. Хандлага (сурагчид зохих хандлага төлөвшсөн байх)	В1. Гэр бүл, сургууль, орон нутгийн хүрээнд зан үйлийн хэм хэмжээ, дэгийг баримталж байгаа байдал В2. Хүмүүсийн болон нийгмийн харилцаанд идэвхтэй оролцож, зохистой харилцаж, хамтран ажиллаж буй байдал В3. Бусдад хүлээцтэй хандаж, туслаж, бусдаас дэмжлэг авч буй байдал В4. Хүн ба нийгмийн асуудлыг эргэцүүлэх, сонирхох, эрмэлзэх болон хичээл зүтгэл гаргаж буй байдал

Үнэлгээний арга, хэлбэр

Явцын үнэлгээ

- Багшийн өдөр тутмын ажиглалт, ярилцлага, тэмдэглэлээр
- Сурагчийн өөрийн үнэлгээгээр
- Сурагчийн эцэг, эх, асран хамгаалагчийн ажиглалт, сэтгэл ханамжаар

Үр дүнгийн үнэлгээ

- Тусгайлан боловсруулсан сорилын даалгаврын гүйцэтгэл (хам сэдэв, улирал, жилээр)
- Явцын үнэлгээний баримт, тэмдэглэл, нотолгоо
- Сурагчийн бүтээл буюу бодит үйл
- Хөндлөнгийн үнэлгээ

Үнэлгээний хэрэгсэл

- Ажиглалтын хуудас
- Хэлэлцүүлэгийн санамж
- Амаар, бичгээр илэрхийлэх аргачлал
- Үнэлгээний рубрик
- Үйлдэх, үзүүлэх, харуулах (бүтээл хийх, дүрд тоглох гэх мэт) дараалал, загвар
- Өөрийн болон үр дүнгийн үнэлгээний хуудас
- Сорил, даалгаврууд
- Даалгавар гүйцэтгэх хуудас зэрэг болно.

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт		Эзлэх хувийн жин
1	Мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгавар	40%
2	Мэдлэгээ хэрэглэх чадвар, хандлагыг үнэлэх даалгавар	60%

УРЛАГ

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийг танин мэдэх арга барилтай, гоо сайхны мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх, хөгжүүлэх, соёлын өв, уламжлалаа хүндэтгэх хүсэл эрмэлзэлтэй иргэн болж төлөвшинө.

1.2. Зорилт

1.2.1. Урлагийн хэл, нэр томъёог танин мэдэх;

1.2.2. Хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийг тайлбарлах, илэрхийлэх;

1.2.3. Урлагийн бүтээл, үндэсний өв уламжлалаа хүндэтгэх хүсэл эрмэлзэлтэй болох.

Урлагийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	III анги	V анги
Мэдрэх, хүлээж авах	- Хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийг сонирхох, ажиглах, сонсох, ойлгох - Хүрээлэн буй орчин, амьдрал, хүмүүсээс бий болсон хувь хүний мэдрэмж санаагаа илэрхийлэх, бусадтай хуваалцах	- Хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлээс төрсөн сэтгэгдэл болон сэдлээ өөрийнхөөрөө сайжруулах, санал гаргах - Хэрэгцээ, сонирхол, туршлагаас бий болсон мэдрэмж санааг илэрхийлэх, бусадтай хуваалцах
Гүйцэтгэх ур чадвар	- Урлагийн бүтээлтэй танилцах, дуурайн хийх - Урлагийн хэлийг ашиглан аливаа үйлийг гүйцэтгэх - Өөрсдийн санаа, бүтээлийг ярьж тайлбарлах	- Янз бүрийн хүрээнд урлагийн хэлийг ашиглан, зааврын дагуу гүйцэтгэх - Бие даан болон багаараа санаагаа хэрэгжүүлж, хамтран хийж гүйцэтгэх - Даалгаврыг гүйцэтгэхдээ өөртөө итгэлтэй байх
Бүтээх, хөгжүүлэх	- Өөрийн сэтгэгдэл, эргэн тойрон дахь байгаль, амьдралаас бий болсон хувь хүний мэдрэмж санааг илэрхийлэх хоёр ба гурван хэмжээст урлагийн бүтээл зохиох, хийх - Бүтээлийн онцлог шаардлагад нийцүүлэн материал, багаж хэрэгсэл сонгож ашиглах - Хувь хүний ойлголтыг илэрхийлэхдээ зохиомжийн хэрэгслүүдийг /өнгө, цэг, толбо, зураас, дүрс /ашиглах - Сэдвийн хүрээнд урлагийн бүтээл зурах бүтээхдээ зохиомжийн зарчмыг /тэгш ба тэгш бус хэм, хэмнэл, давтамж/ ашиглан зохиомжийн талаарх ойлголтоо харуулах - Бүтээлийн санаа, загвар дизайнаа олох, шинэ бүтээлээ илэрхийлэх турших	- Хэрэгцээ, сонирхол, туршлагаас бий болсон мэдрэмж санааг илэрхийлэх хоёр ба гурван хэмжээст урлагийн бүтээл зохиох, хийх - Зохиомжийн шаардлагад нийцүүлэн төрөл бүрийн материал, багаж хэрэгсэл, техник ашиглах - Зохиомжийн элементүүдийг /өнгө, цэг, толбо, зураас, дүрс, биет, харьцаа, хөдөлгөөн гэх мэт/ ашиглан хувь хүний ойлголтоо илэрхийлэх - Сэдвийн хүрээнд урлагийн бүтээл зохиохын тулд зохиомжийн зарчмыг /тэгш ба тэгш бус хэм, хэмнэл, давтамж, нэгт төвт, өнцөглөсөн, дэлгэмэл гэх мэт/ ашиглан зохиомжийн талаарх ойлголтоо харуулах - Шинэ бүтээлийн /зохиомжийн/ болон хөгжмийн санаа гаргахын тулд хэрэгцээтэй мэдээллийг цуглуулах, бүтээх хөгжүүлэх - Цуглуулсан мэдээллээ боловсруулах явцдаа арга барил, материалыг сонгож хэрэглэж сурах

Илэрхийлэх, үнлэх	- Өөрийн болон бусдын бүтээлтэй танилцах, шинэ санаа авч бүтээлдээ ашиглах, туршлагаа хуваалцах - Өөрийн болон бусдын бүтээлийг өөрчлөх арга замыг эрэлхийлж сайжруулах - Бусадтай санаа бодлоо хуваалцах, өөрийн бүтээлээр бахархах, бусдын бүтээлийг хүндэлж байгаагаа илэрхийлэх	- Өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бүтээлдээ тусгах, илэрхийлэх арга хэлбэрээ төлөвлөх - Бусдыг болон бусдын хийсэн бүтээлийг хүндэлж байгаагаа илэрхийлэх
-------------------	---	--

ХОЁР. АГУУЛГА

ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИ

I АНГИ

1.1. ДҮРСЛЭХ УРЛАГ

- 1.1а. Зургийн багаж, хэрэглэгдэхүүнийг таньж хэрэглээг тодорхойлох
- 1.1б. Тосон харандаагаар ажиллах арга барилыг зураг дүрслэлд хэрэглэх
- 1.1в. Энгийн хэлбэр дүрс зурахдаа цэглэх, толболох, цэгүүдийг холбох аргыг ашиглах
- 1.1г. Энгийн дүрсээс бүтсэн эд юмсыг дүрслэхдээ шулуун, долгион, нуман, тахир зураасыг хэрэглэх
- 1.1д. Үндсэн 5 дүрсийн нийлэмжийг эд юмсыг дүрслэхдээ ашиглах
- 1.1е. Усан будгаар ажиллах арга барилыг зураг бүтээлдээ хэрэглэх
- 1.1ж. Нэг ба олон өнгөөр зурсан зургийн ялгааг харьцуулах, зураг дүрслэлдээ ашиглах
- 1.1з. Өөрийн бодол төсөөллөөр зурсан зургаас гол ба туслах дүрийг таньж тодорхойлох
- 1.1и. Өөрийн бодол төсөөллөөр зурсан зургаас наана цаана байгаа зүйлсийг таньж тодорхойлох

1.2. ТЕХНОЛОГИ

- 1.2а. Үндсэн дүрсийг хайчлах, эвлүүлэх, өрөх аргаар бүтээх
- 1.2б. Үндсэн дүрсийг зохиомжлон наах аргаар бүтээл хийх
- 1.2в. Үндсэн дүрсийг эвлүүлж наах аргыг техникийн загвар бүтээхэд хэрэглэх
- 1.2г. Амьтны ба техникийн загвар бүтээхэд цаасыг тэнцүү хэсэг болгон нугалж хайчлах аргыг ашиглах
- 1.2д. Цаасыг нугалах аргаар бүтээл хийх
- 1.2е. Навч өрж наах аргаар амьтны дүрс бүтээх
- 1.2ж. Баримлын шавартай ажиллах хэрэглэгдэхүүнийг таньж зориулалтыг тодорхойлох
- 1.2з. Баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх аргаар хагас товгор дүрс бүтээх
- 1.2и. Баримлын шаврыг цувих, хэрчих, бөөрөнхийлөх, холбох, мушгих аргаар хүнсний ногоо, жимс жимсгэний загвар хийх

II АНГИ

2.1. ДҮРСЛЭХ УРЛАГ

- 2.1а. Үндсэн өнгийг хольж, үүсмэл өнгүүдийг үүсгэх замаар үндсэн болон үүсмэл өнгийг ялгааг таньж тодорхойлох
- 2.1б. Үндсэн болон үүсмэл өнгийг зураг дүрслэлдээ ашиглах
- 2.1в. Хуруугаар дардаслах аргаар толбо үүсгэн өөрийн бодол төсөөллөөр баяжуулан зурах
- 2.1г. Ургамал, амьтан дүрслэхдээ махир зураасыг хэрэглэх
- 2.1д. Эд юмсыг зурахдаа үндсэн 5 дүрсийн хэлбэр, хэмжээг өөрчлөх аргыг ашиглах
- 2.1е. Уншсан зүйлийнхээ агуулгаар зурсан зургаас гол ба туслах дүрийн ялгааг тайлбарлах
- 2.1ж. Давхцуулан зурах аргаар юмсын наана, цаана хол, ойр байршлыг дүрслэн харуулах
- 2.1з. Хоёр өнгөөр дагнааслан будах аргаар цэцэг, навчин хээг дүрслэх
- 2.1и. Чулуун дээр зураас арилгагч (штрих), шохойн ба лааны тосон харандаагаар зураг зурах аргыг хэрэглэх

2.2. ТЕХНОЛОГИ

- 2.2а. Үндсэн дүрсээр нийлмэл дүрс бүтээж харьцуулан тайлбарлах
- 2.2б. Ам дөрвөлжин цаасан нугалаагаар амьтны дүрс бүтээх
- 2.2в. Цаасыг хуйлах, тэнийлгэх аргаар бэлэг дурсгалын бүтээл хийх
- 2.2г. Үндсэн болон нийлмэл дүрсийг эвлүүлж наах аргаар техникийн загвар бүтээх
- 2.2д. Олон дүрс ашиглаж, эвлүүлдэг тоглоом зохион бүтээх
- 2.2е. Ургамал, амьтны дүрс бүтээхэд баримлын шаврыг цаасан дээр нялж наах аргыг ашиглах
- 2.2ж. Баримлын шавар, савх модыг холбох аргаар мал, амьтны загвар хийх, бүрдэл хэсгийг нэрлэх
- 2.2з. Өвс ургамал, навчаар 2 хэмжээст бүтээл хийх
- 2.2и. Өнгө өнгийн чулууг баримлын шавраар холбох аргаар амьтны баримал хийх
- 2.2к. Номын хавчуурга хийхэд төрөл бүрийн материалыг ашиглах
- 2.2л. Шувууны тэжээл бэлтгэхэд цаасан хайрцаг ашиглах

III АНГИ

3.1. ДҮРСЛЭХ УРЛАГ

- 3.1а. Өнгийн хүрдийг ажиглаж дулаан, хүйтэн өнгийг ялгааг таньж тодорхойлох
- 3.1б. Дулаан, хүйтэн өнгийг байгалийн зураг дүрслэлд ашиглах
- 3.1в. Санамсаргүйгээр толбо үүсгэх аргыг зураг дүрслэлдээ ашиглах
- 3.1г. Юмсын хатуу, зөөлөн, тогтвортой, хөдөлгөөнтэй зэрэг шинж чанарыг зураасны төрлүүдээр илэрхийлэх
- 3.1д. Үндсэн дүрсүүдийг дардаслан олшруулах аргаар зохиомжийн ойлголтоо харуулах
- 3.1е. Хүүхдийн зураг, бүтээлүүдээс төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлэх
- 3.1ж. Бодит болон хийсвэр зургийг харьцуулан орон зай илэрхийллийн ялгааг тайлбарлах
- 3.1з. Монголын зураачдын уран зургийн бүтээлийг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах
- 3.1и. Гурван өнгөөр дагнааслан будах аргаар эвэр угалз дүрслэх

3.2. ТЕХНОЛОГИ

- 3.2а. Үндсэн ба нийлмэл дүрсийн хэлбэрийг өөрчлөх аргаар загвар бүтээх
- 3.2б. Зааврын дагуу цаасыг 5-аас дээш нугалж загвар бүтээх

- 3.2в. Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар бүтээх
- 3.2г. Хатуу цаасыг хуйлж хэлбэржүүлэх аргаар амьтны загвар бүтээх
- 3.2д. Цаасыг нугалж хайчлах аргаар тэгш хэмийн ойлголтыг тайлбарлах
- 3.2е. Цаасыг тэгш хэмээр нугалж, хайчлах аргаар техникийн загвар бүтээх
- 3.2ж. Эд ангийг үлгэр ашиглан зурж хайчилж угсрах аргаар техникийн загвар бүтээх
- 3.2з. Байгалийн материалыг зохиомжлон наах, холбох аргаар бүтээл хийх
- 3.2и. Янз бүрийн материалыг будаж хооронд нь холбох, хайчлах, чимэглэх аргаар бүтээл хийх
- 3.2к. Баримлын шавраар хийсэн геометрийн энгийн биетүүдийг өрж холбох аргаар хэлбэрийг өөрчлөх, хувиргах
- 3.2л. Баримлаар хийсэн амьтад, юмсын загварыг зохиомжлон байрлуулах аргаар үйл явдал илэрхийлсэн баримал бүтээх
- 3.2м. Өнгийн ноосон утас ашиглан бөмбөлөг хийх аргаар бүтээл хийх
- 3.2н. Зүүлтийн гоёл чимэглэлд өнгийн ноосон утсыг хатуу цаасанд ороох, цаасны ирмэг дагуу хайчлах, цацагласан утсаа багцалж боох аргыг ашиглах

IV АНГИ

- 4.1. ДҮРСЛЭХ УРЛАГ
 - 4.1а. Өнгийн хүрднээс эсрэг өнгийг байрлалаар нь ялгаж, эсрэг өнгийн ялгарлыг ажиглан тодорхойлох
 - 4.1б. Эсрэг өнгийн ялгарлыг зураг дүрслэлдээ ашиглах
 - 4.1в. Төрөл бүрийн материалаар толболох аргыг зураг дүрслэлдээ ашиглах
 - 4.1г. Хөгжмийн аялгууг сонсоод зураасны төрлүүдээр илэрхийлэх
 - 4.1д. Нэг төвт зохиомжийн онцлогийг зураачдын бүтээлийн жишээн дээр тайлбарлах
 - 4.1е. Үндсэн дүрс ба биетийг бүтээхдээ орон зайн ялгааг анзаарах
 - 4.1ж. Амьтны биеийн ерөнхий хэмжээ, харьцааг баримжаалан дүрслэх
 - 4.1з. Араг зургийн аргаар амьтдын хөдөлгөөнийг дүрслэх
 - 4.1и. Хүүхдийн болон монгол зургийн бүтээлийг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах
 - 4.1к. Мартан, нагтан зургийн аргаар өөрийн бодол төсөөллийг дүрслэх
- 4.2. ТЕХНОЛОГИ
 - 4.2а. Цаасны үүсэл болон боловсруулах үе шатыг жишээн дээр тайлбарлах
 - 4.2б. Цаасан хайрцаг задалж тэгш өнцөгт биетийн дэлгээс судалж тайлбарлах
 - 4.2в. Тэгш өнцөгт биетийн дэлгээс байгуулах аргаар тоглоомын загвар бүтээх
 - 4.2г. Хавтгай дүрсүүдийг сэтэлж хайчлах аргаар холбож 3 хэмжээст бүтээл хийх
 - 4.2д. Төрөл бүрийн биетүүдийг загварчлах аргаар бүтээл хийх
 - 4.2е. Туузан цаасыг хэлбэр үүсгэн холбох аргаар 3 хэмжээст чимэглэлийн бүтээл хийх
 - 4.2ж. Шигтгэж чимэглэл хийхэд байгалийн материал (будaa, чулуу, самрын яс)-ыг ашиглах
 - 4.2з. Цаасыг хэлбэрт оруулж тугалган цаасаар бүрэх аргаар амьтдын баримал урлах
 - 4.2и. Хаягдал материалаар хүндрүүлэгч ачаа, харимхай металл салхины хүч ашиглан техникийн загвар бүтээх
 - 4.2к. Гар оёдлын багаж хэрэгслийг жижиг эдлэл хийхэд ашиглах
 - 4.2л. 2-3 төрлийн орц найрлагатай хөнгөн зууш бэлтгэх
 - 4.2м. Ажил мэргэжлийн онцлогийг жишээгээр тайлбарлах

V АНГИ

- 5.1. ДҮРСЛЭХ УРЛАГ
- 5.1а. Дүрслэх урлагийн төрөл зүйлийг бүтээлийн жишээгээр тайлбарлах
- 5.1б. Өнгийн уламжлалт нэршил, бэлгэдлийг тайлбарлах, нэг өнгийг цайруулах аргыг зураг дүрслэлдээ ашиглах
- 5.1в. Биетийн гэрэл сүүдрийг дүрслэхдээ цэглэх, толболох аргыг ашиглах
- 5.1г. Задгай болон өнцөглөсөн зохиомжийн ялгааг харьцуулан зураачдын бүтээлийн жишээн дээр тайлбарлах
- 5.1д. Юмсын хол, ойр байршлыг нэг цэгийн алслалттай холбон тайлбарлах
- 5.1е. Юмсын хол, ойр байршлыг хүйтэн дулаан өнгө, хүнд хөнгөн өнгийн ялгаатай холбон тайлбарлах
- 5.1ж. Хүний нүүрний хэсгүүдийн хэмжээ, харьцааг дүрслэх аргыг зураг дүрслэлдээ ашиглах
- 5.1з. Гадаадын зураачдын уран зургийн бүтээлийг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах
- 5.1и. Геометрийн дүрсийн гаралтай хээ угалзыг дүрслэх
- 5.1к. Түйхий ба их дагнаасын харьцуулах онцлог, ялгааг тайлбарлах
- 5.1л. Монгол зургийг орон зайтай дүрслэх аргыг жишээн дээр тайлбарлах
- 5.2. ТЕХНОЛОГИ
- 5.2а. Цаас дахин боловсруулан ашиглах талаар жишээн дээр тайлбарлах
- 5.2б. Цаасыг нугалах, хуйлах аргаар чимэглэлийн загвар хийх
- 5.2в. Нимгэн кардон хуйлж ирмэгээр нь зөрүүлэн наах аргаар цилиндр, конус биет бүтээх
- 5.2г. Цилиндр, конус биетийн бүрдэл хэсгийн тоог нэмэх аргаар загварчилж бүтээл хийх
- 5.2д. Автомашины загварын хэлбэрийг өөрчлөх аргаар зориулалтыг тодорхойлох
- 5.2е. Байгалийн материал (боргоцой, чулуу)-ын хэлбэрийг ашиглан бүтээл хийх
- 5.2ж. Цаасан зуурмагаар баримал, шуумал хийх
- 5.2з. Цаасан тавагны хэлбэрийг өөрчлөх аргаар малгайн загвар бүтээх
- 5.2и. Энгийн гар оёдлын төрлүүдийг зөөлөн эдлэл хийхдээ ашиглах
- 5.2к. 3-4 төрлийн орц найрлагатай хачиртай талх бэлтгэх
- 5.2л. Сургууль дээрх ажил мэргэжлүүдийн нэрлэх онцлог болон нийтлэг талыг жишээгээр тайлбарлах

ХӨГЖИМ

НЭГДҮГЭЭР АНГИ

- I. БАЙГАЛИЙН ДУУ ЧИМЭЭ
- 1.1а. Байгалийн дуу чимээ, тэдгээрийн шинж төрх, өнгө аясыг сонсож тодорхойлох, ялган таних
- 1.1б. Дуу, дасгалыг дагаад дуулахдаа биеийн байршил, амьсгааг зөв эзэмшсэнээ харуулах
- 1.1в. Хөгжмийн энгийн зэмсгээр дуу авиа үүсгэх арга (цохих, сэгсрэх, шигших, хавсрах) барил эзэмшсэнээ харуулах
- 1.1г. Хөгжмийн аялгуунд нийцүүлэн найгах, ганхах, эргэх хөдөлгөөнийг гүйцэтгэх
- 1.1д. Төрөл бүрийн материал ашиглан хөгжмийн энгийн зэмсэг бүтээж, байгалийн дуу чимээ, амьтдад тохирох дуу авиа үүсгэж үзүүлэх
- II. ХЭМ, ХЭМЖЭЭ
- 1.2а. Хялбар дуу, аялгууг сонсож, хэмжээ хэмнэлийг тодорхойлох, жишээгээр харуулах

- 1.2б. Өөрийгөө болон бусдыг сонсож, хэмжээ хэмнэлд нийцүүлэн дууны үгийг тод, зөв хуваарилж хамтран дуулах
- 1.2в. Эгшгийн уртаашийг (дөрөвт, наймт,) ялган таних, дүрсээр тэмдэглэх, хөгжмийн энгийн зэмсэг ашиглан 2 хувьт хэмд хэмнэлээр дагаж хөгжимдөх
- 1.2г. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хүчтэй, сул хувийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулах
- 1.2д. Хоёр хувиар хэмнэл зохиосноо хөгжмийн энгийн зэмсгээр хөгжимдөх
- III. ЭНГИЙН ХЭМНЭЛ
- 1.3а. Хөгжмийн төрөл зүйл /дуу, бүжиг, марш/-ийг сонсож тодорхойлох, сэтгэгдэлээ илэрхийлэх
- 1.3б. Сонсголын тогтоолт дээр тулгуурлан 2 ба 3 хувьт хэмд хэмжээ, хэмнэлээ нийлүүлэн нэгэн зэрэг дуулах
- 1.3в. Хоёр ба гурван хувьт хэмд сонсголын тогтоолт дээр тулгуурлан бие даан ноотоор хөгжимдөх
- 1.3г. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг тодорхойлж, тохирох дүрийг (цэцэг, амьтад,...) хөдөлгөөнөөр илэрхийлэх
- 1.3д. Янз бүрийн хэмнэлээр тодорхой сэдэвт зохиомж хийж /морьд, бороо, марш, бүүвэй,/ үзүүлэх
- IV. АЯЛГУУНЫ ХЭМ, ХЭМНЭЛ
- 1.4а. Хөгжмийн төрөл зүйл /дуу, бүжиг, марш/-ийг сонсож, хэмнэл, аялгууны шинж төрхийг тодорхойлох
- 1.4б. Дууны утга агуулгыг ойлгож, сэтгэл хөдлөлөө илэрхийлэн, гоцлол, найрлаар хөг нийлүүлэн дуулах
- 1.4в. Хоёр ба гурван хувьт хэмтэй дуу аялгуунд хэмнэлийн хамсраа хийж, хэмжээ, хэмнэл нийлүүлэн хамтран хөгжимдөх
- 1.4г. Тойрон бүжиг, аялгуут тоглоом, хөгжимт хөдөлгөөн хийхдээ аялгууны шинж төрх, хэмжээ, хэмнэл, хурд, хүчийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулах, өөрийнхөөрөө баяжуулан илэрхийлэх

ХОЁРДУГААР АНГИ

- I. ХӨГЖМИЙН ДУУ АВИА
- 2.1а. Хүний дуу хоолойн өнгө аясыг сонсож тодорхойлох, сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой өөрчлөгддөгийг жишээгээр харуулах
- 2.1б. Энгийн хэмнэлийг эгшгийн өндөр намтай холбон өндрийн зураглал, тулгуур дохиог харж дуулах
- 2.1в. Өгөгдсөн аялгуунд хөгжмийн энгийн зэмсгээр хэмнэлийн хамсраа зохион хөгжимдөх
- 2.1г. Хөгжмийн зохиолын айзам хэмжээг мэдэрч, хөгжимт хөдөлгөөнөөр гүйцэтгэх
- II. ХӨГЖМИЙН ЭГШИГ ТЭМДЭГЛЭГЭЭ
- 2.2а. Эгшгийн өндөр намыг ялган сонсож, хөгжмийн дүрийг тодорхойлоход ашиглах
- 2.2б. G1-C2 эгшгийг дэвсгэр шугамд байрлуулж, ноотоор дуулах
- 2.2в. G1-C2 эгшгүүдээр давтах, өгсөх, уруудах хөдөлгөөнийг дуулах
- 2.2г. Хөгжмийн энгийн зэмсгийн дуугаралтын ялгааг илэрхийлэн 2 хоолойгоор хөгжимдөх
- 2.2д. Хөгжмийн зохиолын аялгууны чиглэл хөдөлгөөнийг мэдэрч, хөгжимт хөдөлгөөнөөр илэрхийлэх

III. ХӨГЖМИЙН ЭГШГИЙН ХӨДӨЛГӨӨН БА АЯЛГУУ

- 2.3а. Хялбар дуу, аялгууг сонсоод, эгшгийн өндөр нам, урт богино, аялгууны чиглэл хөдөлгөөнийг зураглах
- 2.3б. F1-C1 эгшгийг дэвсгэр шугамд байрлуулж, ноотоор дуулахдаа үсгэн тэмдэглэгээ, зогсоцын тэмдгийг ашиглах
- 2.3в. Цэгтэй ноот, зогсоц бүхий хэмнэлээр 2 хоолойгоор хөгжимдөх
- 2.3г. Алчуур, тууз, савх, дарцаг зэрэг хэрэгсэл ашиглан хөгжимт хөдөлгөөн хийж гүйцэтгэх
- 2.3д. Өгөгдсөн график зураглалаар /өгсөх, уруудах, давтах/ аялгуу зохиох

IV. АЯЛГУУНЫ ШИНЖ ТӨРХ

- 2.4а. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг сонсож тодорхойлох, зураглах, амьтдын төрх араншинг илэрхийлэх
- 2.4б. C1-C2 цараанд хялбар дуу, дасгалыг ноотоор дуулахдаа дууны утга агуулгыг ойлгож, өнгө эгшиг, үг хэллэг, амьсгааг хянаж чадахаа харуулах
- 2.4в. Үгийн үеийг ашиглан хялбар хэмнэлийн цээж бичиг бичиж, хөгжимдөх
- 2.4г. Тодорхой сэдвээр /эрвээхий, цэцэг, шувуухай/ хөгжимт хөдөлгөөн хийж, дүр төрхийг илэрхийлэх
- 2.4д. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхөд тохируулан чөлөөт хөдөлгөөн зохиомжлох

ГУРАВДУГААР АНГИ

I. ӨНГӨ АЯС

- 3.1а. Хөгжмийн зэмсгийн эгшиглэлтийн өнгө аясыг ялган таних, зэмсгүүдийг бүлэглэн тайлбарлах
- 3.1б. Дууны ноот бичлэг дэх цэгтэй болон догол хэмнэлийг дуулах
- 3.1в. Бишгүүрээр G-H эгшгийн багтаамжид хөгжимдөх арга барил эзэмшсэнээ харуулах
- 3.1г. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хэмнэлийн онцлогийг янз бүрийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлэх
- 3.1д. Хөгжмийн зэмсгүүдийн дуу авиа үүсгэх арга замыг тодруулж ангилах

II. ХУРД, ХҮЧДЭЛ

- 3.2а. Хөгжмийн уран бүтээлээс өнгө аяс, хурд, хүчний өөрчлөлтийг сонсож тодорхойлох
- 3.2б. Ноот бичлэгээс хурд, хүчний тэмдэглэгээг таньж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулах
- 3.2в. G1-D2 цараанд дуу, дасгал, аялгууг ноотоор хөгжимдөхдөө хурд, хүчний тэмдэглэгээг илэрхийлэх
- 3.2г. Хөгжмийн зохиолын агуулга, дүр, өгүүлэмжийн онцлог шинжийг хөдөлгөөнөөр дүрслэх
- 3.2д. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг зураглалаар илэрхийлэх

III. ХӨГЖМИЙН БАЙГУУЛАМЖ

- 3.3а. Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, бүрэлдэхүүнийг (гоцлол, цөөхүүл, найрал) тодорхойлох, тайлбарлах
- 3.3б. Дууны уран бүтээл дэх давталт ялгарамжийг (бадаг, дахилт, тухайлбар, өгүүлбэр) тодорхойлж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулах
- 3.3в. C1-D2 цараанд ноотоор хөгжимдөх, дуу, аялгуун дахь давталт ялгарамжийг (тухайлбар, өгүүлбэр) тодорхойлох

- 3.3г. Хөгжмийн зохиолын аялгууны бүтэц хэсгийг мэдэрснээ хөдөлгөөний шилжилт, өөрчлөлтөөр илэрхийлэх
- 3.3д. Өгсөн хэмнэлийг хувилбарлан хөгжүүлэх /A1,A2,A3/
- IV. ХӨГЖМИЙН ЦАРАА
- 3.4а. Хөгжмийн уран бүтээлийн аялгууны шинж төрх, хурд хүчний өөрчлөлтөөр зохиолын өгүүлэмжийг тайлбарлах
- 3.4б. Дууны шүлгийн утга санаа, аялгууны шинж төрхийг тайлбарлах, удирдаачийн дохиогоор дуулах
- 3.4в. C1-D2 цараанд удирдаачийн дохиогоор хөгжимдөх
- 3.4г. Хөгжимт дасгалыг янз бүрийн хэрэгсэлтэй гүйцэтгэх
- 3.4д. Өгөгдсөн хэмд хэмнэлийн янз бүрийн багцлал зохиох

ДӨРӨВДҮГЭЭР АНГИ

- I. СЭТГЭЛ ХӨДЛӨЛ БА ХӨГЖИМ
- 4.1а. Хөгжмийн зохиолын лад хөгийг /мажор, минор/ ялган сонсох, агуулга дүрийг тайлбарлах
- 4.1б. Мажор, минорын ладад хялбар аялгууг ноотоор дуулах
- 4.1в. Мажор, минорын ладад хялбар аялгууг бишгүүрээр /пианика/ хөгжимдөх
- 4.1г. Хөгжмийн зохиолын эгшиглэгээний өнгө аясыг мэдэрч, сэтгэл хөдлөлөө илэрхийлж бүжиглэх
- 4.1д. Сэтгэлийн хөдөлгөөний гадаад илрэл (баярлах, гуниглах, бодлогошрох)-д тохирох хөгжмийн сонголт хийж, хөгжимт хөдөлгөөн зохиомжлох
- II. УРАН ИЛЭРХИЙЛЛИЙН АРГУУД
- 4.2а. Хөгжмийн зохиолоос уран илэрхийллийн хэрэглүүрийг сонсож таних, тодорхойлох
- 4.2б. Сонгогдсон бүтээлийг уран илэрхийлэлтэй дуулах
- 4.2в. Хялбар дуу аялгууг уран илэрхийлэлтэй хөгжимдөх
- 4.2г. Хөгжмийн зохиолын уран илэрхийллийн хэрэглүүрийг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлэх
- III. ХӨГЖМИЙН ЭНГИЙН ХЭЛБЭРҮҮД
- 4.3а. Хөгжмийн зохиолын энгийн хэлбэрийг ялган таних /AB, ABA/
- 4.3б. Хүүхдийн болон ардын дууг харилцаа болон хөөцөл хэлбэрээр дуулах
- 4.3в. Хялбар дуу аялгууг харилцаа болон хөөцөл хэлбэрээр хөгжимдөх
- 4.3г. Тодорхой сэдэв, дүрийг илэрхийлэх хөгжмийн зохиолын сонголт хийж, хөгжимт хөдөлгөөн зохиомжлох
- 4.3д. Хөгжмийн хэлний хэрэглүүрүүдийг ашиглан сэтгэл хөдлөлийг илэрхийлэх, тодорхой дүрслэл үүсгэх
- IV. ХӨГЖМИЙН ЗОХИОЛЫН ДҮР ДҮРСЛЭЛ
- 4.4а. Хөгжмийн зохиолын энгийн хэлбэрийг агуулгатай холбон тайлбарлах
- 4.4б. Ноот бичлэгт ажиглалт хийж, дууны утга агуулгыг илэрхийлэн хоёр хоолойгоор дуулах
- 4.4в. Хялбар дуу, аялгууны айзам хэмжээ, чиглэл хөдөлгөөнийг тодорхойлж, хоёр хоолойгоор хөгжимдөх
- 4.4г. Хөгжмийн уран бүтээлийн агуулга, дүр дүрслэлийг график дүрслэл, зурах, бичих, жүжигчилэх зэргээр илэрхийлэх

ТАВДУГААР АНГИ

I. АЯЛГУУ

- 5.1a. Хөгжмийн зохиолын энгийн хэлбэрийг (AB, ABA, ABC, A1, A2, A3) тодорхойлох, ялган таних
- 5.1б. Диатоник, пентатоник мажор, минорын ладад дуулж, ялгааг тайлбарлах
- 5.1в. Утга санаа илэрхийлж, уран яруу /ньюанстай/ гоцлол, найрал хэлбэрээр хоёр хоолойгоор хөгжимдөх
- 5.1г. Тодорхой сэдвийн (галт тэрэг, уралдаан, бүүвэй гэх мэт) дагуу хэмнэлийн зохиомж хийх

II. ХӨГ ЭГШИГЛЭГЭЭ

- 5.2a. Хөгжмийн зохиолын эгшиглэгээний онцлогийг /пентатоник, диатоник/ сонсож тодорхойлох
- 5.2б. Эгшиг зохиролоор /консонанс, диасонанс интервал/ дуулж, онцлогийг тайлбарлах
- 5.2в. Бүжгийн энгийн элемент бүхий дасгалыг гүйцэтгэх
- 5.2г. Хөгжмийн энгийн зэмсгүүдийг ашиглан цохивор хөгжмийн найруулгыг жишээгээр харуулах

III. ХЭЛБЭР

- 5.3a. Эгшиг зохирлыг /консонанс, диссонанс, интервал/ сонсож таних
- 5.3б. Ноот бичлэгийг харж канон, имитаци хэлбэрийг тайлбарлан гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулж, хөгжимдөх
- 5.3в. Хөгжмийн зохиолын агуулга дүрийг хөдөлгөөнөөр илэрхийлэх
- 5.3г. Өгөгдсөн аялгууг хөгжүүлэх, хувилбарлах

IV. ХӨГЖМИЙН ХЭЛ

- 5.4a. Хөгжмийн зохиолын төрөл зүйлийг /дуулаач, дан хөгжим/ сонсож тодорхойлох
- 5.4б. Удирдаачийн дохиогоор хурд хүчний өөрчлөлтийг илэрхийлж гоцлол, найрал хэлбэрээр дуулах, хөгжимдөх
- 5.4в. Хөгжим болон хөдөлгөөний уялдаа холбоог тайлбарлах
- 5.4г. Хөгжмийн зохиолын эгшиглэгээний онцлогийг янз бүрийн арга хэлбэрээр (өнгө будаг, зураглал) илэрхийлэх

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

Сурагчийн эзэмшвэл зохих тодорхой мэдлэг, чадвар, хандлагад баримжаалан сурах арга барилын эзэмшилт болон авьяас чадварыг хөгжүүлэхтэй холбогдуулж, дараах зүйлийг анхаарч ажиллана. Үүнд:

- Урлагийн олон талт үйл ажиллагааг бие даасан болон хамтарсан хэлбэрээр гүйцэтгэх, үйлийн явцад суралцах, энгийнээс аажмаар өргөжин гүнзгийрэх арга зүйд суурилна.
- Урын сангийн сонголтыг оновчтой хийж, сурагч бүрийн авьяасыг хөгжүүлэхийн тулд илэрхийлэх арга хэлбэрийг чөлөөтэй сонгох боломж олгох, сургууль болон сурагчийн нөхцөл байдалд тохируулан үр дүнтэй заах арга зүйг боловсруулахыг чухалчилна.
- Өөрийн болон бусад улс орны дүрслэх урлаг, дуу хөгжим, технологийн сургалтын хөтөлбөрийн зорилготой уялдуулан сурагчдад ойлгоход дөхөм, сонирхол, эрэлт хэрэгцээнд нь нийцсэн урлагийн бүтээлийг сонгоно.

- Сурагчдын эрэлт хэрэгцээ сонирхлыг харгалзан театр музей, галерей, үзэсгэлэн үзүүлж, монгол ардын болон сонгодог, орчин үеийн урлагийн бүтээлүүдтэй танилцах боломжийг бүрдүүлж, соёлын өв, урлагийн үнэт бүтээлүүдийг хүндэтгэх, хамгаалах төлөвшил олгоход анхаарна.
- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй, технологи нь сурагч мэдлэг бүтээх идэвхтэй сургалтын аргад тулгуурласан, сурагчдын ялгаатай байдлыг тооцсон, өөртөө итгэлтэй, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, тайлбарлах зэрэг чадварт суралцахад чиглэнэ.

3.2. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

Сургалтыг хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулгыг хэрэгжүүлэхэд нийцсэн анги, кабинетад зохион байгуулна. Анги, кабинетийн гэрэлтүүлэг, өнгөний зохицол нь сурагчдын сэтгэл зүйд нийцсэн, талбай нь хүртээмжтэй байна. Урлагийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг бүрдүүлсэн байна. Үүнд:

Хөгжим

- Бишгүүр, пианика
- Хөгжмийн энгийн зэмсэг
- Төгөлдөр хуур, даралтат хөгжим
- Хөгжмийн уран бүтээлийн аудио болон CD бичлэг

Дүрслэх урлаг

- Өнгийн цаас, зургийн дэвтэр, усан будаг, харандаан будаг, тосон харандаа, бийр гэх мэт
- Зураачдын дүрслэх урлагийн бүтээл
- Муляж, модель зэрэг биет үзүүлэн
- Зурж дүрслэх арга үзүүлсэн зурган үзүүлэн

Технологи

- Өнгийн цаас, картон, байгалийн болон гарын доорх материалууд
- Цаасны хайч, хутга, цавуу, шугам, харандаа, гортиг, баримлын шавар
- Ургамал, амьтан техникийн дүрсэн ба биет загвар
- Видео бичлэг, цахим зурган мэдээлэл

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

Үнэлгээнд дараах үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтална.

4.1. Үнэлгээний зорилт

- А. Мэдлэг, ойлголт
- Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар
- В*. Хандлага

* Сурагчийн хандлагыг ажиглалт, ярилцлага, рубрик зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Мэдлэг, ойлголт	А1. Урлагийн хэл, нэр томьёо
Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар	Б1. Зурах, дүрслэх, зохион бүтээх ур чадварын гүйцэтгэл Б2. Сонсох, дуулах, хөгжимдөх, бүжиглэх ур чадварын гүйцэтгэл
В. Хандлага	В1. Урлагийн бүтээлд хандах хандлага, хүсэл сонирхол В2. Урлагийн олон талт үйл ажиллагаанд оролцох оролцоо, идэвх, зүтгэл

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
А. Мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгавар	40%
В. Мэдлэг, ойлголтоо хэрэглэх чадварыг үнэлэх даалгавар	60%

БИЕИЙН ТАМИР

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь эрүүл чийрэг биетэй, өдөр тутмын амьдралын хэрэгцээг хангахуйц хөдөлгөөний чадвартай, биеийн тамирын дасгалаар хичээллэж бие бялдраа хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй, эрүүл амьдралын дадал хэвшилтэй иргэн болж төлөвшинэ.

1.2. Зорилт

- 1.2.1. Биеийн тамирын хэл, нэр томьёо, биеийн үндсэн ба хүний төрөлхийн хөдөлгөөнийг танин мэдэх;
- 1.2.2. Биеийн тамирын энгийн дасгалыг зөв гүйцэтгэх, спортын тодорхой төрлийн техникийн суурь хөдөлгөөний чадвар эзэмших;
- 1.2.3. Биеийн тамирын дасгал, хөдөлгөөнт тоглоомоор өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй болох.

Биеийн тамирын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагч дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	III анги	V анги
Хөдөлгөөнийг танин мэдэх	- Гар, хөл, их биеийн үндсэн ба завсрын хөдөлгөөнийг нэрлэх, ялгах, - Дасгалын ач холбогдлыг ойлгох, өөрийн үгээр ярилцах - Өөрийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн үзүүлэлтийг мэдэх	- Гар, хөл, их биеийн үндсэн ба завсрын хөдөлгөөнийг хооронд нь зохицуулан холбож биеийн ерөнхий хөгжлийн цогц дасгалыг бүрдүүлэх - Өөрийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн ахиц өөрчлөлтийг тодорхойлох
Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшингээ тодорхойлох	- Гар, хөл, их биеийн үндсэн ба завсрын хөдөлгөөн бүхий хэрэгсэлгүй ба хэрэгсэлтэй цогц дасгалыг дарааллын дагуу гүйцэтгэх, өглөөний дасгал хийж хэвших - Өөрийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтээ дээшлүүлэх цогц дасгалыг тогтмол гүйцэтгэх	- Өглөөний болон алжаал тайлах цогц дасгалыг баяжуулан гүйцэтгэх, ашиглаж хэвших - Биеийн ерөнхий хөгжлийн дасгалыг хамтран гүйцэтгэх - Өөрийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн хувьд дутагдалтай үзүүлэлтийг ахиулах цогц дасгалыг тогтмол гүйцэтгэх
Хөдөлгөөний техникийг гүйцэтгэх	- Жагсаалын энгийн хувилбаруудыг гүйцэтгэх - Мөлхөх, авирах, өнхрөх аргуудыг ашиглах - Шагайг няслах, шүүрэх, шагайн тоглоом тоглох - Янз бүрээр алхах, 30 м хүртлэх зайд хурдтай, 500 м хүртлэх зайд жигд гүйх - Гүйлтээс уртад ба өндөрт саадыг даван харайж харуулах - Жижиг бөмбөг, цагариг, урт богино жад, цаасан саваа, тавганцарыг барих ба шидэх аргуудыг хэрэглэх - Том бөмбөгийг байрандаа ба алхалтаас залж, 1-2 м зайнаас дамжуулж харуулах	- Олуулаа дасгал гүйцэтгэхдээ жагсаалын энгийн хувилбаруудыг ашиглах - Ганцаараа ба хосоороо акробатикийн эвлүүлэг гүйцэтгэх - 50 м хүртлэх зайд хурдтай, 1000 м хүртлэх зайд жигд гүйх - Гүйлтээс уртад ба өндөрт харайж харуулах - Сагсны, волейболын бөмбөгийг шидэх, дамжуулах аргыг хэрэглэх - Хөл бөмбөгийг өшиглөх, тогтоох аргыг хэрэглэх - Жижиг бөмбөг шидэлтийн тэмцээнд оролцох

Хөдөлгөөнөөр дамжуулан харилцах	- Биеийн тамирын хичээлийн үед мөрдөх аюулгүй байдлын дүрмийг хэрэгжүүлэх - Бие биенээ хүндэлж, бусаддаа саад болохгүйгээр дасгалыг гүйцэтгэх	- Дасгалын амжилттай гүйцэтгэлд баяр хүргэх, дэмжих - Дасгалын гүйцэтгэлийн талаар өөрийн санаа бодлоо илэрхийлэх
---------------------------------	--	--

ХОЁР. АГУУЛГА

I АНГИ

1.1. АХУЙН ХЭРЭГЦЭЭТ ДАСГАЛ

- 1.1а. Хувцасны эрүүл ахуйн шаардлагыг биеийн тамирын хичээлд хувцасаа өмсөх, хадгалахдаа хэрэгжүүлэх
- 1.1б. Багшийн үгэн заавраар өндрөөсөө намхан руу нэг эгнээ, хоёроор тоолон нэг эгнээнээс хоёр эгнээ жагсаж харуулах, хөлөө зөөж баруун, зүүн тийш эргэлтийг гүйцэтгэх
- 1.1в. Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг нэрлэх, танин ялгах, үндсэн хөдөлгөөн бүхий цогц дасгалыг хөгжмийн аянд зөв гүйцэтгэх, том бөмбөгтэй цогц дасгалыг хийж харуулах
- 1.1г. Багшийн тусламжтайгаар өөрийн биеийн өндөр, жинг хэмжиж тодорхойлох, биеийн зөв галбиртай болох дасгалыг гүйцэтгэх
- 1.1д. Өглөөний цогц дасгалыг дарааллын дагуу тогтмол хийж хэрэгжүүлэх
- 1.1е. Янз бүрээр мөлхөх аргыг ашиглах, ижил нэрийн ба эсрэг нэрийн хөдөлгөөнөөр авирах аргыг гимнастикийн хана, налуу байрлуулсан гимнастикийн сандал өөд авирахдаа хэрэглэх
- 1.1ж. Өөрийн биеийн жинг ашиглан, гараа ардаа тулж суусан байдлаас гимнастикийн сандал дээр, 50-60 см өндөр тавцан дээр тулалтаас хүчний дасгалыг тодорхой тоогоор гүйцэтгэх
- 1.1з. Сунгалтын ба савалтын идэвхтэй дасгалаар уян чадавхаа сайжруулан, зогсоо байдлаас өвдөг нугалахгүй бөхийж гарын хурууны үзүүрийг газарт хүргэж харуулах
- 1.1и. Янз бүрийн байдлаас шагайг дунд ба долоовор хуруугаар няслаж тоглохдоо талуудыг нэрлэх, дөрвөн бэрхийг үзүүлж тайлбарлах

1.2. АЛХАХ, ГҮЙХ

- 1.2а. Биеийн ба гар, хөлийн зөв хосолсон хөдөлгөөнийг алхах, гүйхдээ хэрэглэх, хурдан гүйх хэрэгцээг тодруулах
- 1.2б. Жижиг саадыг давж алхах, 10 см нарийн зурвас дээгүүр болон 20-30 см өндөр гимнастикийн сандал дээгүүр алхахдаа хөдөлгөөнөө зөв зохицуулж харуулах
- 1.2в. Хөлөө хагас нугалан, өлмий, өсгий дээр урагш ба арагш, хавсарч, том, жижиг, өвдөг өндөр өргөж, хөлөө солибож, биеийн зөв галбираа хадгалан, гарын хөдөлгөөнтэй алхаж харуулах
- 1.2г. Биеийн зөв галбираа хадгалан, гарын 4 янзын хөдөлгөөнтэй алхаж харуулах
- 1.2д. Шулуун замд 10-15 м зайд дунд зэргийн хурдтай гүйх дасгал, тоглоомыг бүтээлчээр гүйцэтгэх
- 1.2е. Гадаа талбайд 300 м зайг туулахдаа алхаа ба зөөлөн гүйлтийг хослуулан ашиглах
- 1.3. ҮСРЭХ, ХАРАЙХ
- 1.3а. Харайхдаа хөлөө бага зэрэг нугалсан байдлаас хүчтэй түлхэх, гараа савах, зөөлөн газардах үйлдлүүдийг уялдуулах учрыг олох
- 1.3б. Байрандаа дээсэнд хоёр хөл дээр үсэрч тоглохдоо дээсийг бугуй, тохойн үеэр эргүүлэх аргыг ашиглах

- 1.3в. Үсэрч тоглохдоо нэг ба хоёр хөл дээрээ янз бүрийн чиглэл рүү үсрэх, эргэх аргыг ашиглах
- 1.3г. Байрнаас хоёр хөлөөр түлхэн урагш, хажуу тийш үсэрч, 15-20 см өндөрт татсан резин дээгүүр давж, 20 см өндөр тавцан дээр гарч, 70-80 см хол харайж харуулах
- 1.3д. Алхалт, гүйлтээс нэг хөлөөр түлхэн үсэрч, хоёр хөл дээр зөөлөн бууж үзүүлэх
- 1.3е. Хоёр хөлөөр түлхэн үсэрч, цувруулан тавьсан 6-8 ш жижиг саадыг давж харуулах
- 1.4. ШИДЭХ, ДАМЖУУЛАХ
- 1.4а. Янз бүрийн бөмбөгний жин, хэмжээг ялгах, шидэлтийн үеийн аюулгүй байдлын дүрмийг тайлбарлах
- 1.4б. Дунд зэргийн хэмжээтэй бөмбөгөөр тоглохдоо бөмбөгийг 1 м зайнаас нэг ба хоёр гараар дамжуулах, барьж авах, өнхрүүлж оновчтой дамжуулах аргыг ашиглах
- 1.4в. Байрнаасаа жижиг бөмбөгийг шидэн байг онох ба 1-2 м өндөрт татсан уяа хэцийг давуулж харуулах
- 1.4г. Том бөмбөгийг байрнаасаа хоёр гараар, жижиг бөмбөгийг нэг гараар аль болох хол шидэж харуулах

II АНГИ

- 2.1. АХУЙН ХЭРЭГЦЭЭТ ДАСГАЛ
- 2.1а. Эрүүл байхын тулд биеийн тамирын олон төрлийн дасгалыг сурч, тогтмол хийх хэрэгтэйг өөрийн үгээр тайлбарлах
- 2.1б. Багшийн командаар нэг эгнээ ба нэг эгнээнээс хоёр эгнээ жагсах, дэс дараагаар тоолох, баруун, зүүн тийш эргэлтийг гүйцэтгэх
- 2.1в. Өглөөний дасгалыг тогтмол гүйцэтгэх, багшийн тусламжтайгаар өөрийн биеийн өндөр ба жингийн өсөлтийг хэмжиж тодорхойлох
- 2.1г. Гар, хөл, их биеийн завсрын хөдөлгөөнийг хослуулан цаасан саваатай, цацагтай, зөөлөн бөмбөгтэй цогц дасгалыг гүйцэтгэх
- 2.1д. Гимнастикийн хананд дүүжигнэлтээс хөлөө нугалан өргөж буулгах, биеэ баруун, зүүн тал руу ээлжлэн эргүүлэх, хөлөө савах, хажуу тийш шилжилтийг гүйцэтгэх
- 2.1е. Тулж суултаас урагш ба арагш өнхрөх, урагш хоёр өнхрөөд босож зогсон харуулах
- 2.1ж. Янз бүрийн тулалтаас сунаих, зэрэгцүүлж тавьсан гимнастикийн сандал дээр тулалтаас урагш, арагш шилжих, ардаа тулж суусан байдлаас хөлөө шулуун өргөж 10 сек өнцөг барихдаа бие биенээ хүндэлж, бусаддаа саад болохгүйгээр хамтран гүйцэтгэх
- 2.1з. Хэрэгсэлтэй ба хэрэгсэлгүй дасгалаар уян хатны чадавхаа хөгжүүлэх
- 2.1и. Янз бүрийн байрлалаас шагайг няслан 40-60 см зайд буй шагайг онож уян хатан, хөдөлгөөний эвслээ сайжруулах, шагай няслах, морь уралдуулах, шагай таалцан тоглохдоо шударгаар өрсөлдөн тоглоомын дүрмийг хэрэгжүүлэх
- 2.2. АЛХАХ, ГҮЙХ
- 2.2а. Жагсаалын алхаа, энгийн алхааны ялгааг таних, ангиараа жагсаж алхах шаардлагыг биелүүлэх
- 2.2б. Гараа нугалан урагш-хойш савж, 200-300 м зайд хурдтай алхаж харуулах
- 2.2в. Чиглэлээ өөрчлөн хэрж ба тэмдэгтийг сүлжин алхах, гүйх, хөлөө солибон хажуугаараа хурдтай алхах, байрандаа өвдөг өндөр өргөн гүйж харуулах
- 2.2г. Мэдэгдэж буй дохиогоор гараанаас гарч, шулуун замд 20 м зайд дээд хурдаар, 20-25 м зайд 2-3 удаа давтан гүйж харуулах
- 2.2д. Гимнастикийн сандал дээгүүр гүйх, бөмбөг, урт сандал зэрэг саадыг давах, 15 см өргөн зурвас дундуур хурдтай гүйх зэргээр гүйхдээ өөрийн хөдөлгөөнөө удирдан, хүчээ оновчтой хуваарилах

- 2.2е. 400 м зайг туулахдаа алхаа ба зөөлөн гүйлтийг хослуулан ашиглах
- 2.3. **ҮСРЭХ ХАРАЙХ**
- 2.3а. Резин давж үсрэх ба дээсдэж тоглохдоо байрандаа нэг хөл дээр үсрэх чадвар болон тоглоомын дүрмийг ашиглах, хөлийн хүч болон хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх
- 2.3б. Гүйлтээс хол харайх аргыг хэрэгжүүлэн, 6-8 м зайнаас гүйж, нэг хөлөөр түлхэн уртад 1.5-2 м-ээс хол харайж үзүүлэх
- 2.3в. Гүйлтээс үсэрч 150-160 см өндөрт дүүжилсэн зүйлд нэг гараар хүрэх ба 20 см өндөр саадыг давж үсрэх, 30-40 см өндөр тавцан дээр хоёр хөлөөр үсэрч гараад, үсрэн бууж харуулах
- 2.3г. Нэг ба хоёр хөл дээрээ урагш, хажуу тийш, арагш үсэрч явах, түлхэлт савалт хосолсон дасгалыг ашиглан хөлийн хүч ба уян хатныг хөгжүүлэх
- 2.3д. Байрнаас уртад 80-95 см-ээс хол харайж харуулах
- 2.4. **ШИДЭХ, ДАМЖУУЛАХ**
- 2.4а. Нэг ба хоёр гараар жижиг бөмбөгийг шидэж, өнхрүүлэн 2-3 м зайд буй байг онож харуулах, орон зайн баримжаа, хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх
- 2.4б. Дунд зэргийн бөмбөгийг байрандаа нэг гараар залалт гүйцэтгэх
- 2.4в. Дунд зэргийн бөмбөгийг 2 м зайнаас оновчтой дамжуулахдаа нэг ба хоёр гараар дамжуулах аргыг ашиглах
- 2.4г. 100-150 гр жинтэй жижиг бөмбөгийг байрнаасаа нэг гараар хол шидэж харуулах
- 2.4д. Гарын хүч, шидэх чадвараа хөгжүүлэхдээ байрнаасаа янз бүрийн байдлаас бөмбөгийг хол шидэх аргыг ашиглах

III АНГИ

- 3.1. **АХУЙН ХЭРЭГЦЭЭТ ДАСГАЛ**
- 3.1а. Нэг цуваанаас хоёр цуваанд жагсах, тоолсон тоогоороо нэг эгнээнээс гурван эгнээнд шилжих, заал талбайн төв рүү хоёроор орох, дороо алхалтаас баруун, зүүн тийш эргэх, цуваа жагсаалаар алхаж харуулах
- 3.1б. Багшийн тусламжтайгаар өөрийн биеийн өндөр ба жинг хэмжих, өсөлтөө тодорхойлох
- 3.1в. Удаан сууснаас чилж ядарвал алжаал тайлах цогц дасгалыг ашиглах
- 3.1г. Гар, хөл, их биеийн хөдөлгөөн хосолсон шинэ дасгал, богино дээстэй, зөөлөн бөмбөгтэй, саваа модтой, цацагтай дасгалыг ганцаар болон хосоор гүйцэтгэх
- 3.1д. Дүүжигнэлтээс хөлөө нугалан өргөж өнцөг барих, гараа нугалан дүүжигнэх, их биеэ савах дасгалыг гүйцэтгэх
- 3.1е. Тэнцвэрийн чадавхаа сайжруулахдаа жижиг тавцан дээр нэг хөлөөрөө зогсох, үсэрч 180° эргэн, тэнцвэрээ хадгалж буух, бие биенийхээ тэнцвэрийг алдагдуулах хөдөлгөөнт тоглоомыг ашиглах
- 3.1ж. Гар, их бие, хөлийн хүчийг хөгжүүлэхдээ 700-800 г жинтэй хүндрүүлэгчийг ашиглах
- 3.1з. Хосоороо сунгалтын дасгал гүйцэтгэхдээ нөхөртөө туслах, аюулгүй байдлаа хангах аргыг хэрэгжүүлэх
- 3.1и. Шагайн тоглоомын дүрмийг өөрийн үгээр тайлбарлах, биеийн тэнцвэр, хөдөлгөөний эвсэл, уян чадавхаа хөгжүүлэхдээ хэвтээ, суугаа, зогсоо байдлаас дурын аргаар шагайг няслах, шүүрэх дасгал, тоглоомыг ашиглах
- 3.2. **АЛХАХ, ГҮЙХ**
- 3.2а. Зөв гүйж сурахдаа нарийн зурвас дээгүүр гарын янз бүрийн хөдөлгөөнтэй алхах, гүйх дасгалыг ашиглах

- 3.2б. Вальс алхаа ба гимнастикийн сандал дээрх саадыг давж алхах аргыг харуулах
- 3.2в. Уралдан гүйж тоглохдоо чиглэлээ өөрчлөн хурдтай гүйх чадвараа ашиглах
- 3.2г. Санамсаргүй дохиог ялгаж, уг дохиогоор ойрхон зайд огцом хурдтай гүйж харуулах
- 3.2д. Гүйлтийн хурдаа хөгжүүлэхдээ тус тусын замаар 30 м зайд дээд хурдаар гүйх дасгалыг ашиглах
- 3.2е. 500 м зайг туулахдаа алхаа ба зөөлөн гүйлтийг хослуулан ашиглах
- 3.3. **ҮСРЭХ ХАРАЙХ**
- 3.3а. Дээш ба урагш үсэрч харайхын ялгааг биеийн үйлдлээр үзүүлэх, тодруулах, үсрэлтийн дасгал, тоглоомын ач холбогдлыг эргэн санах
- 3.3б. Байрнаас уртад 95-105 см-ээс хол харайж харуулах
- 3.3в. 8-10 м зайнаас гүйж, нэг хөлөөр түлхэн, уртад 2 м-ээс хол харайж үзүүлэх
- 3.3г. Дээс, резин, бөмбөг ашиглан үсрэх, өндөр тавцан дээр зогсоод үсэрч эргэх дасгал, тоглоомоор хөлийн түлхэлт, савалтыг сайжруулах
- 3.3д. Гүйлтээс нэг хөлөөр түлхэн, 160-170 см өндөрт дүүжилсэн зүйлд нэг гараар хүрч харуулах
- 3.4. **ШИДЭХ, ДАМЖУУЛАХ**
- 3.4а. Шидэлтийн дасгалыг гүйцэтгэхдээ жижиг цагариг, урт богино жад, цаасан саваа, тавганцарыг барих ба шидэх аргуудыг хэрэгжүүлэх
- 3.4б. Том бөмбөгийг байрандаа ба алхалтаас залж харуулах
- 3.4в. Жижиг, том бөмбөгөөр 2-5 м зайд буй байг онож, орон зайн баримжаа, хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх
- 3.4г. Том бөмбөгийг хоёр гараар хана руу шидээд 360 градус эргэн барих, 3 м орчим дээш шидээд алдалгүй барин авч харуулах
- 3.4д. Тоглохдоо том бөмбөгийг бие бие рүүгээ дамжуулах аргыг ашиглах
- 3.4е. 150 гр жинтэй бөмбөгийг алхалтаас нэг гараар хол шидэж харуулах

IV АНГИ

- 4.1. **АХУЙН ХЭРЭГЦЭЭТ ДАСГАЛ**
- 4.1а. Командаар нэг эгнээнээс гурван эгнээнд жагсах, заал талбайн төв рүү гурваар орох, алхалтан дундаа баруун, зүүн тийш эргэх, цуваа жагсаалд баруун, зүүн мөр түрүүлж алхах жагсаалын хувиралтыг гүйцэтгэх
- 4.1б. Биеийн тамирын хичээлийн үед мөрдөх аюулгүй байдлын дүрмийг хэрэгжүүлэх, биеийн жин, өндрийг хэмжих аргыг ашиглан өөрийн өндөр, жингээ тодорхойлох
- 4.1в. Хөдөлгөөний эвсэл ба гарын хүчээ хөгжүүлэхдээ гимнастикийн саваатай цогц дасгал, янз бүрийн хэмжээний алчууртай дасгалыг багаараа хамтран гүйцэтгэх, үзүүлэх тоглолтод оролцох
- 4.1г. Хэвлийн булчингийн хүчээ хөгжүүлэх дүүжигнэлтээс хөлөө шулуун өргөж, буулгах дасгалыг ашиглах
- 4.1д. Тодорхой хугацаанд гурван цэгийн ба далан дээр зогсолтыг гүйцэтгэх, урагш ба арагш өнхрөлттэй хослуулан эвлүүлэг болгон хийж харуулах
- 4.1е. Зэрэгцүүлж тавьсан дамжуурга буюу нам савлуурт тулалтаас гараа зөөн, урагш ба арагш шилжилт гүйцэтгэх, 800-1000 г жинтэй гантельтай дасгалаар хүчийг хөгжүүлэх
- 4.1ж. Уян хатнаа хөгжүүлэхдээ туслалцаатайгаар босоогоос нуман тулгуур (мост), хөлөөрөө бүтэн төөлж (шпагат) суух сунгалтын дасгалыг хосоороо болон хэд хэдээрээ хамтарч гүйцэтгэх

- 4.1.3. Шагай няслах, морь уралдуулах, шагай шүүрч тоглохдоо шударгаар өрсөлдөн тоглоомын дүрмийг хэрэгжүүлэх
- 4.2. АЛХАХ, ГҮЙХ
 - 4.2a. Янз бүрээр алхах чадвараа сайжруулан, 300-400 м зайд хурдтай алхаж харуулах
 - 4.2б. Өвдөг өндөр өргөж гүйх, хөлөөс хөлд үсрэх, шилбээр арагш савж гүйх зэрэг гүйлтийн сонгомол дасгалыг техникийн дагуу гүйцэтгэх
 - 4.2в. 10-15 м хүртэл ойрхон зайд гүйхдээ гүйх чиглэл ба хурдаа огцом өөрчлөх
 - 4.2г. Шулуун замд 40 м зайд дээд хурдаар 3-4 удаа давтан гүйж харуулах
 - 4.2д. Охид 500 м, хөвгүүд 600 м зайг туулахдаа алхаа ба зөөлөн гүйлтийг хослуулан ашиглах
- 4.3. ҮСРЭХ ХАРАЙХ
 - 4.3a. Үсрэлт харайлтын дасгал хийх үед аюулгүй байдлын дүрмийг хэрэгжүүлэх
 - 4.3б. Хоёр хөлөөр түлхэн модон морь, тавцан дээр тулж явган суух, суултаас хотойлттой үсэрч буух техникийг гүйцэтгэх
 - 4.3в. Ташуу гүйлтээс нэг хөлөөр түлхэн, хөвгүүд модон морь, охид 60 см өндөр тавцан дээр гарч, гараа ардаа тулан сууж харуулах
 - 4.3г. Үсэрч, харайх дасгал, тоглоомоор хөлийн түлхэлтийн хүч, хурд, хөдөлгөөний эвслийг хөгжүүлэх
 - 4.3д. Гүйлтээс нэг хөл дээр дэгдэж үсрэн 10 м зайг туулах, гүйлтээс түлхэн 40-50 см өндөр саадыг давах, 60-80 см өндрөөс үсэрч зөөлөн буух, 170-190 см өндөрт өлгөсөн зүйлд нэг гараар хүрэх, байрнаас уртад 100-125 см харайх нормыг биелүүлэх
 - 4.3е. 10-12 м зайнаас гүйн уртад 150-200 см хол харайж харуулах
- 4.4. ШИДЭХ, ДАМЖУУЛАХ
 - 4.4a. Волейболын бөмбөгийг шидэх болон шилжилтээс дамжуулах аргаар хурд-хүчээ хөгжүүлэх
 - 4.4б. Сагсан бөмбөгийг янз бүрийн бай руу дамжуулах, дамжуулж тоглохдоо оновчтой аргыг сонгох
 - 4.4в. Хүчээ хөгжүүлэхдээ 600-800 гр жинтэй чихмэл бөмбөгийг байрнаас, 150 гр жижиг бөмбөгийг гүйлтээс хол шидэж харуулах
 - 4.4г. Хөл бөмбөгийг хөлөөрөө өнхрүүлэх, тогтоох аргуудыг ашиглах
 - 4.4д. Жижиг бөмбөгөөр 2-5 м зайд буй байг онож, орон зайн баримжаа, хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх, үнэлэх

V АНГИ

- 5.1. АХУЙН ХЭРЭГЦЭЭТ ДАСГАЛ
 - 5.1a. Заал, талбайн төв рүү дөрвөөр орох, алхалтан дунд эргэлтийг гүйцэтгэх
 - 5.1б. Нөхөдтэйгээ хамтран өөрийн биеийн өндөр ба жин, цээжний тойргийг хэмжих, өсөлтөө тодорхойлох
 - 5.1в. Хүчээ хөгжүүлэхдээ дүүжигнэлтээс болон тулж хэвтсэн байдлаас сунаих, 800 г жинтэй гантельтай дасгалыг ашиглах
 - 5.1г. Хөтлөлцөн зогссон байдлаас болон хосоороо урагш өнхрөх, акробатикийн дасгалыг эвлүүлэг болгон гүйцэтгэх
 - 5.1д. Биеийн ерөнхий хөгжлийн гимнастикийн сандалтай дасгалыг гурвуулаа, дөрвүүлээ хамтран гүйцэтгэх
 - 5.1е. Янз бүрийн байдлаас шагай няслах, шүүрч тоглох дүрмийг хэрэгжүүлэх

- 5.2. АЛХАХ, ГҮЙХ
- 5.2а. Спорт алхаагаар 100-200 м зайд хурдтай алхаж харуулах
- 5.2б. Дохиогоор гараанаас гарах чадвараа ашиглан, босоо гараанаас ба тулж тонгойсон байдлаас 50 м зайд дээд хурдаар гүйж харуулах
- 5.2в. Янз бүрийн чиглэлд алхаж ба гүйлтээс сагсан бөмбөгийн залалт гүйцэтгэх
- 5.2г. Өнхөрч буй хөл бөмбөгийг хөөж гүйцэх, хурдтай гүйх тоглоом ба давтан гүйлтээр хурд, тэсвэрээ хөгжүүлэх
- 5.2д. Холын зайд жигд гүйх аргыг ашиглан, 1000 м зайд жигд хурдаар гүйж үзүүлэх
- 5.3. ҮСРЭХ ХАРАЙХ
- 5.3а. Гүйлтээс уртад харайх аргыг эргэн санаж, уртын харайлтын техникийг 4 хэсэгт хувааж тайлбарлах, гүйлтээс уртад 200-250 см хол харайж харуулах
- 5.3б. Гүйлтээс өндөрт харайх аргыг эргэн санаж, өндрийн харайлтын техникийг 4 хэсэгт хувааж тайлбарлах, гүйлтээс өндөрт 60-80 см харайж харуулах
- 5.3в. Дээсдэж тоглохдоо эргүүлж буй дээсэнд ганцаараа ба багаараа орж үсрэн, дүрмийг хэрэгжүүлэх, хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх
- 5.3г. Гүйлтээс 60-80 см өндөр тавцан дээр хоёр гараар тулан, хөл салгаж харайн саадыг давж харуулах
- 5.3д. Өндрөөс үсэрч буунгуут 20-30 см өндөр тавцанд үсэрч гарах, хөлөөс хөлд үсрэн 20 м зайг туулах, нэг хөл дээр дэгдэж үсрэн 15 м зайг туулах, байрнаас уртад 110-130 см харайх нормыг биелүүлэх
- 5.4. ШИДЭХ, ДАМЖУУЛАХ
- 5.4а. Хөл бөмбөгийг шагайн дотор талаар өшиглөх, өнхөрч ирсэн бөмбөгийг хөлийн улаар тогтоох техникийг гүйцэтгэх
- 5.4б. Волейболын бөмбөгийг хоёр гараар шидэж тор давуулахдаа гар-мөрний хүчээ ашиглах
- 5.4в. 1.5 м өндөр бай руу жижиг бөмбөгийг, 2-2.5 м өндөр бай руу сагсан бөмбөгийг оновчтой шидэх үзүүлэлтээ ахиулах
- 5.4г. Сагсан бөмбөгийг цээжний орчмоос хоёр гараар дамжуулах техникээ сайжруулж, 2-3 м зайнаас цээжний орчмоос хана руу дамжуулан шаланд ойлгон барьж авах аргыг ашиглах
- 5.4д. Хурдтай гүйлтээс жижиг бөмбөгийг хол шидэж харуулах
- 5.4е. Жижиг бөмбөг шидэлтийн тэмцээнд оролцож, тэмцээний дүрмийг биелүүлэх

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

Бага боловсролын биеийн тамирын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй нь дараах онцлогтой байна.

- Жагсаалын хувилбарыг гүйцэтгэх, ашиглахдаа нэгдүгээр ангид командлах аргыг хэрэглэхгүй бөгөөд хоёрдугаар ангиас багш команд өгч эхэлнэ.
- Ихэвчлэн дуурайх аргаар хөдөлгөөний үйлдлийг гүйцэтгэх боловч сурагч өөрөө бодох, харилцан ярилцах, алдааг хэлэлцэх боломж олгож, нөхцөл бүрдүүлэхэд анхаарна.
- Аль ч агуулгыг хэрэгжүүлэхдээ тоглоомыг өргөн ашиглана. Тиймээс хөдөлгөөнт тоглоом тоглоход хүүхэд бүрийн бие бялдрын хөгжлийн онцлогийг харгалзан тоглоомын дүрмийг өөрчилж, ачааллыг тохируулна.
- Дасгалын техник буюу тухайн дасгалыг зөв гүйцэтгэх чадвар эзэмшүүлэхдээ баримжаалах (шалан дээрх талбайн шугам, өндөрт татсан хэц, тодорхой зайд байрлуулсан тэмдэгт гэх мэт) зүйлсийг хэрэглэгдэхүүн болгож ашиглана.

- Хүүхдийн хөдөлгөөний чадварт гарч буй ахиц өөрчлөлтийг мэдрүүлэхийн тулд мэргэжлийн багаж хэрэгслээр үзүүлэлтийг хэмжих, өмнөх үзүүлэлттэй нь харьцуулах, ахицаа тодорхойлж хэлэх зэрэг үйл ажиллагааг явуулна.
- Биеийн тодорхой бүлэг булчинд ачаалал өгөх дасгалыг олон удаа, 5-6-аас дээш цагийн хичээлээр давтахгүй байхаар төлөвлөнө.

3.2. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

- Бага ангийн, ялангуяа нэгдүгээр ангийн биеийн тамирын хичээлийг бусад ангиас тусад нь жижиг талбайтай, зориулалтын хэрэглэгдэхүүн, зөөлөн дэвсгэр бүхий заал танхимд явуулбал зохино. Хэрэв ийм боломжгүй бол сургуулийн биеийн тамирын зааланд бага ангийг ахлах, дунд ангитай нийлүүлэхгүйгээр хичээлийн хуваарийг зохиох шаардлагатай. Гадаа биеийн тамирын талбай нь эрүүл ахуйн шаардлага болон аюулгүй байдлыг хангасан байх ёстой.
- Өглөөний цогц дасгал, алжаал тайлах дасгалын зурагтай тараах материал, хүүхдийн бие бялдрын хөгжил ба чийрэгжилтийн үзүүлэлтийг бичсэн хуудас, тэдгээрийг ахиулах арга зүйн бичил зөвлөгөө зэргийг хүүхдийн насны онцлогт тохирсон хэл найруулгаар бичиж, хичээл дээр ашиглахаас гадна эцэг эх, асран хамгаалагчдад өгч хичээлийн бус цагаар гэртээ хэрэгжүүлэх даалгавар байдлаар ашиглана.
- 1-3 дугаар ангид том, дунд, жижиг хэмжээний, хийтэй янз бүрийн бөмбөгийг ашиглах бол 4-5 дугаар ангид сагсны, волейболын, хөл бөмбөгүүдийг хэрэглэнэ.
- Гарын доорх материалаар хийсэн сургалтын хэрэглэгдэхүүн нь аюулгүй байдлыг хангахуйц байхыг анхаарна. Жишээ нь: саадыг давж харайхад картон цаасаар саад хийх, цаасан саваа, нарийн резин, матрас зэргийг заавал ашиглана.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилт

- А. Мэдлэг, ойлголт
- Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар
- В*. Хандлага

* Сурагчийн хандлагыг ажиглалт, ярилцлага, рубрик зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Мэдлэг ойлголт	А1. Биеийн тамирын хэл, нэр томъёо, тэдгээрийн хэрэглээ
Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар	Б1. Өөрийн бие бялдрын хөгжлийн түвшинг тодорхойлох, сэтгэгдлээ илэрхийлэх байдал Б2. Биеийн ерөнхий хөгжлийн дасгалыг гүйцэтгэх байдал Б3. Өдөр тутмын амьдралд хэрэгцээт хөдөлгөөний техникийг зөв гүйцэтгэх байдал Б4. Төрөл бүрийн дасгал гүйцэтгэхдээ аюулгүй байдлаа хангах, нөхөддөө туслах байдал
В*. Хандлага	В1. Биеийн тамирын дасгалаар хичээллэх хүсэл сонирхол В2. Биеийн тамирын хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагааны оролцоо, идэвх

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
А. Мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгавар	30%
Б. Мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх даалгавар	70%

АНГЛИ ХЭЛ

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь англи хэлээр өдөр тутмын сэдвийн хүрээнд тодорхой эх сонсож ойлгон, санаа бодлоо энгийн, богино өгүүлбэрээр илэрхийлж, гадаад хэл сурах хүсэл эрмэлзэлтэй болно.

1.2. Зорилт

- 1.2.1. Тодорхой сэдвийн хүрээнд үгийн сан, хэлний хэрэглээний мэдлэг эзэмших;
- 1.2.2. Өөрийн болон гэр бүл, хүрээлэн буй орчны эд юмсыг энгийн, богино өгүүлбэрээр илэрхийлэх;
- 1.2.3. Англи хэл сурах хүсэл эрмэлзэлтэй болох.

Англи хэлийг эхлэн сурах, харилцах анхан шатны мэдлэг, чадвар эзэмшихдээ хэлний хэрэглээнд тулгуурлан сонсох, ярих чадварыг түлхүү, унших бичих чадварыг тодорхой хүрээнд эзэмшин хэл сурах арга барилд суралцана.

Чадвар	V анги
Сонсох - бусдыг хүндэтгэх, хүлээцтэй хандах	- Энгийн зааварчилгааг ойлгож түүний дагуу зөв ажиллаж, дасгал даалгаврыг гүйцэтгэх - Сэдвийн хүрээнд богино эхийн гол болон туслах санаа, энгийн хүүрнэл болон асуудлыг ойлгох, энгийн ярианы агуулгыг тааварлах
Ярих - өөрийгөө илэрхийлэх - бусадтай хамтрах - тохирсон үг хэллэг, өгүүлбэрийн бүтцийг ашиглан харилцах	- Өөрийн тухай болон хүрээлэн байгаа эд юмсыг энгийн, богино өгүүлбэрээр илэрхийлэх, асуулт асуух - Хосоор, бүлгээр, ангиар ажиллахад өөрийн хувь нэмрээ оруулах, хамтран ажиллах, ярилцах
Унших - мэдээлэлтэй ажиллах, хамтран ажиллах,	- Үсэг, авиа, авианы нийлэмжийг таних, - Үзсэн үг хэллэг, өгүүлбэрийг таних, ялгах - Энгийн үг хэллэг, өгүүлбэрийг харааны уншлагаар унших - Сэдвийн хүрээнд танил үг хэллэг, өгүүлбэрийн утгыг уншиж ойлгох - Энгийн зурагт толь бичгийг ашиглан унших
Бичих - тохирсон үг хэллэг ашиглан бичгээр харилцах	- Сэдвийн хүрээнд судалсан хүн, газар орон, эд юмсыг заасан үгсийг бичих - Танил үг хэллэг, өгүүлбэрийг зөв бичих
Хэлний хэрэглээ	- Тодорхой сэдвийн хүрээнд нэр үгийн ганц ба олон тоо, нэр хавсрал, төлөөний үг, асуух үг, үйл үгийн энгийн цаг, зарим угтвар үгийг хэрэглэх

ХОЁР. АГУУЛГА

V АНГИ

СОНСОЖ ОЙЛГОХ /LOW A1/

- 5.L1. Ангид хэрэглэх богино, энгийн зааварчилгааг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэгтэй сонсож ойлгох
- 5.L2. Хувийн мэдээллийг лавлах энгийн асуултыг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэгтэй сонсож ойлгох

- 5.L3. Энгийн асуултыг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэгтэй сонсож ойлгох
- 5.L4. Энгийн ярианаас гол санааг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэгтэй сонсож ойлгох
- 5.L5. Энгийн ярианаас туслах санааг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэгтэй сонсож ойлгох
- 5.L6. Энгийн ярианаас хам сэдвийн агуулгыг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэгтэй таамаглах
- 5.L7. Богино хэмжээний хүүрнэлийг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд сонсож ойлгох

ЯРИХ /LOW A1/

- 5.S1. Хувийн мэдээллийг энгийн хэлбэрээр илэрхийлэх
- 5.S2. Хувийн мэдээлэл, ангийн дэгийн талаар тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд асуулт асуух
- 5.S3. Ангийн эд юмс, үйл ажиллагаа, дэгийн талаар энгийн үг, хэллэг, өгүүлбэр ашиглан тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд ярих
- 5.S4. Ангийн дэг, өдрийн дэглэмийн талаарх үндсэн асуултад дэлгэрэнгүй өгүүлбэрээр хариулах
- 5.S5. Энгийн үг хэллэг ашиглан эд юмс, хүнийг дүрслэн ярих
- 5.S6. Хосоор, бүлгээр, ангиар ажиллахад тохиромжтой үг хэллэгийг ашиглах
- 5.S7. Үндсэн мэдээллийн талаар тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд харилцан ярилцах

УНШИХ /WORKING TOWARDS A1/

- 5.R1. Үгсийн авиа, сегмент, авианы нийлэмжийг ялгах, таних
- 5.R2. Түгээмэл хэрэглэгддэг үг өгүүлбэр дэх авиа, энгийн болон нийлмэл үсгийг ялгах, таних
- 5.R3. Танил эхээс үгийг шууд таньж унших
- 5.R4. Сэдвийн хүрээнд танил үг хэллэг, өгүүлбэрийн утгыг дахин уншиж ойлгох
- 5.R5. Энгийн зурагт толь бичгийг ашиглах

БИЧИХ /WORKING TOWARDS A1/

- 5.W1. Том, жижиг үсгийг зөв бичих
- 5.W2. Сэдвийн хүрээнд судалсан хүн, газар орон, эд юмсыг заасан түгээмэл үгсийг бичих
- 5.W3. Үсэг, үгийн хоорондох зайг зөв хуваарилж бичих
- 5.W4. Танил үг хэллэгийг зөв хуулан бичих
- 5.W5. Нэр, газар орон заасан үгийн том, жижиг үсгийг зөв хуулан бичих
- 5.W6. Зарим танил үгийг зааварчилгын дагуу үсэглэх
- 5.W7. Танил энгийн өгүүлбэрийн эцэст цэг тэмдэглэгээг бичих

ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ /LOW A1/

- 5.U1. Use common singular nouns, plural nouns [plural 's'] and proper names to say what things are
- 5.U2. Use numbers to count
- 5.U3. Use adjectives to describe person
- 5.U4. Use determiners a, the, some, any, this, these to indicate what/where something is
- 5.U5. Use interrogative pronouns which, what, where to ask basic questions Use Wh questions
- 5.U6. Use demonstrative pronouns this, that, these to indicate things
- 5.U7. Use have got + noun to describe and ask about possessions
- 5.U8. Use imperative forms of common verbs for basic commands, instructions

- 5.U9. Use common present simple forms [positive, negative, question] to give basic personal information
- 5.U10. Use common present continuous forms [positive, negative, question] to talk about what is happening now
- 5.U11. Use personal subject and object pronouns to give basic personal information
- 5.U12. Use basic prepositions of location and position at, in, near, next to, behind, in front of, on, to describe where people and things are Use prepositions of time on, in to talk about days and time Use with to indicate accompaniment Use for to indicate recipient

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

Бага ангийн сурагчдад англи хэлийг заахдаа дараах аргыг хэрэглэнэ. Үүнд:

- Хэл сурах, сургах коммуникатив арга зүйг голлон, сурагчдын нас бие сэтгэхүйд тохирсон сургалтын идэвхтэй аргууд (тулгуур дохио, зураг, хөгжим, дуут ба дүрст бичлэг, TPR / Total Physical Response/) -ыг түлхүү хэрэглэнэ.
- Бага ангийн сурагчийн сонирхол, хэлний түвшин, насны онцлогт тохирсон, тэдний судалж буй сэдэвтэй ойр, танил эх, хам сэдвийг ашиглан, дүрийн тоглолт, хэлэлцүүлэг, мэдээллийн технологид суурилсан үйл ажиллагаануудыг хичээлээр зохион байгуулна.
- Толь бичиг, өөрийн гэр бүлийн альбом хийх, баримлын шавраар амьтныг дүрслэх, зурах зэргээр сурагчдыг идэвхтэй, бүтээлч үйл ажиллагаанд татан оролцуулж, багаар болон хосоор хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ.

3.2. Сургалтын орчин

Англи хэлийг эхлэн сурах, харилцах анхан шатны мэдлэг, чадвар эзэмшихдээ хэлний хэрэглээнд тулгуурлан сонсох, ярих чадварыг түлхүү, унших бичих чадварыг тодорхой хүрээнд эзэмшин хэл сурах арга барилд суралцах учраас сурагчдын сонсох, ярих чадварыг хөгжүүлэх хүрээнд чөлөөтэй, өөртөө итгэлтэй, бие биеэ хүндэтгэн харилцах эерэг сэтгэл зүйн орчин, анги танхимд хэл сурах бичил орчинг бүрдүүлнэ.

3.3. Сургалтын хэрэглэгдэхүүн

Сонсох, ярих чадварыг хөгжүүлэх хүрээнд:

- Сурагчдын сонсох чадвар болон зөв дуудлагыг хөгжүүлэхүйц танин мэдэхүйн түвшинд тохирсон дуу, шүлгийн ТӨМ, CD, ажлын хуудас
- Зорилготой, анхааралтай сонсох чадварыг хөгжүүлэх төрөл бүрийн эхүүд, түүнд тохирсон даалгавар, асуултууд

Унших чадварыг хөгжүүлэх хүрээнд:

- Сэдвийн агуулгад тохирсон үзүүлэн таниулах материал, мэдээлэл технологийн хэрэгсэл, бодит материал, эх

Бичих чадварыг хөгжүүлэх хүрээнд:

- Төрөл бүрийн зориулалтай эхийн загвар (богино эх, шүлэг, оньсого, мэндчилгээ, танилцуулга)
- Сургалтын идэвхтэй үйл ажиллагааг дэмжсэн дасгал даалгаврууд

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

Үнэлгээнд дараах үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтална.

4.1. Үнэлгээний зорилт

А. Үгийн сан, хэлний хэрэглээ

Б. Сонсох, ярих чадвар

В*. Гадаад хэл сурах хандлага

* Сурагчдын хандлагыг ажиглалт, ярилцлага, рубрикээр үнэлнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Гадаад хэлний сургалтаар сурагчдын эзэмшвэл зохих сонсох, ярих, унших, бичих, хэлний хэрэглээний чадварыг үнэлэхдээ үнэлгээний зорилтод нийцсэн даалгавар боловсруулж суралцахуйн зорилтыг үнэлгээний шалгуур болгон үнэлнэ.

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Үгийн сан, хэлний хэрэглээ	A1. Үг хэллэг, холбоо үг, энгийн өгүүлбэр A2. Тодорхой сэдвийн хүрээнд үгийн сан, хэлний хэрэглээ
Б. Сонсох, ярих чадвар	Б1. Энгийн зааварчилгааг сонсоод ойлгох Б2. Сэдвийн хүрээнд эхийн гол болон туслах санааг ойлгох Б3. Энгийн эхийн хүрээнд агуулгыг тааварлах Б4. Энгийн дуу, шүлэг сонсох, дагаж дуулах, хэмнэлттэй унших Б5. Энгийн үг хэллэг, өгүүлбэрийг сонсоод, зөв тод дуудах Б6. Богино эхийг сонсон, өгөгдсөн даалгаврыг гүйцэтгэх Б7. Өөрийн тухай болон хүрээлэн байгаа эд юмсыг энгийн богино өгүүлбэрээр илэрхийлэх
В. Гадаад хэл сурах хандлага	В1. Хэл сурах сонирхол В2. Сонсох, ярих явцад хэлний хэрэглээний мэдлэгээ хэрэглэх, илэрхийлэх В2. Хосоор, бүлгээр, багаар хамтран ажиллах В3. Идэвх оролцоо, бүтээлч байдал

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
Үгийн сан, хэлний хэрэглээ	40% (сэргээн санах даалгавар 20%-иас ихгүй)
Сонсох, ярих чадвар	60% (үгийн сан, хэлний хэрэглээний даалгавар 20%-иас ихгүй)

ЭРҮҮЛ МЭНД

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь биеийн өсөлт, хөгжилтийн үед гарах өөрчлөлтийг мэдэж, эрүүл ахуйн зөв дэглэм баримтлан, өөрийгөө болон бусдыг хүндэлж, аюулгүй амьдрах арга ухаан, эрүүл зан үйлд суралцана.

1.2. Зорилт

Сурагч дараах мэдлэг эзэмшинэ.

- Хувийн эрүүл ахуй, бие бялдар, сэтгэцийн эрүүл мэндийн талаарх суурь мэдлэг, ойлголт
- Эрүүл харилцаа болон гэр, сургуулийн болон хүрээлэн буй орчны хүчин зүйлийн талаарх мэдлэг, ойлголт
- Хувийн эрүүл ахуй, хооллолт, хөдөлгөөн, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, ойлголт

Сурагч дараах чадвар эзэмшинэ.

- Хувийн зохион байгуулалттай, өөрийгөө ойлгож, хянах
- Бусдыг мэдэрч ойлгох, үр дүнтэй харилцах, бусадтай хамтран ажиллах
- Хөдөлгөөний ур, эв дүйтэй, нягт нямбай байх, аюулгүй амьдрах дүрмийг баримтлах

Сурагчид дараах хандлага төлөвшинө.

- Эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болох
- Бусдын үнэт зүйлийг хүндэтгэх
- Зохистой хэрэглээг эрхэмлэх
- Буруу зуршлаас татгалзах
- Гэр бүлийнхэн, мэргэжлийн байгууллага, ойр дотны хүнд хандах, тусламж хүсэх тэдний өмнө хариуцлага хүлээх


ХОЁР. АГУУЛГА

Бага боловсролын I-III ангид хүн ба орчин, биеийн тамирын хичээлийн агуулгад туссан дараах суралцахуйн зорилтуудаар дамжуулан эрүүл мэндийн мэдлэг, ойлголт, чадвар, хандлага төлөвшүүлэхэд анхаарна.

Сэдэв	Суралцахуйн зорилт
Хичээл: Хүн ба орчин	
Хувийн ариун цэвэр, эрүүл ахуй, өсөлт хөгжил	1,01.б. Тоглоом тоглох ба эрүүл ахуйн дэглэм сахих 1,04.г. Хичээл, амралтаа зөв зохицуулах, өдрийн дэглэм баримтлах 2,04.а. Биеийн бүтцийн нүдэнд харагдах хэсгийг тодорхойлох (нүд, сормуус, хөмсөг, хуруу, хумс гэх мэт) 2,04.б. Биеийн бүтцийн хэсгүүдийн үүргийг тайлбарлах (гарын хуруу юмыг барих, хөдөлмөр хийх, хөл тулгуур болох гэх мэт) 3,04.б. Биеийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлийг тайлбарлах

Хооллолт	3,04.в. Амьд биеийн үндсэн хэрэгцээг судлах (хоол тэжээл ба хооллох, хөдөлгөөн ба хөдөлгөөний ач тус) - Хүний хоол тэжээлийн зүйлсийг бүлэглэх, эрүүл хүнсний талаар хэлэлцэх - Хүний хоол хүнс, хөдөлгөөний хамаарлын учир шалтгааныг тайлбарлах
Өөртөө итгэх итгэл, сэтгэлийн хөдөлгөөнөө хянах	2,01.в. Тоглох үеийн дэгийг дагаж мөрдөх, хожиг хожигдож сурах, тэвчээртэй хүлээцтэй хандах чадвараа хөгжүүлэх
Харилцах, бусдыг мэдэрч ойлгох	1,02.в. Эцэг эх, ахмад хүмүүс, багш, найз нөхөдтэйгөө мэндэлж сурах 2,02.а. Найзаа таних, түүний эерэг зан чанарыг мэддэг болох 2,02.б. Найз нөхдөө хүндэтгэн харилцах 2,05.а. Гэр бүлийхнээ нэрлэх, 3 үеэ мэдэх (нагац, авга), тэднийг хүндэтгэх 3,02.б. Эцэг эх, ахмад хүмүүс, багш, найз нөхөдтэйгээ харилцан ойлголцож өөрийн хариуцлагыг ухамсарлаж, бусдыг хүндэтгэх
Гэр, сургуулийн орчин	1,07.а. Сургууль орчмын дуу чимээг судлах 1,05.б. Гэр байраа цэвэр байлгахад юу хийж чадахаа тайлбарлах, гэр бүлийн гишүүддээ туслах 2,07.а. Сургуулийн орчмын дуу чимээний эх үүсвэрийг тодорхойлох, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг тайлбарлах
Хичээл: Биеийн тамир	
Хувийн ариун цэвэр, эрүүл ахуй, өсөлт хөгжил	1,1.з. Өглөө бүр дасгал хийх хэрэгтэйг ойлгох 1,1.б. Өөрийн биеийн өндөр ба жингээ мэдэх 1,1.й. Биеийн зөв галбир ямар байхыг ойлгох 2,1.а. Эрүүл мэндээ сайжруулахын тулд биеийн тамирын олон төрлийн дасгалыг сурч тогтмол хийх хэрэгтэйг ойлгох 2,1.е. Өөрийн биеийн жин ба өндрийн өсөлтийн хэмжээг мэдэх 3,1.а. Дасгал, хөдөлгөөн бие эрхтэнд хэрхэн нөлөөлөх талаар ойлгох

Тайлбар: Суралцахуйн зорилтын дугаарлалтаас анги, сэдэв, суралцахуйн зорилтын дугаарыг тайлж уншиж болно. Тухайлбал:



IV анги

ЭМ01. ХУВИЙН ЭРҮҮЛ АХУЙ БА ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД

- 4,01.а. Сүүн ба байнгын шүдний бүтэц, үүргийг мэдэж, шүдээ буруу ургаж буй эсэхийг ажиглах, амны хөндийн эрүүл ахуйг сахих
- 4,01.б. Хоол идэхийн өмнө болон гараа бохирдсон тохиолдол бүрт аргачлалын дагуу зөв угааж хэвших
- 4,01.в. Бэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийн талаар мэдэх, дэглэм сахихын ач холбогдлыг тайлбарлах

ЭМ02. ХООЛЛОЛТ БА ХӨДӨЛГӨӨН

- 4,02.а. Өглөөний цайг тогтмол ууж, идэвхтэй хөдөлгөөн хийж хэвших
- 4,02.б. Хүнсний бүлгээ ялган тодорхойлж, хоол, хүнсийг сонгоход шошго ашигладаг болох

ЭМ03. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

- 4,03.а. “БИ” хэн бэ?, өөрийн давуу, сул талыг тодорхойлох
- 4,03.б. Өөрийн болон бусдын үнэт зүйлийг хүндэтгэх

ЭМ04. ХОРТ ЗУРШИЛ

- 4,04.а. Өдөр тутам хэрэглэдэг цахим хэрэгслийг зохистой хэрэглэж, илүү хэрэглээг хязгаарлах

ЭМ05. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД

- 4,05.а. Жендэр ба хүйсийн ялгааг танин мэдэж, хүн бүр жендэр болон хүйсээс үл хамааран ижил тэгш эрхтэй болохыг тайлбарлах
- 4,05.б. Эрэгтэй, эмэгтэй хүний бие махбодын ялгааг мэдэх, биеийн өсөлт хөгжлийг шилжилтийн насны үеийн бие бялдар, нийгэм, сэтгэл зүйн өөрчлөлттэй холбон тайлбарлах
- 4,05.в. Өөрийн хувийн орон зайг мэдэх, хянах чадвартай болох

ЭМ06. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АНХНЫ ТУСЛАМЖ

- 4,06.а. Ердийн болон хальтиргаа гулгаатай үед гэр, сургуулийн хооронд аюулгүй зорчих

V АНГИ

ЭМ01. ХУВИЙН ЭРҮҮЛ АХУЙ БА ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД

- 5,01.а. Хувийн эрүүл ахуй (гар угаах, усанд орох, бэлэг эрхтнээ угаах, зэргээр) сахих, халдварт бус өвчин болон бусад олон эрсдлээс сэргийлэх
- 5,01.б. Гэр, сургуульдаа эрүүл орчин бүрдүүлэх нь хувийн болон нийгмийн эрүүл мэндэд тустай болохыг тайлбарлах, өөрийн оруулах хувь нэмрийг тодорхойлох
- 5,01.в. Хувийн эрүүл ахуйг сахих талаарх монголын уламжлалт зан заншлыг ойлгох; хувь хүний эрүүл мэндэд гэр бүл, орчин хэрхэн нөлөөлдөг талаар тайлбарлах

ЭМ02. ХООЛЛОЛТ БА ХӨДӨЛГӨӨН

- 5,02.а. Зохистой хооллох зарчимд тулгуурлан хоол, хүнсний үндсэн шимт бодисыг харгалзан сонгох, зөв хадгалж, хэрэглэх
- 5,02.б. Биеийн өсөлтийг үнэлэх аргыг мэдэж, өөрт тохирсон идэвхтэй хөдөлгөөнийг сонгон тогтмол хийж хэвших

ЭМ03. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

- 5,03.а. Бусдыг анхааралтай сонсож, хүлээцтэй хандах

5,03.б. Өөрийн хүсэл мөрөөдлөө тодорхойлж, түүнд хүрэх төлөвлөгөө боловсруулах

ЭМ04. ХОРТ ЗУРШИЛ

5,04.а. Цахим хэрэгслийг хэтрүүлэн хэрэглэснээс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг хэлэлцэх

ЭМ05. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД

5,05.а. Гэр бүл, найз нөхөд, үе тэнгийнхний эрүүл харилцаа холбоог тодорхойлох, хөгжүүлэх, хадгалах

5,05.б. Жендэрийн тэгш бус байдал нь эрх мэдлийн ялгаатай байдалтай хэрхэн уялдаж байгааг тайлбарлах, гэр, сургууль, нийгэм дэх жендэрийн тэгш байдлыг дэмжих арга замыг үзүүлэх

5,05.в. Дээрэлхэл (цахим болон цахим бус)–ийг тодорхойлох, тэдгээрт өртөхгүй байх, хариу арга хэмжээ авах үр дүнтэй арга замыг үзүүлэх

ЭМ06. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АНХНЫ ТУСЛАМЖ

5,06.а. Ахуйн осол, байгалийн гэнэтийн үзэгдлийн үед бусдад туслах, яаралтай тусламж дуудах

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Ерөнхий боловсролын сургуулийн 4-5 дугаар ангийн сурагчдын насны онцлог нь логигоор сэтгэж эхлэх ба юмсыг хэд хэдэн шинж тэмдгээр нь ангилах, аливаа асуудлыг тунгаан бодох чадвартай байдагтай холбоотой. Бие махбодын хөгжлийн хувьд гар, хурууны бичих хөдөлгөөний дадал сайжирч, бие бялдрын хөгжил эрчимтэй явагдан, зарим хүүхдэд бэлгийн бойжилт эхэлдэг. Мөн сурагчдын оюун ухааны үйл ажиллагаа, сэтгэхүйн чадвар хөгжиж сурах арга барилд суралцаж эхэлдэг. Сэтгэл санааны хувьд тогтвортой, хамт олонч болох ба тоглоомын дүрмийг даган мөрдөх хүсэл эрмэлзэлтэй болсон байдаг. Тиймээс багш аргагүйгээ сонгохдоо дээрх онцлогийг харгалзан үздэг байх нь чухал.

Эрүүл мэндийн боловсрол олгох арга зүй нь оролцоонд суурилсан, практик шинжтэй байх нь чухал бөгөөд тухайн агуулгын хувьд хамгийн тохиромжтой байх арга зүйг сонгох нь зүйтэй. Тухайлбал, нэг хичээл дээр зөвхөн нэг аргыг сонгохоос илүү тухайн үйл ажиллагаа нь тодорхой мэдлэг эзэмшүүлэхэд чиглэсэн бол бие даан суралцах арга барилд сургах, харилцан яриа, үзүүлэн таниулах зэрэг аргыг сонгох, чадвар хөгжүүлэх бол хийж турших, дүрд тоглох, тодорхой жишээн дээр дүр бүтээх, шийдвэр гаргах, зөв буруугаа ярилцах зэрэг аргыг хэрэглэж болно. Харин хандлага төлөвшүүлэх хичээл дээр хийгдэх үйл ажиллагаа нь дүн шинжилгээ хийх, харьцуулах, харилцан ярилцах, төсөөлөн бодох, хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулахад чиглэсэн байна. Дараах тодорхой аргуудыг хослон хэрэглэх боломжтой. Үүнд:

- Үзүүлэн таниулах арга: Ойлголтын тойрог, Давуу ба сул талаа тодорхойлох, Мэдрэмж нээх арга;
- Мэдээлэлтэй ажиллах арга: Эхтэй ажиллах, Ажиглах арга, Юмс үзэгдлийг жиших;
- Хөгжөөнт тоглоомын арга: Та битгий уурлаарай, Намайг олоорой, Амьтныг дуурайх, Би хэн бэ, Та үүнийг мэдэх үү;
- Дүрд тоглох арга: “Үгүй” гэж хэлэх, Уналт, Татгалзах, Сонсохын ач холбогдол гэх мэт.

Мэдлэг бүтээх идэвхтэй сургалтын аргуудыг ашиглан сурагчдыг өөрсдөөр нь үнэлүүлэх, дүгнэлт хийлгэх, бие даан сэтгэн бодохуйг хөгжүүлэхэд түлхүү анхаарна. Өөрөөр хэлбэл, асуудлыг олон талаас нь харж дүн шинжилгээ хийж, сурах арга барилд сургах зорилготой

бөгөөд ингэснээрээ тэднийг хичээл дээр төдийгүй, амьдрал болон нийгэмд идэвхтэй хандах чадвартай болгоход туслах юм.

Багш сургалтын аргыг үр өгөөжтэй хэрэглэх дараах нийтлэг шаардлагыг мөрдөхөд анхаарна. Үүнд:

- Тухайн ангийн сурагчдын нас, сэтгэцийн онцлог, хөгжлийн ерөнхий түвшин, сурах чадавх, ангийн хамт олны төлөвшлийн онцлог, хэрэгцээ, сонирхол зэргийг харгалзан сургалтын аргаа сонгоно.
- Тухайн хичээлийн сэдэв, зорилго, зорилт, агуулгын багтаамж, цаг хугацаа зэргийг тооцно.
- Багш нар нэг аргыг байнга хэрэглэхээс зайлсхийж, олон янзын аргыг хослуулан хэрэглэнэ.
- Илүү бүтээлч байхын тулд багш өмнө нь хэрэглэж байсан аргыг өөр өөр нөхцөлд шилжүүлэн өөрчилж сургалтаа зохион байгуулна.

3.1. Багшлах стратеги

Багш оролцооны аргаар хичээлийг зохион байгуулахад дараах зарчим баримтална.

Хэрэгцээнд тулгуурласан байх: Эрүүл мэндийн боловсролд хувь хүний болон нийгмийн хэрэгцээг тооцох, үнэлэх явдал хамгийн чухал байр суурь эзэлнэ.

Судалгаанд суурилсан, шинжлэх ухааны онолын үндэслэлтэй байх: Сурагчдад өгөх мэдлэг, мэдээлэл нь зөвхөн судалгаанд суурилсан, онолоор батлагдсан үнэн зөв мэдээлэл байх

Хувь хүний үнэт зүйл, хандлага, итгэл үнэмшилд хандсан байх: Хүн бүр өөрийн гэсэн үзэл бодол, итгэл үнэмшилтэй байдгийг хүндэтгэж үзэх, өөрийнхөө үзэл бодлыг тулган зөв, буруу гэж үнэлэхгүй байх

Суралцах стратеги, заах арга, хэрэглэгдэхүүнийг оновчтой сонгох: Багш сурагчдын нас, сэтгэхүйн хөгжлийн үе шатад тохирсон үзүүлэн таниулах материал, муляж, бодит болон зурагт үзүүлэн, мультимедиа хичээл, компьютер, проектор зэрэг орчин үеийн техник хэрэгсэл ашиглан, сургалтыг үр дүнтэй, сонирхолтой арга, хэлбэрээр зохион байгуулахад анхаарна. Эрүүл мэндийн хичээлийг анги, том баг, жижиг баг, хосоор болон ганцаар ажиллуулах зэрэг хэлбэрээр зохион байгуулах нь илүү оновчтой байдаг.

Эрүүл мэндийн хичээлийг заах багш нь дараах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх шаардлагатай. Үүнд:

- Эрүүл мэндийн хичээлийг заах боломж, сонирхолтой байхаас гадна энэ чиглэлээр мэргэшсэн, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх,
- Эрүүл мэндийн шинжлэх ухааны үндэслэлтэй баримт мэдээ, онолын мэдээллийг баталгаат эх сурвалжаас авч ашигладаг байх,
- Хичээлд бэлтгэхдээ сурагчийн хийх үйл ажиллагаа талаас нь төлөвлөж, тухайн сэдэвтэй холбоотой гарч болох асуулт, түүний хариултыг урьдчилан бэлтгэдэг байх,
- Сурагчийн хэрэгцээ сонирхлыг төрүүлэх, сэдэлжүүлэхэд анхаарах, зарим сурагчийн ярилцахаас эмзэглэх асуудал байж болохыг анзаарах
- Сэдэв болон хичээл хоорондын залгамж уялдаа холбоог хангах,
- Сургалтын аргуудыг хослон хэрэглэж, хичээлдээ бүтээлчээр хандах, аль болох асуудлыг өөрсдөөр нь гаргуулж, шийдвэрлэх олон хувилбарыг гаргаж ярилцах
- Хичээлийн агуулгаа өдөр тутмын амьдралтай холбон зааж, хэвшүүлбэл зохих эрүүл зан үйлийг хичээлээс бусад цагаар эзэмшүүлэхэд анхаарах,

- Сурагчдаа судлан, тэдний нас, сэтгэхүйн болон орчны онцлог нөхцөл зэргийг харгалзан заах арга зүйгээ улам сайжруулахад анхаарах,
- Эрүүл мэндийн хичээлийн зарим агуулга хувь хүний нууцтай холбоотой тул тухайлан жишээ авахаас зайлсхийх, хувийн нууцыг хадгалахад анхаарах.

Суралцах стратеги, заах арга, хэрэглэгдэхүүн зэрэг нь соёл, уламжлал, зан заншлын онцлогийг харгалзсан байх. Жендэр, арьстан, угсаатан, шашин шүтлэг, нас, бие/сэтгэлийн чадвар, гадаад төрх, бэлгийн чиг баримжаа гэх мэт ялгаатай байдлыг харгалзсан байх ёстой.

Эрүүл мэндийн багшийн ёс зүйг эрхэмлэсэн байх: Эрүүл мэндийн хичээл нь бусад хичээлийг бодвол хүний хувийн асуудал, эмзэг мэдрэмтгий сэдвийг хөндөх учир дараах ёс зүйн хэм хэмжээг зайлшгүй мөрдвөл зохино. Үүнд:

1. Хувийн нууцыг хадгалах
2. Үзэл бодлоо тулгахгүй байх
3. Ялгаварлан гадуурхахгүй байх
4. Хувийн, дотно харилцаа үүсгэхгүй байх
5. Хувь хүний талаар тухайлан жишээ авахгүй байх

Энэ насны хүүхдүүд гэр бүл, аав, ээжтэйгээ илүү дотносож тэдний сургамж зөвлөгөөг хүлээн авдаг учраас эдгээр онцлогийг харгалзан бие даан сурах арга барилыг төлөвшүүлэхэд анхаарах хэрэгтэй. Үүний тулд багш эрүүл мэндийн хичээлийн даалгаврыг өгөхдөө шинэ мэдлэг, мэдээлэл, туршлага хуримтлуулах аргад суралцуулахуйцаар төлөвлөх хэрэгтэй. Үүнд:

- Аливаа эрсдэлт зан үйлийг арилгаж болох боломжит арга замыг олуулах,
- Эрсдэлт зан үйлээс гарч буй хор уршгийг таниулах,
- Татгалзах чадварыг илэрхийлэх жишээ баримт, тохиолдол дээр ажиллуулах,
- Үзэл бодлоо илэрхийлэх арга замыг нээж өгөх,
- Хувь хүнд учирч буй хор нөлөөний талаарх мэдээллийг цуглуулах, түүнээс гарах аргыг мэдүүлэх гэх мэт.

3.2. Суралцах стратеги

Энэ насны сурагчид орчноо байнга танин мэдэж, үе тэнгийнхэнтэйгээ харилцаж сурч, тэднээс сайн үнэлгээ авахыг хичээдэг. Сурагч дараах чадвартай болсон байна. Үүнд:

- Өөрийн бие махбод, сэтгэл санаанд гарах өөрчлөлтийг таньж мэдэх, улмаар түүнд дасан зохицох, сэтгэл зүйн бэлтгэлтэй болох,
- Багаар ажиллах,
- Багш болон үе тэнгийнхэнтэйгээ дотно харилцаж, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх,
- Аливаа зүйлийг сонирхон судлах, сурах хүсэл, тэмүүлэлтэй болох,
- Олж авсан мэдлэгтээ дүн шинжилгээ хийж, ижил болон өөр нөхцөлд хэрэглэх,
- Өөрийн болон бусдын сул талыг мэдэж, бусдадаа эергээр нөлөөлөх

3.3. Эрүүл мэндийн хичээлийн онцлог, сургалтын орчин

Эрүүл мэндийн хичээл нь сурагчдын өдөр тутмын амьдралд тохиолдох, биеийн өсөлт хөгжилтэй холбоотой олон асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг онцлогтой. Хүүхэд зөвхөн өөрийн сонирхол хэрэгцээнээс гадна найз нөхөд, харилцагчийнхаа сонирхол хэрэгцээг илүү

анхаардаг онцлогтойгоос гадна охид, хөвгүүдийн хүйсийн ялгаатай байдал олон зүйл дээр ажиглагддаг болохыг багш тооцох хэрэгтэй.

Эрүүл мэндийн хичээл нь эрүүл ахуйн шаардлага хангасан, материаллаг, үйлийн болон сэтгэл зүйн таатай орчинд хэрэгжих нь зайлшгүй. Иймээс сургалтын орчинд онцгой анхаарах хэрэгтэй. Тухайлбал:

1. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь хичээл буюу танхимын сургалтаас гадна хичээлээс гадуурх үйл ажиллагаа, нийгмийн амьдралд оролцохоос ихээхэн хамаардгийг анхаарч төлөвлөх,
2. Сургууль болон анги танхимын эерэг орчин бий болгоход анхаарч, хамтран суралцах соёл, сурагчдын сайн сайхныг дэмжих төлөвлөлт бүхий үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх,
3. Сурагч-сурагч, сурагч-багш гэсэн ижил төвшинд дарамтгүйгээр нэг нэгтэйгээ харьцах боломж бүрдүүлэхэд анхаарах,
4. Эрүүл мэндийн үйлчилгээ болон орчин нь сурагчийн танин мэдэхүй, сэтгэл хөдлөл-нийгэмшил болон бие бялдрын хөгжилд чухал үүргийг гүйцэтгэх тул эрүүл мэндийн үйлчилгээг дэмжих, сургуулийн орчны эрүүл ахуй, сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулахад анхаарах,
5. Сурагчид өөрсдийн сурах үйлийн үнэт зүйлийг үнэлэн дүгнэх, сургалтын болон сургалтын бус үйл ажиллагаанд оролцох сэдлийг өрнүүлэх,
6. Эцэг эх, сургуулийн хамт олон болон олон нийтийн төлөөлөл нь тухайн сургуулийн бодлого, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд санаачилга гарган, дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах,
7. Орон нутаг, сургуулийн нөөц боломж, байгаль, нийгэм, соёлын ялгаатай байдал зэргийг харгалзан үзнэ.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилт

Бага боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийн үнэлгээ нь сурагчийн эзэмших мэдлэг, ойлголт, чадвар, хандлага, зан үйлийн эзэмшилтийг илрүүлэхэд чиглэнэ. Бага ангид зөвлөмжид суурилсан дүнгийн бус үнэлгээг хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл, сурагчийг үнэлэхдээ юуг сайжруулах хэрэгтэй байгааг нь илрүүлэн яаж сайжруулах арга замыг нь зөвлөмжилнө.

Багш үнэлгээ хийхдээ сурагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадварын шалгуур үзүүлэлтийг урьдчилан тооцсон байна. Бага ангийн сурагчийг багшийн төсөөлснөөр агуулгаа бүрэн эзэмшээгүй тохиолдолд шууд сайн, муу гэх зэргээр дүгнэх нь тэдний идэвх, оролцоог бууруулах магадлалтай учраас мэдлэг, ойлголт, чадвар, хандлагыг үнэлэх шалгуур үзүүлэлт бүхий рубрик боловсруулан үнэлгээнд ашиглаж болно. Рубрик нь сурагчийн гүйцэтгэлийн янз бүрийн түвшинг үнэлэхэд ашигладаг багц шалгуур үзүүлэлт байна.

4.2. Үнэлгээний төрөл, арга, хэрэгсэл

Үнэлгээний төрөл: Өөрийн үнэлгээ, явцын үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ, үр дүнгийн үнэлгээ
Үнэлгээний арга, хэрэгсэл: Асуулт, ажиглалт, сэтгэгдэл, санал асуулга, дасгал даалгавар, бичгийн шалгалт, илтгэл, эсээ, бүтээл зэрэг байна. Мэдлэг үнэлэх тест нь үнэлгээний үндсэн хэлбэр байх боломжгүй. Харин чадвар, хандлагыг илрүүлэхэд чиглэсэн асуулга, ярилцлага,

илтгэл, эсээ, реферат бичүүлэх зэрэг нь илүү бодитой бөгөөд үр дүнтэй байх болно. Гэхдээ бага ангийн сурагчдын бичих, бичгээр илэрхийлэх чадвар харьцангуй сул байх талтай. Иймээс ярилцлага хийх, тайлбарлан яриулах, зураг зуруулах зэрэг аргыг ашиглаж болохын зэрэгцээ багш өөрөө ажиглалт, тандах судалгаа хийх байдлаар сурагчдад гарч буй ахиц өөрчлөлтийг үнэлэх боломжтой.

Явцын үнэлгээ

Багш хичээлийн явцад асуулт, дасгал даалгавар болон бусад үйл ажиллагааны гүйцэтгэлээр сурагчийн мэдлэг, чадварын ахиц өөрчлөлтийг илрүүлж, заах арга зүй, орчин хэрэглэгдэхүүнийг сайжруулахын зэрэгцээ, сурагчдад зөвлөн тусална.

Үр дүнгийн үнэлгээ

Улирал, хагас жил, жилийн эцэст санал асуулга, сэтгэгдэл, бичгийн шалгалт болон бусад үйл ажиллагааны гүйцэтгэлээс сургалтын зорилт хэр зэрэг биелсэн болон сурагчдын сурах арга барил, хандлага, зан үйл төлөвшилд дүгнэлт хийнэ.

